



# МОНГОЛ УЛСЫН ТӨРӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО

Судалгаа гүйцэтгэгч:	Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургууль, Нийгмийн ухааны салбар
Багийн ахлагч:	Ц.Болормаа, доктор (Ph.D), Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн профессор
Багийн судлаачид:	Б.Энхцэцэг, доктор (Ph.D), Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн дэд профессор Ч.Цогтбаяр, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн багш Б.Наранчимэг, БНХАУ-ын Жилиний их сургуулийн докторант
Санхүүжүүлэгч байгууллага:	НҮБ-ын Хүүхдийн сан

УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

Энэхүү тайлан нь судалгааг гүйцэтгэхэд бодлогын болоод санхүүгийн дэмжлэг үзүүлсэн аль нэг байгууллага, хувь хүний байр суурийг илэрхийлээгүй харин тайланг бичигчдийн судалгааны үр дүнд суурилсан санал дүгнэлт, сэтгэгдлийг илэрхийлж байгааг юуны өмнө хэлмээр байна. Тайлангийн зурган болон хүснэгтэн тоо мэдээллийг харуулсан дүрслэл, хэв маяг нь аль нэг улс, нутаг дэвсгэр, хот эсвэл бүс нутаг, засаг захиргааны байгууллага, хил хязгаарын талаарх ямар нэг байр суурийг илэрхийлээгүй болно.

## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....	5
ХҮСНЭГТ, ДИАГРАММ, ШИГТГЭЭ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	6
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	9
ХУРААНГУЙ.....	10
БҮЛЭГ 1: УДИРТГАЛ.....	13
1.1 Үндэслэл.....	13
1.2 Зорилго, зорилт.....	14
1.3 Судалгааны арга зүй.....	14
1.4 Судалгааны ач холбогдол, хязгаарлалт .....	15
БҮЛЭГ 2: ДЭЛХИЙН ХҮН АМЫН ТӨРӨЛТИЙН ХАНДЛАГА .....	16
2.1 Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин .....	16
2.2 Азийн улс орнуудын төрөлт, харьцуулалт.....	18
2.3 Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс.....	20
БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛСЫН ТӨРӨЛТИЙН ШИЛЖИЛТ.....	23
3.1 Монгол Улсын хүн амын өсөлт, бүтэц .....	23
3.2 Төрөлтийн шилжилтийн хандлага, ялгавартай байдал.....	24
БҮЛЭГ 4: ТӨРӨЛТӨД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ .....	30
4.1 Төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс: Бонгаарцын загварын шинжилгээ ....	30
4.2 Төрөлтийн түвшин ба темпо өөрчлөлт .....	33
4.2.1 Төрөлтийн ажиглагдсан ба темпо-зассан (ТНК*) түвшний харьцуулалт.....	33
4.2.2 Темпо нөлөөний хэмжээ (Tempo Effect Share) .....	35
4.2.3 Төрөлтийн өөрчлөлт дэх темпо ба квантум нөлөө .....	36
4.2.4 Kitagawa хоёр бүрэлдэхүүний шинжилгээ: Насны бүтэц ба төрөх зан төлөв .	37
4.3 Насны бүтэц ба оргил насны шилжилт .....	39
4.3.1 Төрөлтийн насны бүлгийн тархалт .....	39
4.3.2 Оргил (модал) нас ба темпо шилжилт.....	40
4.4 Төрөлтийн цаг хугацааны шинжилгээ .....	41
4.4.1 Үелрэл төрөлтийн нийлбэр коэффициентийн өөрчлөлт, чиг хандлага .....	42
4.4.2 Хугацааны болон үелрэл ТНК-ийн харьцуулалт харьцуулалт.....	42
4.5 Төрөлтийн талаарх ирээдүйн таамаглал.....	43
БҮЛЭГ 5: ТӨРӨЛТ, ГЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА.....	47
5.1 Төрөлтийн талаарх хандлага .....	47
5.2 Гэрлэлтийн талаарх хандлага .....	56
БҮЛЭГ 6: ТӨРӨЛТИЙН ТАЛААРХ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ .....	69

6.1 Дэлхийн улс орнуудын бодлого, арга хэмжээ.....	69
6.2 Монгол Улсын төрөлтийг дэмжих бодлого, арга хэмжээ.....	77
БҮЛЭГ 7: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	80
7.1 Дүгнэлт .....	80
7.2 Зөвлөмж .....	81
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	87
ХАВСРАЛТ А.....	90
ХАВСРАЛТ Б.....	93
ХАВСРАЛТ В.....	98

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад сүүлийн жилүүдэд хүн амын төрөлтийн түвшин тогтвортой буурч, гэрлэлт, гэр бүл, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хотжилт, амьдралын чанартай нягт уялдсан цогц хүн ам зүйн сорилтууд нэмэгдсээр байна. Төрөлтийн энэ өөрчлөлт нь зөвхөн хүн амын тоон өсөлтийн асуудал бус, харин эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжил, хүн амын нөхөн үржихүй, нийгмийн хамгааллын тогтолцоо, бүсчилсэн хөгжлийн бодлоготой шууд холбогдох стратегийн шинжтэй асуудал юм. Иймээс төрөлтийн хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэй, бодлогын шийдвэр гаргалтад чиглэсэн байдлаар гүнзгий судлах зайлшгүй шаардлага бий болсон.

“Монгол Улсын төрөлтийн шинжилгээ, бодлого” сэдэвт судалгааны ажил нь Монгол Улсын төрөлтийн түвшин, өөрчлөлтийн шалтгаан, бүрэлдэхүүн, нөхцөлийг тоон өгөгдөлд тулгуурлан шинжлэн дүгнэж, бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх боломжит шийдэл, чиглэлийг тодорхойлоход чиглэсэн болно. Судалгаанд олон улсын хүн ам зүйн орчин үеийн онол, арга зүйг ашиглаж, Монгол Улсын нөхцөл байдалд нийцүүлэн тайлбар, дүгнэлт хийснээр бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, судлаачид болон олон нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьсон юм.

Энэхүү судалгааг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлсэн Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, С.Зулпхар, Ерөнхий сайдын зөвлөх асан Ч.Болортуяа нарын бодлогын түвшний санал, зөвлөгөө нь судалгааны ач холбогдол, практик хэрэглээг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Түүнчлэн судалгаанд шаардлагатай албан ёсны статистик мэдээлэл, судалгааны өгөгдлийн сангаар хангаж, мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн ҮСХ-ны дарга Б.Батдаваа болон тус хорооны хэлтэс, нэгжийн хамт олонд гүн талархал илэрхийлье.

Судалгааны ажил амжилттай хэрэгжихэд эрдэм шинжилгээний байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлсэн МУИС-ийн ректор Б.Очирхуяг, мөн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хүүхдийн сан, тус сангийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан Д.Хүрэлмаа нарт талархал илэрхийлж байна. Эдгээр байгууллага, хувь хүмүүсийн дэмжлэг нь судалгааг бодлогын болон судалгааны өндөр түвшинд гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн билээ. Мөн судалгааг амжилттай гүйцэтгэхэд хамтран ажиллаж, санал зөвлөгөө өгсөн бусад бүх байгууллага, судлаач, мэргэжилтнүүдэд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэ судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмж нь Монгол Улсын хүн амын бодлого, төрөлтийг дэмжих бодлогын шинэчлэл, “амьдралын мөчлөгт суурилсан” бодлогын багцыг боловсруулах, салбар хоорондын уялдааг сайжруулах, бүс нутгийн онцлогт нийцсэн бодлогын шийдлийг тодорхойлоход бодитой хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм. Цаашлаад уг судалгаа нь хүн ам зүйн шилжилтийн өнөөгийн үе шатанд Монгол Улсад тулгамдаж буй сорилтыг илүү бодитой үнэлэх, урт хугацааны хөгжлийн бодлого, нийгэм-эдийн засгийн стратегитай уялдуулан шийдвэр гаргах шинжлэх ухааны үндэслэлийг бэхжүүлэхэд чухал эх сурвалж болно гэж үзэж байна.

МУИС-ийн судалгааны баг.

## ХҮСНЭГТ, ДИАГРАММ, ШИГТГЭЭ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 2.1 Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 25 жилээрх тоон өөрчлөлт
- Хүснэгт 2.2 Азийн улс орнуудын төрөлтийн түвшин, 1950-2025
- Хүснэгт 3.1 Төрөлтийн түвшин, НҮТС явагдсан онуудаар
- Хүснэгт 3.2 Төрөлтийн түвшин, хот, хөдөөгөөр, НҮТС явагдсан онуудаар
- Хүснэгт 3.3 Судалгааны өмнөх 3 жил дэх ТНК (15-49 нас), Монгол Улс
- Хүснэгт 4.1 Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн log утга болон өөрчлөлтөд эзлэх хувь, 2008-2023 онд
- Хүснэгт 4.2 Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн log утга болон өөрчлөлтөд эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2008-2023 онд
- Хүснэгт 4.3 ТНК-ийн өөрчлөлтийн Kitagawa задаргаа, сонгосон интервалаар, 1990-2024
- Хүснэгт 4.4 Үелрэл ТНК, эхийн төрсөн он ба нөхөн үржихүйн насаа гүйцээсэн байдлаар, 1960-1980 онд төрсөн эмэгтэйчүүдийн хувьд
- Хүснэгт 4.5 Тухайн хугацааны болон нэг үед төрсн үелрэлийн ТНК-ийн дундаж харьцуулалт ба темпо нөлөө, 10 жилийн интервалаар, 1990-2024
- Хүснэгт 4.6 Монгол Улсын төрөлтийн түвшний 2024-2050 оны таамаглал, 4 хувилбараар, НҮБ-ын тооцооллын дундаж хувилбартай харьцуулсан байдлаар
- Хүснэгт 4.7 Монгол Улсын төрөлтийн талаарх ирээдүйн түвшний 4 хувилбарын тооцооллын нөхцөл, төсөөлөл
- Хүснэгт 5.1 Монгол Улсын төрөлтийн тоо буурч байгаа талаарх мэдлэг
- Хүснэгт 5.2 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, хүүхэдтэй эсэх, гол шалтгаанаар
- Хүснэгт 5.3 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, хот, хөдөөгөөр, гол шалтгаанаар
- Хүснэгт 5.4 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, зарим насны бүлгээр, гол шалтгаанаар
- Хүснэгт 5.5 Төрөлтийн төсөөлөл: Эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх тохиромжтой дундаж нас
- Хүснэгт 5.6 Төрөлтийн төсөөлөл: Гэр бүлд зохимжтой гэж үзэж буй хүүхдийн дундаж тоо
- Хүснэгт 5.7 Төрөлтийн төсөөлөл: Хүсэмжит хүүхдийн тоо
- Хүснэгт 5.8 Хот, хөдөөгийн 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдээр, %
- Хүснэгт 6.1 Төрөлтийг дэмжих бодлогын багц, сонгонсон Төвийн Азийн орнуудаар
- Хүснэгт A1 ТНК ба quantum (темпо-зассан ТНК)-ийн харьцуулалт, темпо нөлөөний хэмжээ
- Хүснэгт A2 Бодит темпо-зассан ТНК\*-ийн квантум индекс% 5 жилээр, 1991-2024 (суурь он 1991)
- Хүснэгт A3 ТНК-ийн өөрчлөлтийн Kitagawa задаргаа, 50 жилийн интервалаар, 1990-2024
- Хүснэгт A4 Амьд төрсөн хүүхдийн тоо, насны бүлгийн тархалтын хувиар, 15-49 насны эмэгтэйчүүдийн 5 насны бүлгээр, 1990-2024

Хүснэгт Б1	Гэрлэх насны талаарх нийгэм, хүн ам зүйн бүлгүүдийн ялгаатай хүлээлт
Хүснэгт Б2	Гэрлэлтэд хандах хандлага
Хүснэгт Б3	Гэрлэлтэд тавигдах зайлшгүй шаардлагатай нөхцөлүүд
Хүснэгт Б4	Гэрлэлтийн талаарх хувь хүний шийдвэрт нөлөөлөх нийгмийн дарамт ба нөлөөлөл
Хүснэгт Б5	Гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэрт нөлөөлөх хувь хүний болон нийгэм-соёлын хүчин зүйлс
Хүснэгт В1	Төрөлтийг дэмжих бодлогын багц, сонгосон улс орнуудаар
Хүснэгт В2	Амьдралын мөчлөгт суурилсан бодлогын багцын бүтэц (загвар жишээ)

#### Диаграмм 2.1 Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс

Зураг 2.1	Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 1950-2023
Зураг 2.2	Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 1950-2023, бүс нутгаар
Зураг 2.3	“-стан” улсуудын төрөлтийн түвшин, 1950-2025
Зураг 2.4	Хүн ам зүйн шилжилтийн сонгодог онол
Зураг 3.1	Монгол Улсын хүн амын тоо, өсөлтийн хурд, 1918-2024
Зураг 3.2	Монгол Улсын хүн ам зүйн шилжилт, 1934-2024
Зураг 3.3	Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суварга, 1990, 2024 он
Зураг 3.4	Монгол Улсын Төрөлтийн нийлбэр коэффициент ба хүн амын бодлого, 1963-2010
Зураг 3.5	Монгол Улсын Төрөлтийн нийлбэр коэффициент
Зураг 3.6	Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, НҮТС явагдсан онуудаар
Зураг 4.1	Төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс, Бонгаарцын загвараар, НҮТС явагдсан онуудаар
Зураг 4.2	Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн нөлөөлж буй хувь, Бонгаарцын загвараар, НҮТС явагдсан онуудаар
Зураг 4.3	Төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс, Бонгаарцын загвараар, хот, хөдөөгөөр, НҮТС явагдсан онуудаар
Зураг 4.4	Ажиглагдсан ТНК ба темпо-зассан ТНК*-ийн харьцуулалт, 1990-2024
Зураг 4.5	Жил тутмын ТНК дэх темпо өөрчлөлтийн нөлөөний хувь хэмжээ, 1990-2024
Зураг 4.6	Төрөлтийн түвшин дэх өөрчлөлт, бодит ба нас хойшлуулалтын нөлөөгөөр, 5 жилийн хугацааны чиг хандлагаар, 1990-2024
Зураг 4.7	Жил тутмын төрөлтийн насны тархалтын чиг хандлага, насны бүлэг дэх төрөлтийн нийт төрөлтөд эзлэх хувиар, 1990-2024
Зураг 4.8	Монгол Улсын 1990-2050 оны төрөлтийн түвшин (ТНК), ажиглагдсан ТНК ба олон хувилбарт таамаглалууд
Зураг 5.1	Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад анхаарал хандуулах шаардлагатай эсэх
Зураг 5.2	Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад санаа зовж буй байдал
Зураг 5.3	Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад анхаарал хандуулах шаардлагатай эсэх, насны бүлгээр

- Зураг 5.4 Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад санаа зовж буй байдал, насны бүлгээр
- Зураг 5.5 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, шалтгаанаар
- Зураг 5.6 Төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээнүүд гэр бүлд хангалттай гэж үзсэн байдал
- Зураг 5.7 Төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээнүүд гэр бүлд хангалттай гэж үзсэн байдал, насны бүлгээр
- Зураг 5.8 Хүүхэдтэй болох шийдвэрт нөлөөлөх төрийн арга хэмжээ
- Зураг 5.9 Эмэгтэй, эрэгтэй хүний анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой насны талаарх хүлээлт
- Зураг 5.10 Эмэгтэйчүүдийн (15-34 насны) амьдралын төлөвлөгөөнд албан ёсны гэрлэлтийн ач холбогдлын түвшин, ерөнхий ойлголтоор чухалд тооцогддог гэрлэлтийн хэлбэрүүд, хот, хөдөөгөөр, %
- Зураг 5.11 Эмэгтэйчүүдийн (15-34 насны) салалтад хандах хандлагын хот, хөдөөгийн ялгаа, %
- Зураг 5.12 15-34 насны эмэгтэйчүүдийн хувийн жингийн тархалт, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдээр, %
- Зураг 5.13 15-34 насны эмэгтэйчүүдийн хувийн жингийн тархалт, гэрлээгүй үед хүүхэд төрүүлэхийг хүлээн зөвшөөрөх байдлаар, %
- Шигтгээ 6.1 Франц: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.2 Герман: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.3 Швед: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.4 Канад: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.5 Чех: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.6 Сингапур: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.7 Өмнөд Солонгос: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.8 Япон: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж
- Шигтгээ 6.9 Монгол: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЖСАХ	Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл
МУИС	Монгол улсын их сургууль
НБТК	Насны бүлгээр тооцсон төрөлтийн коэффициент
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБТС	Нийгмийн үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа
НҮТС	Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа
НҮБХС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан
НҮБХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮЭМС	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТНК	Төрөлтийн нийлбэр коэффициент
ҮСХ	Үндэсний статистикийн хороо

## ХУРААНГУЙ

“Монгол Улсын төрөлтийн шинжилгээ, бодлого” сэдэвт судалгаа нь Монгол Улсад сүүлийн хорин жилд ажиглагдаж буй төрөлтийн түвшний өөрчлөлт, түүний шалтгаан, бүтэц, хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр задлан шинжилж, бодлогын түвшинд авч хэрэгжүүлэх боломжит шийдэл, чиглэлийг тодорхойлох зорилготой юм. Судалгаа нь хүн ам зүйн шилжилтийн онол, олон улсын туршлага, Монгол Улсын статистик болон түүвэр судалгааны өгөгдөлд тулгуурлан хийгдсэн бөгөөд төрөлтийн бууралтыг зөвхөн тоон үзэгдэл бус, харин нийгэм, эдийн засаг, соёл, бодлогын хүчин зүйлсийн нийлмэл үр дүн гэж үзэн тайлбарласан онцлогтой.

Дэлхийн хэмжээнд төрөлтийн түвшин урт хугацаанд тогтвортой буурч, олон улс оронд төрөлт нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доош орсон нь хүн амын насжилт, хөдөлмөрийн нөөцийн хомсдол, нийгмийн хамгааллын тогтолцоонд дарамт учруулах гол хүчин зүйл болж байна. Азийн ихэнх улс оронд төрөлтийн бууралт богино хугацаанд, хурдтай явагдаж байгаа бол Төв Азийн зарим “-стан” улсад 2000 оноос хойш төрөлт тодорхой хэмжээнд өссөн онцлог хандлага ажиглагдаж байна. Энэхүү олон улсын туршлага нь Монгол Улсын төрөлтийн шилжилтийг бүс нутгийн болон түүхэн онцлогтой нь уялдуулан ойлгох суурь нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын хувьд төрөлтийн түвшин 1990 оноос хойш эрчимтэй буурч, 2000-аад оны эхээр түүхэн доод түвшинд хүрснээс хойш тодорхой хугацаанд харьцангуй тогтворжсон ч сүүлийн жилүүдэд дахин буурах хандлага ажиглагдаж байна. Судалгааны үр дүнгээс харахад, төрөлтийн бууралт нь хот, хөдөөгийн ялгаатай байдал, насны бүтэц, гэрлэлт, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, амьдралын өртөг, орон сууцны хүртээмж зэрэг олон хүчин зүйлтэй нягт холбоотой байна. Ялангуяа, Улаанбаатар хотод төрөлтийн түвшин эргэн нөхөгдөх түвшинд ойртож, залуу үеийн дунд хүүхэд төрүүлэх шийдвэр хойшлох, хүүхдийн тоо багасах хандлага давамгайлж байна.

Судалгааны үр дүнгээс харахад, гэрлэлтийн хэв шинжийн өөрчлөлт, жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ, үр хөндөлтийн түвшин, хөхөөр хооллолтын үргэлжлэх хугацаа зэрэг завсрын хүчин зүйлс нь Монгол Улсад төрөлтийн түвшний бууралтад харилцан адилгүй, боловч нийлбэр дүнгээрээ бодитой нөлөө үзүүлж байна. Ялангуяа гэрлэлт, төрөлтийг хойшлуулах хандлага болон жирэмслэлтээс сэргийлэх аргын өргөн хэрэглээ нь төрөлтийн түвшний өөрчлөлтийн гол тайлбарлагч хүчин зүйлс болж байна.

Төрөх насны цаг хугацааны өөрчлөлтөөс үүдэлтэй темпо нөлөөг Bongaarts–Feeney аргаар засварлан темпо-зассан төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК\*)-ийг тооцсон дүнгээс үзэхэд, сүүлийн жилүүдэд ажиглагдаж буй төрөлтийн бууралтын тодорхой хэсэг нь хүүхэд төрүүлэх бодит шийдвэр (quantum)-ийн огцом багасалтаас бус, харин төрөх насыг хойшлуулж буй темпо өөрчлөлттэй шууд холбоотой байна. Энэ нь одоогийн ТНК-ийн түвшин бодит нөхөн үржихүйн шийдвэрийг бүрэн илэрхийлэхгүй, тодорхой хэмжээнд “хойшлуулалтын нөлөөг” агуулж байгааг илтгэнэ.

Мөн үелрэл (cohort) шинжилгээ болон Китагавагийн хоёр бүрэлдэхүүний задаргааны үр дүнгээс харахад, төрөлтийн өөрчлөлтөд нэг талаас нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн насны бүтцийн нөлөө, нөгөө талаас хүүхэд төрүүлэх зан төлөв, шийдвэрийн (хэдэн хүүхэдтэй болох, хэдэн насандаа төрөх) нөлөө ялгаатайгаар үйлчилж байна. Ялангуяа, 20–29 насны эмэгтэйчүүдийн дунд анхны төрөлт хойшлох хандлага, мөн 30–34 насны эмэгтэйчүүдийн дунд хоёр дахь болон дараагийн хүүхэд

төрүүлэх шийдвэр хойшлох, эсхүл хязгаарлагдах нь төрөлтийн түвшний бууралтад голлон нөлөөлж байна. Иймд судалгааны үр дүн нь төрөлтийг дэмжих бодлогын анхаарлыг бүх насны бүлэгт жигд бус, харин анхны гэрлэлт, анхны төрөлт төвлөрч буй 20–29 нас, мөн хоёр дахь хүүхэд төрүүлэх шийдвэр зонхилдог 30–34 насны эмэгтэйчүүдэд оновчтой чиглүүлэх нь илүү үр дүнтэй болохыг нотолж байна. Энэ нь хүүхэд асаргаа, хөдөлмөр–амьдралын тэнцвэр, орон сууц, санхүүгийн дэмжлэг зэрэг бодлогын арга хэмжээг амьдралын мөчлөг, насны онцлогт суурилан зорилтот байдлаар боловсруулах шаардлагатайг тодорхой харуулж байна.

Төрөлт, гэрлэлтийн талаарх хандлагын судалгааны үр дүнгээс харахад, залуу эмэгтэйчүүдийн дунд гэрлэлт, хүүхэд төрүүлэх шийдвэр нь улам бүр хувь хүний эдийн засаг, нийгмийн нөхцөлтэй нягт уялдан, урьдчилан төлөвлөсөн сонголт болж хувирч байна. Ялангуяа, орон сууцны хүртээмж, тогтвортой орлого, хүүхэд асаргааны үйлчилгээний боломж, ажил–амьдралын тэнцвэрийг хангах зохицуулалт нь гэрлэлт, анхны болон дараагийн хүүхэд төрүүлэх шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай суурь нөхцөл гэж үзэх хандлага давамгайлж байна. Судалгааны дүнгээр, эдгээр нөхцөл бүрдээгүй тохиолдолд гэрлэлт болон төрөлтийг бүрмөсөн үгүйсгэх бус, харин тодорхой хугацаагаар хойшлуулах хандлага илүү түгээмэл илэрч байна. Энэхүү хандлага нь Монгол Улсад ажиглагдаж буй төрөлтийн бууралтыг гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийн өөрчлөлтөөр тайлбарлахаас илүүтэй залуу үеийн дунд гэр бүл, хүүхдийн ач холбогдлыг үгүйсгээгүй хэвээр боловч гэрлэлт, төрөлтийг хэрэгжүүлэх цаг хугацаа, дараалал, нөхцөлийн талаарх хүлээлт бодит амьдралын эрсдэл, боломжтой уялдан өөрчлөгдөж буй нь төрөлтийн өнөөгийн өөрчлөлтийн гол онцлог болж байна. Иймд төрөлтийн асуудлыг үнэт зүйлийн түвшинд бус, харин амьдралын мөчлөг, эдийн засаг, нийгмийн бодит нөхцөлтэй уялдуулсан бодлогын хүрээнд авч үзэх шаардлагатайг энэхүү судалгаа нотолж байна.

Судалгаагаар олон улсын сайн туршлагад тулгуурлан төрөлтийг дэмжих бодлогын арга хэмжээг харьцуулан шинжилж, Монгол Улсын нөхцөлд тохирох бодлогын багцыг тодорхойлсон. Үүнд, хүүхэд асаргаа, сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг өргөжүүлэх, санхүүгийн бодит дэмжлэгийг зорилтот бүлэгт чиглүүлэх, ажил–амьдралын тэнцвэрийг дэмжсэн хөдөлмөрийн зохицуулалт, орон сууцны бодлого, мөн “амьдралын мөчлөгт суурилсан” цогц бодлогын хандлагыг нэвтрүүлэх шаардлагатайг онцлон гаргалаа.

Энэхүү судалгааны үр дүн, дүгнэлт, зөвлөмж нь Монгол Улсын хүн амын бодлого, төрөлтийг дэмжих бодлогын шинэчлэлд нотолгоонд суурилсан суурь мэдээлэл өгөхөөс гадна урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжил, хүний нөөцийн төлөвлөлт, нийгмийн хамгааллын стратегитай уялдуулахад чухал ач холбогдолтой байна. Судалгааны үр дүнгээс харахад, төрөлтийн өнөөгийн бууралт нь гэр бүлийн үнэт зүйлсийн сулрал бус, харин гэрлэлт, төрөлтийг хэрэгжүүлэх цаг хугацаа, эдийн засаг, нийгмийн нөхцөлийн талаарх хүлээлт өөрчлөгдөж буйтай илүүтэй холбоотой тул бодлогын хариу арга хэмжээ нь богино хугацааны мөнгөн урамшууллаар хязгаарлагдах боломжгүйг тодорхой харуулж байна.

Иймд төрөлтийг дэмжих бодлогыг амьдралын мөчлөгийг бүхэлд нь хамарсан, салбар хоорондын уялдаа сайтай, зорилтот бүлэгт чиглэсэн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа, анхны гэрлэлт, анхны төрөлт төвлөрч буй 20–29 нас, хоёр дахь хүүхэд төрүүлэх шийдвэр давамгайлдаг 30–34 насны эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлогын

дэмжлэгийг оновчтой, цаг хугацаанд нь хүргэх явдал төрөлтийн бодит өсөлтөд илүү үр нөлөөтэй болохыг судалгаа онцолж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах онцлох бодлогын зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, хүүхэд асаргаа, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанарыг бодитой нэмэгдүүлж, ялангуяа, хот суурин газрын залуу өрхүүдэд хүртээмжтэй, уян хатан үйлчилгээний хэлбэрийг өргөжүүлэх;

*Хоёрдугаарт*, гэрлэлт, анхны болон дараагийн хүүхэд төрүүлэх шийдвэрт шууд нөлөөлөхүйц орон сууц, хөдөлмөр эрхлэлт, орлогын тогтвортой байдлыг дэмжсэн бодлогын багцыг залуу гэр бүлд чиглүүлэн хэрэгжүүлэх;

*Гуравдугаарт*, ажил–амьдралын тэнцвэрийг хангах хөдөлмөрийн зохицуулалт (уян хатан ажлын цаг, эцэг эхийн чөлөө, ажил олгогчийн оролцоо)-ыг бодлогын түвшинд тууштай дэмжих;

*Дөрөвдүгээрт*, төрөлтийг дэмжих бодлогыг бүх нийтэд жигд бус, харин нас, амьдралын үе шат, бүс нутгийн онцлогт суурилсан зорилтот байдлаар хэрэгжүүлэх;

*Тавдугаарт*, төрөлт, гэрлэлт, гэр бүлийн хандлагын өөрчлөлтийг тогтмол судалж, бодлогын үр нөлөөг үнэлэх мониторинг, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх.

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх нь Монгол Улсад төрөлтийн түвшний тогтвортой байдлыг хангах, хүн амын нөхөн үржихүй, төрөлтийг урт хугацаанд дэмжих, улмаар эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн суурийг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм. Иймд энэхүү судалгаа нь цаашдын судалгаа, бодлого боловсруулах үйл явцад ашиглах суурь баримт бичиг болж, хүн ам зүйн бодлогын шинэ үе шатанд шилжихэд бодитой чиг баримжаа өгнө гэж үзэж байна.

## БҮЛЭГ 1: УДИРТГАЛ

### 1.1 Үндэслэл

Хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу дэлхийн улс орнууд төрөлтийн өндөр түвшнээс бага түвшин рүү шилжиж байна. Энэ үзэгдэл Монгол Улсад ч адил илэрч байна. Манай улсад төрөлтийн түвшин 1970-аад оны дунд үеэс буурч эхлээд, сүүлийн хорин жилийн хугацаанд бууралт тогтвортой үргэлжилсээр, 2024 оны байдлаар нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо (ТНК) 2.5 болсон.

Хэдийгээр энэ бууралт хүн ам зүйн шилжилтийн ерөнхий хандлагын хүрээнд тайлбарлагдаж болох ч цөөн хүн амтай, өргөн уудам нутагтай Монгол Улсын хувьд хүн амын өсөлтийг тогтвортой түвшинд хадгалах, хөдөлмөрийн нөөцийг бүрдүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоог тэнцвэртэй байлгах үүднээс онцгой анхаарах асуудал болоод байна. Мөн төрөлтийн түвшний бууралт хот, хөдөө, бүс нутгийн хооронд ялгаатай байна. Тухайлбал, Улаанбаатар хотод нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж 2.1 орчим байгаа бол хөдөө орон нутагт 3 болон түүнээс дээш байна (UNFPA Mongolia, 2022).

Залуучуудын дунд төрөлт буурах хандлага бодитой ажиглагдаж, үүнд боловсрол эзэмших хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн орчин, орон сууцны хүртээмж, нийгмийн хүлээлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байгаа нь харагдаж байна. Үүний зэрэгцээ хүн амын насны бүтэц залуу хэвээр байгаа хэдий ч хүн амын насжилтын хурд нэмэгдэж буй нь тэтгэврийн болон урт хугацааны нийгмийн хамгааллын тогтолцоонд дарамт учруулж болзошгүй байна (United Nations, 2022).

Нөгөөтэйгүүр, төрөлт нь эдийн засаг, хөдөлмөрийн зах зээл, хүний нөөцийн төлөвлөлтөд хүчтэй нөлөө үзүүлдэг үзүүлэлт учраас нийгмийн бодлого, ялангуяа боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн стратегид төрөлтийн хандлагыг тооцох шаардлагатай. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, гэр бүл-ажил амьдралын тэнцвэр, хот суурин газрын шилжилт хөдөлгөөний хандлага зэрэгт төрөлтийн шийдвэр гаргалт чухал нөлөөтэй байна.

Гэр бүлийн бүтэц, гэрлэлтийн хандлага, амьдралын хэв маягт гарч буй өөрчлөлтүүд (жишээлбэл, гэрлэлтийн нас хойшлолт, ганц бие амьдрал сонголт, гэр бүл салалт) нь нөхөн үржихүйн шийдвэрт хүчтэй нөлөө үзүүлж, жендэрийн ялгаа, нийгмийн хандлагыг анхаарч судлах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Мөн жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хүртээмж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний ялгавартай байдал нь төрөлтөд нөлөөлөх гол хүчин зүйл хэвээр байсаар байна. Хөдөө орон нутаг болон нийгмийн эмзэг бүлгийн хувьд эдгээр үйлчилгээнд хүрэх боломж хязгаарлагдмал байгаа нь төлөвлөөгүй жирэмслэлт болон эх, хүүхдийн эрүүл мэндийн эрсдлийг нэмэгдүүлж байна. Залуучууд, өсвөр үеийнхний бэлгийн боловсролын дутмаг байдал нь хүн амын тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна.

Ийм нөхцөл байдалд Монгол Улсын төрөлтийн өөрчлөлт, түүний хандлага, нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан судалж, нотолгоонд суурилсан, бүс нутгийн ялгаатай нөхцөлийг харгалзан үзсэн бодлогын дэмжлэг шаардлагатай болжээ.

## 1.2 Зорилго, зорилт

Судалгааны гол зорилго бол Монгол Улсын төрөлтийн түвшний өөрчлөлт, төрөлтөд нөлөөлж буй шууд болон шууд бус хүчин зүйлсийн нөлөөг тодорхойлж, төрөлтийг дэмжих бодлогын зөвлөмж боловсруулах юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- Төрөлтийн түвшин, хандлагыг тодорхойлж, ирээдүйн төлөв байдлын таамаглал боловсруулах;
- Төрөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох;
- Бодлогын төлөвлөлтөд суурь мэдээлэл бэлтгэн өгөх.

## 1.3 Судалгааны арга зүй

### Судалгааны өгөгдөл, мэдээлэл

Судалгаанд дараах өгөгдөл, мэдээллийг ашигласан. Үүнд:

- Төрөлтийн мэдээлэл: Албан ёсны бүртгэл статистикаар цуглуулагдсан төрөлтийн мэдээлэл, 1990-2024
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны өгөгдлийн сан: Тус судалгаа хийгдсэн 1998, 2003, 2008, 2013, 2018, 2023 оны өгөгдлийн сангийн тоо мэдээлэл дээр ажилласан.
- Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа +, 2025-2026, 1-р шатны өгөгдлийн сан: Төрөлт, гэрлэлтийн талаарх хандлага, төсөөллийн талаарх тоо мэдээлэл
- Баримт бичиг судлал: Төрөлтийг дэмжих чиглэлээр амжилттай хэрэгжсэн олон улсын туршлага, сургамж, Монгол Улсын өнгөрсөн болон өнөөгийн хүн амын төрөлтийг дэмжих бодлого, гол арга хэмжээ

### Шинжилгээний арга зүй

1. Төрөлттэй холбоотой өгөгдлийг хүн ам зүй, статистикийн шинжилгээний арга зүйг ашиглан шинжиллээ. Төрөлтөд нөлөөлөх завсрын хүчин зүйлсийн шинжилгээ. Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийг Бонгаарцын загвараар улсын хэмжээнд болон хот хөдөөгөөр тооцов.
2. Төрөх насны цаг хугацааны (темпо) өөрчлөлтөөс (ихэвчлэн хойшлуулалт) үүдсэн темпо нөлөөг Bongaarts–Feeney аргаар (Bongaarts and Feeney, 1998) засварлаж, темпо-зассан ТНК (ТНК\*)-ийг тооцлоо. Ингэснээр тухайн жилийн ТНК-ийн түвшингээс темпо нөлөөг салгаж, бодит төрөлтийн түвшинг илэрхийлэх хэмжүүрийг авсан.
3. Төрөх нас хойшлуулалтын хүчийг илтгэх Квантум индекс (Bongaarts and Feeney, 1998) тооцсон ба 1991 оны түвшинг суурь болгон хугацааны бүлгүүдээр харьцуулан үнэлэв. Ингэснээр хүүхдийн тооны бодит шийдвэрийн (quantum) түвшин ба темпо өөрчлөлтийн чиг, эрчийг ялган харуулав.
4. Китагавагийн хоёр<sup>1</sup> бүрэлдэхүүний задлан шинжилгээгээр төрөлтийн түвшний өөрчлөлтийг (i) хүмүүсийн бодит шийдвэр буюу зан төлөв—хэдэн хүүхэдтэй болох, хэдэн насандаа төрөх; мөн (ii) нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн насны бүтцийн нөлөө гэсэн хоёр эх сурвалжид хуваан үнэлж, улмаар аль үед зан төлөв, аль үед насны бүтэц давамгайл нөлөөлснийг тодруулав (Kitagawa, 1955).

<sup>1</sup> Бодлого боловсруулах зорилгоор хоёр бүрэлдэхүүнийг, академик судалгаанд илүү нарийвчилсан гурван бүрэлдэхүүнт шинжилгээг хийдэг.

5. Жил бүрийн төрсөн хүүхдийн тоог эхийн насны бүлгээр (15–49) хуваарилан (Preston et.al, 2001), нийт төрөлтөд эзлэх хувь нэмрийн тархалт болон түүний цаг хугацааны өөрчлөлтийг үнэлэв. Ингэснээр аль насны бүлэгт дэмжлэг, үйлчилгээ, бодлогын анхаарлыг төвлөрүүлэхийг үнэлэх боломж бүрдэнэ.
6. Оргил төрөх насыг жил бүрээр тогтоон, түүний шилжилтийг мөрдөх замаар төрөх насыг хойшлуулж буй темпо өөрчлөлтийн чиглэл, хэмжээг тогтоов. Энэ үр дүнг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, хүүхэд асаргаа, уян хатан ажлын зохицуулалт, орон сууц/санхүүгийн дэмжлэг зэрэг бодлогын нөөц, урамшууллыг аль насны бүлэгт чиглүүлэх ба цаг хугацааны төлөвлөлтийг оновчлоход суурь болгон ашигладаг.
7. Үелрэл (cohort) шинжилгээ нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг төрсөн оноор нь бүлэглэн, тухайн үелрэлийн төрөлтийн нийлбэр коэффициент (CFR) буюу үелрэл-ТНК-ийг бодож гаргадаг. Энэхүү арга нь тухайн үеийн эмэгтэйчүүд нөхөн үржихүйн насаа бүрэн гүйцээсэн үедээ амьдралынхаа туршид хэдэн хүүхэд төрүүлж буй талаар мэдээллийг гаргана. Иймд, үелрэл шинжилгээ нь тухайн үеийн (period) ТНК-ийн шинжилгээнээс тусдаа хийгдэж, нөхөн үржихүйн насыг гүйцээсэн эмэгтэйчүүдийн төрөлтийн түүхэн замнал дахь бодит шийдвэрийн өөрчлөлт, хандлагыг нарийвчлан судлах боломж олгодог.
8. Төрөлтийн талаарх бодлогын арга хэмжээний талаар туршлага судлах (Case Study Analysis).

## 1.4 Судалгааны ач холбогдол, хязгаарлалт

### Судалгааны ач холбогдол

Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшин, хандлагыг шинжлэх судалгаа нь улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, хүний нөөцийн төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлтийн орчин, нийгмийн хамгааллын тогтолцоог дэмжих чухал ач холбогдолтой. Төрөлт буурах хандлага нь олон хүчин зүйлсийн нөлөөгөөр эрчимтэй өрнөж, энэ нь хүн амын өсөлт, насны бүтэц, тэтгэврийн болон нийгмийн хамгааллын тогтолцоонд дарамт учруулах эрсдэлтэй. Төрөлтийн түвшний бууралт нь нийгэм, эдийн засгийн олон салбарт сөрөг үр дагавар үүсгэх тул энэ асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна. Иймд Монгол Улсын төрөлтийн хандлагыг гүнзгийрүүлэн судалж, төрөлт нэмэгдүүлэх бодлогын зөвлөмж гаргах нь улс орны хүн амын өсөлт, хөдөлмөрийн нөөцийг зохицуулах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт болон гэр бүлд ээлтэй бодлогын хэрэгжилтийг сайжруулахад чухал хувь нэмэр оруулах боломжтой.

### Судалгааны хязгаарлалт

Төрөлтийн шинжилгээ хийхэд тулгарсан зарим хязгаарлалт. Эдгээр нь:

1. Өгөгдлийн хязгаарлагдмал байдал: Судалгаанд ашиглагдсан өгөгдөл, ялангуяа гэрлэлт, салалт гэх мэт эх үүсвэрүүдийн бүртгэлийн чанар, хүртээмж хязгаарлагдмал. Мөн тодорхой бүс нутаг, насны бүлгүүдийн хувьд мэдээлэл дутагдалтай.
2. Нийгмийн болон эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөлөл: Нийгмийн үзүүлэлтүүд (соёл, гэр бүлийн үнэт зүйлс гэх мэт) болон эдийн засгийн хүчин зүйлсийн өөрчлөлтүүдийн нарийвчилсан шинжилгээ хийхэд тодорхой нөхцөл байдал, соёлын ялгаа зэргийг харгалзан үзэх шаардлагатай бөгөөд эдгээр хүчин зүйлсийн нөлөө бүрэн хэмжээнд үнэлэгдэхгүй байх магадлалтай.
3. Хугацааны хязгаарлалт: Судалгааны хугацаа болон арга зүйн бүтэц зарим хүчин зүйлсийг бүрэн судлахад хязгаарлалт үүсгэж байв.


## БҮЛЭГ 2: ДЭЛХИЙН ХҮН АМЫН ТӨРӨЛТИЙН ХАНДЛАГА

Сүүлийн хэдэн арван жилд дэлхийн хэмжээнд төрөлтийн түвшин тогтвортой буурч, олон улс оронд төрөлтийн нийлбэр коэффициент нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс (ТНК < 2.1) доош орсон байна. Ялангуяа, Европ, Зүүн Ази, Хойд Америкийн орнуудад төрөлт маш бага түвшинд хүрч, үүний үр дүнд хүн амын хурдацтай насжилт, хөдөлмөрийн насны хүн амын тоо хэмжээ буурах үйл явц эрчимжиж байна. Харин Африк болон зарим бага орлоготой улс орнуудад төрөлтийн түвшин харьцангуй өндөр хэвээр байгаа ч урт хугацаанд буурах ерөнхий чиг хандлага ажиглагдаж байна.

### 2.1 Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин

Төрөлтийн шилжилтийн явцыг дэлхийн бүс нутгуудаар Зураг 2.1-д харуулав. Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин 1950-аад онд нэг нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 5 орчим байсан бол 2023 он гэхэд 2.25 орчимд хүрч мэдэгдэхүйц буурсан. Хорин таван жилийн динамикаар авч үзвэл, 1950–1975 болон 1975–2000 оны хооронд ТНК (нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо) тус бүр ойролцоогоор нэг нэгжээр, нийтдээ 50 жилийн хугацаанд 2 хүүхдээр буурч, 2000 онд 2.75 болсон. Харин сүүлийн 25 жилийн хугацаанд төрөлтийн түвшин 0.5 хүүхдээр буурсан нь 1950–2000 оны үетэй харьцуулахад төрөлтийн бууралтын хурд саарч буйг илтгэж байна.

Зураг 2.1: Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 1950 - 2023




Эх үүсвэр: United Nations, World Population Prospects. 2024

Дэлхийн хүн амын төрөлтийн түвшний чиг хандлага хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хувьд нэлээд ялгаатай байна. Дэлхийн II дайны дараах үед олон улсад “төрөлтийн тэсрэлт” ажиглагдаж байсан бөгөөд энэ үед Европын орнуудад ТНК ойролцоогоор 2.8 түвшинд байв. Үүнээс хойш Европ болон бусад хөгжингүй орнуудад төрөлтийн түвшин тогтвортой буурсаар ирсэн. Харин хөгжиж буй орнуудын хувьд төрөлтийн бууралтын үйл явц харьцангуй хожуу, голчлон 1970-аад оноос эхэлсэн бөгөөд тухайн үед эдгээр улс орнууд хүн ам зүйн шилжилтийн эхний үе шатанд байсан. Гэсэн ч өнөөгийн хөгжиж буй орнуудад төрөлтийн өндөр түвшнээс харьцангуй доогуур түвшинд шилжих, өөрөөр хэлбэл, хүн ам зүйн шилжилтийн явц одоогийн хөгжингүй орнуудтай харьцуулахад богино хугацаанд, илүү хурдацтай өрнөж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Төрөлтийн түвшний өөрчлөлтийг дэлхийн бүс нутгаар авч үзвэл, 2023 оны байдлаар ТНК 1.5–4.4-ийн хооронд хэлбэлзэж байна. Хамгийн өндөр төрөлтийн түвшин Африкийн бүс нутагт ажиглагдаж байгаа бол Европ, Австрали/Шинэ Зеланд, Хойд Америкийн орнуудад 2000 оноос эхлэн төрөлт хүн амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доош орж, тогтвортой буурсан. Харин Ази болон Латин Америкийн ихэнх орнуудад төрөлтийн түвшин харьцангуй дундаж түвшинд буюу нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2.5–3 орчимд байна. Гэхдээ эдгээр бүс нутгийн дотор улс орнуудын хоорондын ялгаа нэлээд их байгааг дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

**Зураг 2.2: Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 1950 – 2023, бүс нутгаар**



Эх үүсвэр: United Nations, World Population Prospects. 2024

Хүснэгтээс харахад, хөгжингүй орнууд, ялангуяа Европ, Хойд Америк, Австрали/Шинэ Зеландын бүс нутагт 1950–1975 оны хооронд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо ойролцоогоор 1 хүүхдээр буурч байсан бол сүүлийн 25 жилийн хугацаанд төрөлтийн түвшин харьцангуй тогтвортой, маш бага түвшинд хүрээд байна.

**Хүснэгт 2.1: Дэлхийн хүн амын төрөлтийн түвшин, 25 жилээрх тоон өөрчлөлт**

	Төрөлтийн нийлбэр Кoeffициент				Тоон өөрчлөлт		
	1950	1975	2000	2023*	1950-1975	1975-2000	2000-2023
Дэлхий	4.85	4.08	2.75	2.25	-0.77	-1.33	-0.50
Хөгжингүй	2.86	2.01	1.56	1.45	-0.85	-0.45	-0.11
Хөгжиж буй /бага хөгжсөн/	5.93	4.88	3.00	2.36	-1.05	-1.88	-0.64
Хөгжиж буй /хамгийн бага хөгжсөн/	6.42	6.69	5.23	3.94	0.27	-1.46	-1.29
Африк	6.64	7.13	6.39	4.35	0.49	-0.74	-2.04
Ази	5.64	5.40	3.53	3.10	-0.24	-1.87	-0.43
Европ	3.95	2.58	1.62	1.62	-1.37	-0.96	0.00
Латин Америк	6.28	5.56	3.81	2.50	-0.72	-1.75	-1.31
Хойд Америк	2.78	2.00	1.58	1.47	-0.78	-0.42	-0.11
Австрали/Шинэ Зеланд	3.15	2.24	1.80	1.64	-0.91	-0.44	-0.16

Эх үүсвэр: United Nations, World Population Prospects. 2024

Зарим улс орнуудад нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 1.5-аас доош түвшинд хүрээд байна. Дэлхийн хүн амын хандлага, 2024 тайланд дурдсанаар, өнөөгийн байдлаар дэлхийн улс орнуудын талаас илүү хувь нь төрөлтийн түвшин хүн амын нөхөн

үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс (2.1) доогуур орсон байгааг онцлон тэмдэглэсэн байна (World Population Prospects, 2024).

Ийнхүү хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу төрөлтийн түвшин түүхэн хугацааны туршид тасралтгүй буурсаар байна. Үүний үр дүнд “baby boom” буюу төрөлтийн тэсрэлт ажиглагдаж байсан Европын зарим орнуудад төрөлтийн абсолют тоо нас баралтын түвшнээс доогуур орж, “baby boomlet” буюу төрөлтийн хомсдолын үзэгдэл илрэх болжээ. Дэлхийн хүн амын хандлага, 2024 тайланд дурдсанаар дэлхийн хүн амын 28 хувийг бүрдүүлдэг 63 улс оронд хүн амын тоо аль хэдийнээ дээд цэгтээ хүрсэн. Энэ нь эдгээр улс орнууд хүн ам зүйн шилжилтийн дараах шатанд орж, цаашид хүн амын тоо буурах үе шат эхэлснийг харуулж байна. Тухайлбал, Хятад, Герман, Япон, Оросын Холбооны Улс зэрэг улсууд үүнд багтаж байна.

## 2.2 Азийн улс орнуудын төрөлт, харьцуулалт

Азийн ихэнх улс орнуудад 1950-иад оны үед төрөлтийн түвшин өндөр байсан боловч өнгөрсөн зууны сүүл үеэс, ялангуяа 1975 оноос эхлэн төрөлтийн бууралт эрчимтэй явагдсан. Нарийвчилсан харьцуулалт хийх зорилгоор улс орнуудыг төрөлтийн түвшнээр нь өндөр (ТНК  $\geq 4.0$ ), дунд (ТНК 2.11–3.9), бага (ТНК 1.6–2.10), маш бага (ТНК  $\leq 1.50$ ) гэж ангилан авч үзлээ. Хүснэгт 2.2-оос харахад, 2025 оны байдлаар Азийн 37 улсын дийлэнх нь буюу 24 улс (68 хувь) төрөлтийн түвшин хүн амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доогуур орсон байна. Эдгээрээс 14 улс бага, 10 улс маш бага төрөлтийн ангилалд хамаарч байна. Тухайлбал, Сингапур, БНСУ, Хонг Конг, Макао зэрэгт төрөлтийн түвшин 1-ээс доош буурч, дэлхийн хэмжээнд хамгийн бага төрөлттэй орнуудын тоонд багтаж байна.

Азийн орнуудад төрөлтийн бууралт маш хурдан явагдаж байгааг хүснэгтээс харж болно. Азийн ихэнх улс оронд 1950 онд нэг эмэгтэй дунджаар 5-6 орчим хүүхэд төрүүлж байсан бол өнөөгийн байдлаар ихэнх нь эргэн нөхөгдөх түвшнээс доогуур төрөлттэй болжээ.

**Хүснэгт 2.2: Азийн улс орнуудын төрөлтийн түвшин, 1950-2025**


Улс	Төрөлтийн нийлбэр коэффициент				Хувийн жингийн өөрчлөлт		
	1950	1975	2000	2025	1950-1975	1975-2000	2000-2025
<b>Өндөр төрөлт</b>							
Афганистан	7.25	7.54	7.57	4.66	4.00	0.40	-38.44
<b>Дунд</b>							
Пакистан	6.80	6.81	5.35	3.50	0.15	-21.44	-34.58
Бангладеш	6.37	6.73	3.28	2.11	5.65	-51.26	-35.67
Жордан	7.44	7.93	3.86	2.57	6.59	-51.32	-33.42
Камбожи	6.53	4.10	3.79	2.51	-37.21	-7.56	-33.77
Лаос	6.25	6.29	4.43	2.36	0.64	-29.57	-46.73
Израйл	4.57	3.61	2.92	2.75	-21.01	-19.11	-5.82
Казакстан	4.56	3.40	1.90	2.95	-25.44	-44.12	55.26
Киргизистан	4.63	4.76	2.58	2.75	2.81	-45.80	6.59
Монгол	5.50	7.07	2.25	2.58	28.55	-68.18	14.67
Тажикстан	5.61	6.69	3.49	2.99	19.25	-47.83	-14.33
Туркменстан	5.26	6.00	2.90	2.63	14.07	-51.67	-9.31
Узбекстан	5.17	5.92	2.70	3.45	14.51	-54.39	27.78
<b>Бага (2.10 – 1.6)</b>							
Азербайжен	5.07	4.21	1.70	1.66	-16.96	-59.62	-2.35
Армен	4.90	2.92	1.47	1.71	-40.41	-49.66	16.33
Бирм	5.94	5.25	2.81	2.08	-11.62	-46.48	-25.98

Вьетнам	5.15	5.62	2.03	1.88	9.13	-63.88	-7.39
Гүрж	2.98	2.55	1.61	1.79	-14.43	-36.86	11.18
Индонез	5.11	5.03	2.50	2.10	-1.57	-50.30	-16.00
Иран	6.97	5.95	2.00	1.67	-14.63	-66.39	-16.50
Мальдив	6.18	7.32	2.69	1.55	18.45	-63.25	-42.38
Непал	6.06	5.73	3.98	1.94	-5.45	-30.54	-51.26
Пиллиппин	7.13	5.60	3.75	1.88	-21.46	-33.04	-49.87
Шри-ланка	5.46	3.82	2.21	1.94	-30.04	-42.15	-12.22
Хойд Солонгос	4.99	3.05	1.94	1.77	-38.88	-36.39	-8.76
Турк	6.47	5.09	2.49	1.62	-21.33	-51.08	-34.94
Энэтхэг	5.73	5.19	3.35	1.94	-9.42	-35.45	-42.09
<b>Маш бага (1.50-с бага)</b>							
Бутан	6.85	6.62	3.38	1.44	-3.36	-48.94	-57.40
Малайз	6.43	4.50	2.94	1.53	-30.02	-34.67	-47.96
Кипр	3.87	2.11	1.64	1.37	-45.48	-22.27	-16.46
Япон	3.62	1.92	1.35	1.23	-46.96	-29.69	-8.89
Тайланд	6.36	4.36	1.73	1.19	-31.45	-60.32	-31.21
Хятад	5.81	3.57	1.63	1.02	-38.55	-54.34	-37.42
Сингапур	6.23	2.08	1.34	0.96	-66.61	-35.58	-28.36
Өмнөд Солонгос	6.06	3.31	1.47	0.75	-45.38	-55.59	-48.98
Хонг Конг	4.26	2.63	1.03	0.73	-38.26	-60.84	-29.13
Макао	5.55	1.55	0.93	0.69	-72.07	-40.00	-25.81

Эх үүсвэр: United Nations, World Population Prospects. 2025

Ихэнх Азийн орнуудад төрөлтийн түвшин тасралтгүй буурч байгаа бол Казакстан, Киргизстан, Узбекистан зэрэг Төв Азийн “-стан” улсуудад харьцангуй өөр, онцлог хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, эдгээр орнуудад төрөлтийн түвшин 1990–2000 оны хооронд огцом буурч, 2000-аад оны эхээр түүхэн доод хэмжээнд хүрсэн боловч түүнээс хойш эргэн өсөж, өнөөгийн байдлаар нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 3 орчимд хүрсэн. Энэ нь Азийн бусад бүс нутгийн нийтлэг чиг хандлагатай харьцуулахад төрөлтийн шилжилтийн өөр замаар бүрэлдэж байгааг харуулж байна.

Зураг 2.3: “-стан” улсуудын төрөлтийн түвшин, 1950-2025



Эх үүсвэр: United Nations, World Population Prospects. 2025


Төрөлтийн түвшинд нийгэм, эдийн засаг, гэр бүлийн бүтэц зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг ч эдгээр улсуудад нийтлэг ажиглагдах нэг онцлог нь 1991 онд ЗСБНХУ задран унасны дараа тусгаар тогтнолоо олж, нийгэм, эдийн засгийн гүнзгий шилжилтийг туулсан

явдал юм. Монгол Улс ч мөн адил 1990 оноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцоонд шилжин, үүний үр дагаварт төрөлтийн “өөр” буюу онцлог хандлага ажиглагдсан. Төрөлтийн энэхүү шилжилтийг бодлого боловсруулагчид, эдийн засагчид бодлогын орчин, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон эдийн засгийн тогтвортой байдалтай холбон тайлбарладаг бол хүн ам зүйчид төрөлтийн темпо өөрчлөлт, мөн төрөлт хойшлох үзэгдлийн нөлөөг онцлон авч үздэг. Энэ талаар Монгол Улсын жишээн дээр тулгуурлан дараагийн дэд бүлэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

### 2.3 Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс

Хүн амын төрөлтийн түвшинд биологийн болон хувь хүний зан үйлийн хүчин зүйлсээс гадна нийгэм, эдийн засаг, соёл, бодлогын зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлс төрөлтөд нөлөөлдгийг тайлбарлах зорилгоор боловсруулсан олон загвар, онолын дундаас харьцангуй системтэй хандлагыг 1950-иад онд Францын хүн ам зүйч Луис Хенри, Америкийн социологич Кингслей Давис, Жудит Блаке нар анх дэвшүүлсэн (Bongaarts, 2014). Тэд төрөлт нь нийгэм, эдийн засаг, соёл, зан заншил, улс төр, хууль эрх зүй, сэтгэл зүй зэрэг олон хүчин зүйлсийн нийлмэл, цогц нөлөөллөөс хамаардаг, эдгээрийн зарим нь төрөлтөд шууд, зарим нь шууд бусаар нөлөөлдөг болохыг тодорхойлжээ. Мөн төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн үйлчлэл нь тодорхой зүй тогтлын дагуу явагддаг гэдгийг тогтоосон байна. Тэдний үзлээр нийгэм, эдийн засаг, соёл болон бодлогын хүчин зүйлс нь завсрын хүчин зүйлсээр дамжин хувь хүний төрөлтийн зан үйл, шийдвэрт нөлөөлдөг гэж тайлбарладаг.

Диаграмм 2.1: Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс




Энэхүү хандлагыг 1978 онд Жоан Бонгаарц (Bongaarts, 2014) илүү боловсронгуй болгож, дээрх Диаграмм 1-д багтсан нийт 11 завсрын хүчин зүйлсээс гэрлэлт, жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээ, үр хөндөлт, хүүхдээ хөхөөр хооллох зэрэг дөрвөн хүчин зүйл нь төрөлтөд бусдаасаа илүү хүчтэй нөлөө үзүүлдгийг тодорхойлсон. Түүний хөгжингүй болон хөгжиж буй орнуудыг хамарсан 41 орны мэдээлэлд тулгуурлан хийсэн судалгаагаар эдгээр дөрвөн хүчин зүйл нь нийт төрөлтийн өөрчлөлтийн ойролцоогоор 96 хувийг тайлбарлаж байжээ. Иймээс төрөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг судлахад эдгээр дөрвөн завсрын хүчин зүйлийг онцгойлон авч үздэг. Бонгаарцын загвар нь төрөлт

судлал, төрөлтийн түвшин болон түүний өөрчлөлтийг тайлбарлахад хамгийн өргөн хэрэглэгддэг загварын нэг болсон юм. Уг загвар нь дэлхийн бүс нутгууд болон хүн амын янз бүрийн бүлгүүдийн хоорондын төрөлтийн ялгаатай байдал, мөн цаг хугацааны явц дахь төрөлтийн өөрчлөлтийг цогцоор нь тайлбарлах боломж олгодог давуу талтай.

Хүн ам зүйн шилжилтийн онол нь тодорхой хугацааны туршид төрөлт, нас баралтын түвшин өөрчлөгдөх зүй тогтлыг тайлбарласан онол юм. Энэхүү онолд эдийн засаг, нийгмийн хөгжлийн явцад нас баралт, төрөлтийн түвшин анх өндөр байснаа аажмаар буурдаг хандлагатай гэж үздэг. Өөрөөр хэлбэл, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт нь хүн амын нөхөн үйлдвэрлэлийн хэв шинжийг үе шаттайгаар өөрчилдөг. Хүн ам зүйн шилжилт нь нийтдээ үндсэн дөрвөн үе шатыг хамардаг.

**Зураг 2.4: Хүн ам зүйн шилжилтийн сонгодог онол**



Хүн ам зүйн шилжилтийн нэгдүгээр үе шатанд төрөлт, нас баралт хоёул өндөр түвшинд байдаг тул хүн амын ердийн өсөлт маш бага буюу бараг ажиглагддаггүй. Хоёрдугаар үе шатанд нас баралт буурч, төрөлт өндөр хэвээр хадгалагдсанаар хүн амын өсөлт эрчимжиж, ердийн өсөлт харьцангуй өндөр түвшинд хүрнэ. Гуравдугаар үе шатанд төрөлт буурснаар ердийн өсөлт саарч, хүн амын өсөлт удааширч эхэлдэг. Харин дөрөвдүгээр үе шатанд төрөлт, нас баралт хоёул доогуур түвшинд тогтож, хүн амын ердийн өсөлт дахин маш бага буюу бараг тэгтэй тэнцэх хэмжээнд хүрдэг.

Хүн ам зүйн шилжилтийн онол нь хүн амын өсөлтийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшинтэй уялдуулан судлахад чухал ач холбогдолтой. Уг онолын дагуу шилжилтийн эхний үе шатанд байгаа улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил харьцангуй доогуур байж, энэ нь төрөлт, нас баралтын түвшин өндөр байх гол нөхцөл болдог. Харин улс орны хөгжлийн түвшин ахихын хэрээр эхлээд нас баралт, улмаар төрөлт буурч, хүн ам зүйн шилжилтийн дараагийн шатанд шилжинэ. Ийнхүү улс орон бүр хөгжлийнхөө явцад хүн ам зүйн шилжилтийн эдгээр үе шатыг зайлшгүй дамждаг боловч үе шат бүрийн үргэлжлэх хугацаа харилцан адилгүй байдаг.

Хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу төрөлтийн түвшин түүхэн цаг хугацааны явцад буурдаг ч нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доош унахгүй гэсэн таамаглал

заавал биелдэггүй нь бодит байдал дээр ажиглагдаж байна. Үүний улмаас судлаачид уламжлалт онолын хүрээнээс давсан шинэ үзэгдлийг тайлбарлах зорилгоор “Хоёр дахь хүн ам зүйн шилжилт”-ийн тухай ойлголтыг дэвшүүлэх болсон юм.


Судлаачид “Хоёр дахь хүн ам зүйн шилжилт”-ийг анх төрөлт нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доогуур түвшинд хүрсэн үзэгдэлтэй холбон тайлбарлаж, үүнийг Европын орнуудад “фамилизм” буюу гэр бүлд чиглэсэн амьдралын хэв маяг суларч, түүний оронд “индивидуализм” өргөн дэлгэрсэнтэй уялдуулан авч үздэг. Энэ өөрчлөлт нь албан ёсны гэрлэлт хамтран амьдрах хэлбэрт шилжих, гэр бүл салалтын түвшин нэмэгдэх (тухайлбал Итали, АНУ), мөн хосууд нөхөн үржихүйн хэрэгцээнээс илүүтэй нийгмийн болон хувь хүний хэрэгцээг тэргүүнд тавьж, өмнөх үеийнхнээс цөөн хүүхэдтэй байхыг эрмэлзэх хандлагаар илэрч байна. Өөрөөр хэлбэл, эдгээр орнуудад төрөлтийн түүхэн хандлага эхэн үед эдийн засгийн болон эдийн засгийн бус хэрэгцээнд тулгуурлаж байсан бол цаашид эдийн засгийн бус хэрэгцээнд суурилсан, харин өнөө үед “индивидуализм”-д үндэслэсэн төрөлтийн хэв шинж давамгайлах болсон нь ажиглагдаж байна.

## БҮЛЭГ 3: МОНГОЛ УЛСЫН ТӨРӨЛТИЙН ШИЛЖИЛТ

### 3.1 Монгол Улсын хүн амын өсөлт, бүтэц

Монгол Улсын хүн ам зүйн өөрчлөлт, чиг хандлагыг авч үзвэл, хүн ам зүйн шилжилтийн ерөнхий хэв маягийг дагаж ирсэн нь ажиглагддаг. Хүн амыг анх тоолсон 1918 оноос 1950-иад оны дунд үе хүртэл хүн амын өсөлт харьцангуй удаан, жилийн 1 хувиас доогуур түвшинд байсан. Харин 1950-иад оны сүүл үеэс хүн амын өсөлт эрчимжиж, 1969–1979 онд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. Бусад олон улстай адил 1960–1970-аад оны Монгол Улсын хүн амын хурдацтай өсөлт нь төрөлтийн түвшин нэмэгдэж, нас баралтын түвшин буурсантай шууд холбоотой байсан. Тухайлбал, 1918 онд 647.5 мянга байсан хүн ам 2010 оны хүн ам, орон сууцны тооллогоор 2.6 саяд хүрч, 2020 оны тооллогоор 3.3 сая болж тус тус нэмэгдсэн нь урт хугацаанд хүн ам жилд дунджаар 1.5 орчим хувиар өссөнийг илтгэнэ.


Зураг 3.1: Монгол Улсын хүн амын тоо, өсөлтийн хурд, 1918-2024



Эх үүсвэр: 1212.mn

Монгол Улсын хүн ам зүйн түүхэн хандлагыг харвал, 1918 оноос хойш хүн ам зүйн шилжилтийн үндсэн гурван үе шатыг дамжсан нь харагддаг. Үүнд: *нэгдүгээрт*, хүн амын өсөлт харьцангуй бага байсан үе, *хоёрдугаарт*, хүн ам хурдацтай өссөн үе, *гуравдугаарт*, хүн амын өсөлт удааширсан үе юм. Хүн ам зүйн шилжилтийн хоёрдугаар үе шатанд Монгол Улсын хүн амын хурдацтай өсөлт нь зөвхөн нас баралтын түвшин буурсантай бус, мөн төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй нягт холбоотой байв. Харин гуравдугаар үе шатанд хүн амын өсөлтийн хурд саарсан нь зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй давхцсан эдийн засгийн хүндрэл, тогтворгүй байдалтай илүүтэй уялдаж байсныг онцолж болно.


**Зураг 3.2: Монгол Улсын хүн ам зүйн шилжилт, 1934-2024**



Эх үүсвэр: 1212.mn

Төрөлт, нас баралтын түвшний өөрчлөлт нь хүн амын нас, хүйсийн бүтцэд тодорхой нөлөө үзүүлдэг. Монгол Улсын 2024 оны хүн амын нас, хүйсийн суваргыг төрөлт огцом буурахаас өмнөх үе болох 1990 онтой харьцуулан Зураг 3.3-т үзүүлэв. Энэ харьцуулалтаас төрөлтийн түвшин буурсны дүнд хүн амын насны бүтэц мэдэгдэхүйц өөрчлөгдөж буй нь тодорхой харагдаж байна.

**Зураг 3.3: Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суварга, 1990, 2024 он**




### 3.2 Төрөлтийн шилжилтийн хандлага, ялгавартай байдал

Монгол Улсын хүн амын төрөлтийн түүхэн чиг хандлагаас төрөлт хүн ам зүйн хөгжилд онцгой чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн нь харагддаг. Тухайлбал, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх гуравдугаар таван жилийн төлөвлөгөөний (1961–1965) хүрээнд хүн амын өсөлтийг дэмжих албан ёсны бодлого, арга хэмжээнүүдийг анх удаа системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн. Үүнд, хүүхэдтэй өрх, шинээр гэрлэсэн хосуудад мөнгөн тэтгэмж олгох, “Алдарт эх” I, II одонгоор шагнах, дөрвөөс дээш хүүхэдтэй

эхчүүдэд нэмэлт мөнгөн дэмжлэг үзүүлэх, 50 наснаас тэтгэвэр тогтоох, гэрлээгүй болон хүүхэдгүй өрхөд тусгай татвар ногдуулах, ажил эрхэлж буй эхчүүдийн эрхийг хамгаалсан хөдөлмөрийн хууль батлах зэрэг арга хэмжээнүүд багтаж байв (Ньюперт 1994; Ньюперт 1996:36). Мөн жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл<sup>2</sup>, хэрэглэх, ерөндөг тавих, үр хөндөлтийг<sup>3</sup> хатуу хориглож, зөвхөн эрүүл мэндийн заалттай тохиолдолд л зөвшөөрдөг байсан. Эдгээр бодлого, зохицуулалтын үр дүнд 1960-аад оны эхээр Монгол Улсад нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн дундаж тоо 7–8-д хүрч, түүхэн дээд түвшиндээ хүрч байв.

**Зураг 3.4: Монгол Улсын Төрөлтийн нийлбэр коэффициент ба хүн амын бодлого, 1963-2010**



Эх үүсвэр : Ньюперт 1994; УСХ 2004, 2006, 2007, 2008, 2009. Жич: Зургийг Гэрэлтуяа ба бусад (2008).

Хүн амын төрөлт 1970-аад оны дунд үеэс буурч эхэлсэн нь Засгийн газраас төрөлт, гэр бүлийг дэмжих бодлогод тодорхой өөрчлөлт оруулсан үетэй давхцаж байна. Хүн амын өсөлтийг урамшуулах бодлого ерөнхийдөө хадгалагдаж байсан ч 1976 онд ерөндөг суулгахыг хуулиар зөвшөөрсөн нь бодлогын чухал өөрчлөлт байв. Гэхдээ уг зохицуулалт нь тодорхой нөхцөлтэй байсан. Тухайлбал эрүүл мэндийн шалтгаанаар жирэмслэх боломжгүй, хэт орой жирэмсэлсэн, эсвэл тав ба түүнээс дээш удаа жирэмсэлж байсан эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал байдлаар зөвшөөрч байжээ (Ньюперт 1996, х. 36; Гэрэлтуяа болон бусад 2007, х. 802).

Цаашлаад, 1985 онд тав ба түүнээс дээш хүүхэдтэй, эсхүл нөхөр нь хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл нөхөргүй гурваас дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд үр хөндөлтийг хуулиар зөвшөөрсөн байна. Үүний зэрэгцээ үр хөндөлт, жирэмслэлтээс хамгаалах эмийг худалдах, хэрэглэх, импортлоход тавьж байсан бүх хоригийг цуцалсан нь төрөлтийн


<sup>2</sup> Монгол Улсад жирэмслэхээс хамгаалах дааврын эм уух аргыг 1969 онд хориглосон (ЗХУ 1974 онд хориглосон) (Ньюперт 1994, х. 18)

<sup>3</sup> 1943-1985 онд үр хөндөлтийг хатуу хориглодог байсан ба зөвхөн эрүүл мэндийн шалтгаантай тохиолдолд зөвшөөрдөг байсан

түвшинд бодит нөлөө үзүүлжээ. Үүний үр дүнд 1960–1970-аад онд нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн дундаж тоо 7–8 байсан бол 1989 он гэхэд 4.6 болж буурсан байна.

Монгол Улс 1990 оноос ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэн. Үүний дараа, ялангуяа, 1992 оноос жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл чөлөөтэй нэвтэрч эхэлсэн нь төрөлтийн түвшинд хүчтэй нөлөө үзүүлсэн. Жишээлбэл, 1993 он гэхэд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2.53 болж огцом буурч, 2002 онд нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшин болох 2.1-д хүрэн, 2005 онд 1.95 болж түүхэн доод цэгтээ хүрсэн. Харин түүнээс хойш төрөлтийн түвшин нэмэгдэж, нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2006 онд 2.07, 2007 онд 2.34 болж нэмэгдэн, 2015 онд 3.0-д хүрчээ. Гэвч 2015 оноос хойш төрөлтийн түвшин жилд дунджаар 0.1 орчим хүүхдээр буурсаар, 2024 оны байдлаар нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2.5 болсон байна.

**Зураг 3.5: Монгол Улсын Төрөлтийн нийлбэр коэффициент, 1963-2024**



Эх үүсвэр: 1212.mn

Судалгаагаар Монгол Улсад хийгдсэн НҮЭМС, НҮТС-ын судалгаануудын төрөлтийн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзсэн. ТНК 1998 онд 3.1 байсан бол 2003 онд 2.5 болж буурснаар хүн амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшинд дөхөж байгааг харуулж байсан. Харин дараагийн судалгаануудаар энэ үзүүлэлт нэмэгдэж, 2008 онд 3.2, 2013 онд 3.1, 2018 онд 3.5 болсон. Гэвч 2023 оны судалгаагаар нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2.8 болж, дахин буурах хандлага ажиглагджээ.


**Хүснэгт 3.1: Төрөлтийн түвшин, судалгаа явагдсан онуудаар**

	1998	2003	2008	2013	2018	2023
Насны бүлэг <sup>A</sup>						
15-19 <sup>1</sup>	54.0	53.0	57.0	40.4	42.6	27.6
20-24	216.0	173.0	189.0	168.0	198.9	173.5
25-29	169.0	140.0	181.0	182.7	182.3	185.6
30-34	105.0	82.0	119.0	130.5	149.8	161.3
35-39	50.0	43.0	69.0	75.3	87.7	86.9
40-44	18.0	7.0	16.0	21.9	32.5	31.8
45-49	-	1.0	1.0	1.5	4.2	0.8
ТНК	3.1	2.5	3.2	3.1	3.5	2.8
ТТК	113.0	87.0	113.6	98.5	110.8	101.3
ТЕК	28.5	22.6	31.1	24.6	24.8	20.8

Эх үүсвэр: НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.

НБТК-ийн үзүүлэлтээс харахад, 1998 оны НҮЭМС-ын үр дүнгээр эмэгтэйчүүдийн төрөлт 20–24 насанд хамгийн өндөр байсан бол дараагийн судалгааны онуудад төрөх нас аажмаар хойшилж буй хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, 2023 оны НҮТС-ын судалгаагаар эмэгтэйчүүд ихэвчлэн 25–29 насанд хүүхэд төрүүлж байгаа нь төрөлтийн насны бүтэц өөрчлөгдсөнийг илтгэж байна.

**Зураг 3.6: Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент, судалгаа явагдсан онуудаар**



**Эх үүсвэр:** НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.

Төрөлтийн түвшин нь байршил, бүс нутаг, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамааран харилцан адилгүй байдаг. Нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоог хот, хөдөөгөөр харьцуулбал, тодорхой зөрүү ажиглагдаж байна. Тухайлбал, 2013 онд энэ үзүүлэлт хотод 2.9, хөдөөд 3.6 буюу бараг нэг хүүхдийн зөрүүтэй байсан бол 2018 онд уг зөрүү 0.5 хүүхэд болж, 2023 онд 0.3 хүүхэд болж буурсан. Энэ нь сүүлийн жилүүдэд хот, хөдөөгийн төрөлтийн ялгаа аажмаар багасах хандлага байгааг харуулж байна.

**Хүснэгт 3.2: Төрөлтийн түвшин, хот, хөдөөгөөр, судалгаа явагдсан онуудаар**

Насны бүлэг <sup>A</sup>	2013		2018		2023	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
15-19 <sup>1</sup>	31.2	68.0	34.7	70.1	25.5	38.6
20-24	149.8	216.9	184.2	240.8	162.7	212.7
25-29	173.4	199.1	167.4	220.0	181.4	201.7
30-34	125.3	139.8	151.4	145.9	161.6	160.3
35-39	79.8	67.3	88.0	87.2	86.5	88.1
40-44	23.5	19.2	38.7	21.3	35.0	23.9
45-49	0.7	3.0	5.8	1.1	1.1	0.2
ТНК (15-49 нас) <sup>b</sup>	2.9	3.6	3.4	3.9	3.3	3.6
ТТК (15-49 нас) <sup>c</sup>	93.0	109.5	108.3	116.6	102.0	99.1
ТЕК <sup>d</sup>	24.5	24.7	25.3	23.8	21.4	19.0

**Эх үүсвэр:** НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.

Төрөлтийн түвшний ялгаатай байдлыг Хүснэгт 3.3-т үзүүлэв. Төрөлтийн түвшин хот, хөдөөгөөр ялгаатайгаас гадна бүс нутгийн хэмжээнд ч тодорхой ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, Баруун бүсэд төрөлтийн түвшин бусад бүсүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр, ойролцоогоор 4 орчим байхад Улаанбаатар хотод хамгийн доогуур буюу 3 орчим байна. Харин бусад гурван бүсэд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж

тоо ойролцоо түвшинд, 3.3–3.7 орчим байна. Мөн 2018 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад Төвийн бүс болон Улаанбаатар хотод нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо буурсан бол бусад бүсүүдэд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдахгүй байна.

### Хүснэгт 3.3: Судалгааны өмнөх 3 жил дэх ТНК (15-49 нас), Монгол Улс

	1998	2003	2008	2010	2013	2018	2023
Бүгд	3.1	2.5	3.2	3.1	3.1	3.5	3.3
Байршил							
Хот	2.5	2.1	3.0	2.9	2.9	3.4	3.3
Нийслэл	-	-	-	2.7	2.9	3.3	3.0
Аймгийн төв	-	-	-	3.5	3	3.6	3.7
Хөдөө	3.7	2.9	3.6	3.6	3.6	3.9	3.6
Сумын төв	-	-	-	3.3	3.4	4.0	3.6
Хөдөөгийн баг	-	-	-	3.8	3.7	3.9	3.6
Бүс							
Баруун	3.9	2.9	3.9	3.8	3.6	3.9	3.9
Хангай	3.5	3.0	3.1	3.3	3.2	3.7	3.7
Төв	3.2	2.6	3.2	3.8	3.4	3.8	3.3
Зүүн	3.0	2.8	3.1	3.4	3.3	3.8	(4.1)
Улаанбаатар	2.2	1.9	3.0	2.7	2.9	3.3	3.0
Боловсрол							
Боловсролгүй				2.7	(*)	3.4	3.1
Бага	3.4	3.2	3.6	3.9	(3.9)	2.6	4.2
Суурь	3.8	2.8	3.1	3.1	3.2	3.9	3.7
Бүрэн дунд	2.9	2.4	3.2	3.7	3.1	3.5	3.4
Техникийн болон мэргэжлийн				2.7	3.3	4.3	3.9
Дээд	2.8	2.4	3.2	3.0	3.2	3.7	3.8
Үйлдлийн чадвар (18-49 нас)							
Хүндрэлтэй	-	-	-	na	na	3.0	2.9
Хүндрэлгүй	-	-	-	na	na	3.6	3.4
Өрхийн тэргүүний үндэс угсаа							
Халх	-	-	-	3.0	3	3.4	3.2
Казах	-	-	-	3.7	(3.4)	3.9	4.8
Бусад	-	-	-	3.4	3.4	3.6	3.5
Өрхийн аж байдлын түвшин							
Доогуур	-	-	-	3.9	3.8	4.0	4.1
Дунджаас доогуур	-	-	-	3.4	3.2	3.6	3.7
Дундаж	-	-	-	3.2	3	3.7	3.5
Дунджаас дээгүүр	-	-	-	2.3	2.8	3.0	2.8
Дээгүүр	-	-	-	3.0	2.9	3.3	2.8

Эх үүсвэр: НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.

Амьжиргааны түвшнээр ангилсан төрөлтийн мэдээллийг 2010 оноос хойш тогтмол цуглуулж эхэлсэн. Түүнээс өмнөх мэдээлэл нь бусад судалгааны үр дүнтэй шууд харьцуулах боломж хязгаарлагдмал байдаг. Төрөлтийн үзүүлэлтийг эмэгтэйчүүдийн амьжиргааны түвшнээр харвал, амьжиргааны түвшин доогуур эмэгтэйчүүдийн хувьд төрөлтийн түвшин харьцангуй өндөр байна. Тухайлбал, 2023 оны байдлаар доогуур амьжиргаатай өрхийн эмэгтэйчүүдийн нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 4.1 байсан бол амьжиргааны түвшин ахихын хэрээр энэ үзүүлэлт буурч, дээгүүр амьжиргаатай өрхийн эмэгтэйчүүдийн хувьд 2.8 болжээ. Ерөнхийдөө, доогуур амьжиргаатай өрхийн эмэгтэйчүүдийн нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо судалгаа бүрт хамгийн өндөр түвшинд, ойролцоогоор 3.8–4.1-ийн хооронд байна.

Боловсролын түвшнээр авч үзвэл, бага боловсролтой эмэгтэйчүүдийн нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо бусад боловсролын түвшний эмэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр байна. Тухайлбал, 2023 оны байдлаар бага боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 4.2 байхад дээд, мэргэжлийн болон техникийн боловсролтой эмэгтэйчүүдийнх 3.8–3.9-ийн хооронд байна. Мөн өрхийн тэргүүний онцлогоор харвал, казах өрхийн хувьд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо харьцангуй өндөр 2023 онд ойролцоогоор 5 орчим байжээ.

Дээрх хүснэгтэд харуулсан нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлүүд нь төрөлтөд шууд бус, дам нөлөө үзүүлдгийг өмнө дурдсан гэдгийг энд дахин онцлон тэмдэглэх нь зүйтэй. Харин төрөлтөд шууд нөлөө үзүүлдэг завсрын хүчин зүйлсийг Монгол Улсын төрөлтийн шинжилгээний дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

## **БҮЛЭГ 4: ТӨРӨЛТӨД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ**

Монгол Улсын хүн амын төрөлтийн шинжилгээнүүдийг (дэлгэрэнгүй арга зүйг Бүлэг 1-ээс харна уу) хийж, үр дүнг танилцуулж байна.

Төрөлтөд нөлөөлөх завсрын хүчин зүйлсийг Бонгаарцын загвараар улсын хэмжээнд болон хот, хөдөөгөөр тооцож, төрөлтийн түвшинд аль хүчин зүйл хэрхэн нөлөөлж байгааг харьцуулан үнэлэв.

Төрөх насыг хойшлуулахтай холбоотой темпо нөлөөг Bongaarts–Feeney аргаар засварлаж, темпо-зассан ТНК\*-ийг тооцсон. Ингэснээр тухайн жилийн ажиглагдсан ТНК-ээс темпо нөлөөг салгаж, бодит төрөлтийн түвшинг илэрхийлэх боломж бүрдсэн.

Квантум индексийг тооцохдоо 1991 оны түвшинг суурь болгон хугацааны бүлгүүдээр тооцож, хүүхдийн тооны бодит шийдвэр (quantum) болон төрөх насыг хойшлуулах темпо өөрчлөлтийн чиглэл, эрчийг ялган үнэлсэн.

Төрөлтийн түвшний өөрчлөлтийг (i) хүмүүсийн зан төлөв буюу хэдэн хүүхэдтэй болох, хэдэн насандаа төрөх шийдвэр, (ii) нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн насны бүтцийн нөлөө гэсэн хоёр эх үүсвэрт хуваан задлан шинжилж, аль үед аль хүчин зүйл давамгайл нөлөөлснийг тодорхойлов.

Жил бүр төрсөн хүүхдийг эхийн насны бүлгээр (15–49) ангилан, нийт төрөлтөд эзлэх хувь нэмэр болон түүний цаг хугацааны өөрчлөлтийг үнэлсэн. Үүний үр дүнд бодлогын дэмжлэг, үйлчилгээ аль насны бүлэгт илүү шаардлагатайг тодорхойлох суурь болох юм.

Жил бүрийн оргил төрөх насыг тодорхойлон, түүний шилжилтийг ажигласнаар төрөх насыг хойшлуулах темпо өөрчлөлтийн чиглэл, хэмжээг тогтоов. Энэхүү үр дүнг эрүүл мэнд, хүүхэд асаргаа, уян хатан хөдөлмөр, орон сууц, санхүүгийн дэмжлэг зэрэг бодлогын нөөцийг насны бүлгээр болон цаг хугацаанд нь оновчтой чиглүүлэхэд ашиглана.

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг төрсөн оноор нь бүлэглэн, үелрэл-ТНК (CFR)-ийг тооцсон. Энэ арга нь эмэгтэйчүүд нөхөн үржихүйн насаа бүрэн гүйцээх хугацаанд амьдралынхаа туршид хэдэн хүүхэд төрүүлж буйг харуулж, нэг үеийн ТНК-ээс ялгаатайгаар урт хугацааны өөрчлөлт, хандлагыг нарийвчлан шинжлэх боломж олгосон.


### **4.1 Төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс: Бонгаарцын загварын шинжилгээ**

Бонгаарц (1978)-ын үзсэнээр завсрын хүчин зүйлс болох гэрлэлт, жирэмслэлтээс сэргийлэх арга (ЖСАХ), үр хөндөлт, түр үргүйдэл нь төрөлтийн түвшинг байгалийн буюу онолын хувьд хамгийн өндөр төрөлт (15.3)-өөс доогуур байхад нөлөөлдөг. Энэхүү загварыг ашиглан Монгол Улсын төрөлтийн түвшинд шинжилгээ хийж, гарсан үр дүнг танилцуулж байна.

Зургаас харахад, 2023 оны байдлаар Монгол Улсад нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 3.9 байна. Энэ нь онолын хувьд байж болох хамгийн өндөр төрөлтийн түвшин 15.3 гэж үзвэл төрөлтийн түвшин жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл (ЖСАХ)-ийн хэрэглээний нөлөөгөөр 6.2 хүүхэд, гэрлээгүй байдалтай холбоотойгоор 2.6

хүүхэд, хөхөөр хооллолтоос үүдсэн түр үргүйдлийн нөлөөгөөр 1.3 хүүхэд, харин үр хөндөлтийн улмаас 0.6 хүүхдээр тус тус буурсан байна гэсэн үг.

**Зураг 4.1: Төрөлтөд нөлөөлөгч завсрын хүчин зүйлс, Бонгаарцын загвараар, судалгаа явагдсан онуудаар**



Эх үүсвэр: 2003, 2008 оны тооцооллыг Томас Спооренбергийн тооцооллоос авав. 2013, 2018, 2023 оны тооцооллыг НҮТС-ний мэдээлэлд үндэслэн судлаачид өөрөө тооцов.

Үүнийг 2003 оноос хойшхи хугацаагаар харьцуулан харвал, ЖСАХ-ийн нөлөө бага зэрэг суларсан бол гэрлэлтийн нөлөө харьцангуй нэмэгдсэн байна. Тухайлбал, 2003 онд гэрлэлтийн нөлөөгөөр төрөлт 1.6 хүүхдээр буурч байсан бол 2023 онд энэ үзүүлэлт 2.6 болж өсчээ.

Хүснэгт 4.1-ээр төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн нөлөөллийн хувь хэмжээг харуулав. Хүснэгтээс харахад, 2023 оны байдлаар ЖСАХ-ийн хэрэглээ төрөлтийн түвшинг 49.2 хувиар, гэрлэлт (гэрлэхгүй байх) 37.3 хувиар, түр үргүйдэл 10 орчим хувиар, үр хөндөлт 2.9 хувиар тус тус бууруулсан байна. Бусад онуудтай харьцуулахад, ЖСАХ-ийн нөлөө харьцангуй тогтвортой байгаа бол гэрлэлтийн нөлөө 2003 оноос хойш нэмэгдсээр байна.

**Хүснэгт 4.1: Төрөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйлсийн log утга болон өөрчлөлтөд эзлэх хувь, 2008-2023 онд**


log-н утга	2003	2008	2013	2018	2023	Өөрчлөлтөд эзлэх хувь	2003	2008	2013	2018	2023
$C_m$	-	-	-	-	-	Гэрлэлт	29.9	33.5	33.9	38.9	37.3
$C_c$	0.274	0.242	0.231	0.238	0.218	ЖСАХ	54.7	48.3	50.6	48.2	49.2
$C_a$	-	-	-	-	-	Үр хөндөлт	5.9	7.00	7.9	3.3	2.9
$C_i$	0.054	0.051	0.054	0.020	0.058	Түр үргүйдэл	9.5	11.2	7.6	9.6	10.6

Эх үүсвэр: 2003, 2008 оны тооцооллыг Томас Спооренбергийн тооцооллоос авав. 2013, 2018, 2023 оны тооцооллыг НҮТС-ний мэдээлэлд үндэслэн судлаачид өөрөө тооцов.

Тухайлбал, 2003 онд гэрлэхгүй байснаар төрөлтийг 30 орчим хувиар бууруулж байсан бол 2008 онд 33.5 хувь, 2018 онд 38.9 хувь, 2023 онд 37.3 хувиар тус тус бууруулжээ. Энэ нь Монгол Улсад сүүлийн жилүүдэд ажиглагдаж буй төрөлтийн түвшний бууралтад гэрлэлт голлох нөлөөтэй болж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, гэрлэсэн хүн амын эзлэх хувийн жин буурч, гэрлэлтийн нас хойшилж байгаатай холбоотой.

Үр хөндөлтийн нөлөөгөөр төрөлтийн түвшин 2003 онд 5.9 хувиар буурч, түүний нөлөө бусад завсрын хүчин зүйлстэй харьцуулахад харьцангуй бага, 2.9–7.9 хувийн хооронд хэлбэлзэж байна. Харин түр үргүйдлийн төрөлтийн түвшинг бууруулж буй хувь 2003 онд 9.5 байсан бол 2013 онд 7.6 хувь, 2018 онд 9.6 хувь, 2023 онд 10.6 хувь болжээ. Энэ нь эмэгтэйчүүдийн хүүхдээ хөхөөр хооллох дундаж хугацаатай холбоотой.


**Зураг 4.2: Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн нөлөөлж буй хувь, Бонгаарцын загвараар, судалгаа явагдсан онуудаар**



*Эх үүсвэр: 2003, 2008 оны тооцооллыг Томас Спооренбергийн тооцооллоос авав. 2013, 2018, 2023 оны тооцооллыг НҮТС-ний мэдээлэлд үндэслэн судлаачид өөрөө тооцов.*

Бонгаарцын загварыг хот, хөдөөгийн ангиллаар 2013, 2018, 2023 онуудаар тооцож, гарсан үр дүнг Зураг 4.3-т харуулав. Үр дүнгээс харахад, хөдөө орон нутагт хоттой харьцуулахад ЖСАХ-ийн төрөлтийн түвшинд үзүүлэх нөлөө харьцангуй өндөр байгаа бол хот суурин газарт гэрлэлтийн хүчин зүйлийн нөлөө илүү давамгайлж байна.

**Зураг 4.3: Төрөлтөд нөлөөлөгч хүчин зүйлс, Бонгаарцын загвараар, хот, хөдөөгөөр, судалгаа явагдсан онуудаар**



*Эх үүсвэр: НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.*

Төрөлтөд нөлөөлөх завсрын хүчин зүйлсээс гэрлэлтийн (гэрлэхгүй байх) нөлөө хот, хөдөө аль алинд нь өсөж байна. Тухайлбал, 2013 онд төрөлтийн түвшинг хот суурин газарт гэрлэлт 35.2 хувиар бууруулсан бол 2018 онд 42.2 хувиар, 2023 онд 39.3 хувиар тус тус бууруулжээ. Хөдөө орон нутагт уг үзүүлэлт 28.7 хувиас 37.2 хувь болж тасралтгүй өсжээ. Харин төрөлтөд хамгийн их нөлөө үзүүлдэг ЖСАХ-ийн нөлөө хот, хөдөөд ялгаагүй бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Мөн хот, хөдөөгийн хувьд үр хөндөлт болон хөхөөр хооллолтоос үүдэлтэй түр үргүйдлийн нөлөө харилцан адилгүй байна. Тодруулбал, хот суурин газарт үр хөндөлтийн нөлөө хөдөөгөөс өндөр байхад хөдөө орон нутагт түр үргүйдлийн нөлөө хоттой харьцуулахад илүү өндөр байгаа нь ажиглагдаж байна.

**Хүснэгт 4.2: Төрөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйлсийн log утга болон өөрчлөлтөд эзлэх хувь, хот хөдөөгөөр, 2008-2023 онд**

log-н утга	2013	2018	2023	Өөрчлөлтөд эзлэх хувь	2013	2018	2023
<b>Хот</b>							
C <sub>m</sub>	-0.240	-0.243	-0.224	Гэрлэлт	35.2	42.2	39.3
C <sub>c</sub>	-0.321	-0.262	-0.276	ЖСАХ	47.2	45.4	48.5
C <sub>a</sub>	-0.072	-0.030	-0.021	Үр хөндөлт	10.6	5.2	3.8
C <sub>i</sub>	-0.048	-0.042	-0.048	Түр үргүйдэл	7.1	7.2	8.5
<b>Хөдөө</b>							
C <sub>m</sub>	-0.205	-0.227	-0.244	Гэрлэлт	28.7	32.7	37.2
C <sub>c</sub>	-0.418	-0.367	-0.317	ЖСАХ	58.5	52.9	48.3
C <sub>a</sub>	-0.033	-0.015	-0.010	Үр хөндөлт	4.6	2.2	1.6
C <sub>i</sub>	-0.058	-0.084	-0.084	Түр үргүйдэл	8.2	12.2	12.9

Эх үүсвэр: НҮБТС, НҮТС-ын мэдээлэлд тулгуурлан судлаач өөрөө тооцоолов.

**4. 2 Төрөлтийн түвшин ба темпо өөрчлөлт**

Монгол Улсын нийт төрөлтийн түвшин сүүлийн гурван арван жилд огцом өөрчлөгдөж, 1990 оны түвшнээс 2024 онд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж тоо 2.5 хүртэл буурсныг өмнө дурдсан. Гэвч төрөлтийн бууралт, хэлбэлзлийн шалтгааныг зөв тодорхойлоход нэг л хэмжүүрийг дангаар ашиглах нь хангалтгүй юм. Иймээс энэхүү шинжилгээнд ажиглагдсан ТНК, төрөх насны шилжилтийн нөлөөг арилгасан темпо-зассан ТНК\*, төрөх насыг хойшлуулах индекс, түүний өөрчлөлтөнд квантум ба темпо нөлөөний хувь нэмэр, мөн ТНК-ийн өөрчлөлтийг зан төлөв ба насны бүтцийн бүрэлдэхүүн хэсгүүдэд задлах Китагавын (Kitagawa) задаргаа, түүнчлэн насны бүлгүүд дэх төрөлтийн тархалт болон оргил насны шинжилгээг цогцоор нь ашиглав. Ингэснээр, богино хугацааны хэлбэлзлийг урт хугацааны үндсэн чиг хандлагаас ялган тайлбарлах боломж бүрдсэн юм. Энэхүү цогц дүн шинжилгээ нь 1990–2024 оны төрөлтийн статистикийн тоон мэдээлэлд тулгуурласан болно.


**4.2.1 Төрөлтийн ажиглагдсан ба темпо-зассан (ТНК\*) түвшний харьцуулалт**

Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшний өөрчлөлт 1990–2024 оны хугацаанд гурван тодорхой ялгаатай үе шатаар өрнөсөн байна. Эдгээр нь хүн ам зүйн шилжилтийн онолоор тайлбарладаг төрөлтийн түвшин өндөр түвшнээс бага түвшинд шилжих ерөнхий чиг хандлагыг дагаж байгааг харуулж байна.

Зураг 4.4-т тухайн жилийн ажиглагдсан ТНК-ийг богино хугацаанд төрөх нас шилжсэнээс үүдэх “темпо” нөлөөг шүүж арилгасан темпо-зассан ТНК\*-тэй зэрэгцүүлэн харуулав. Эхний үе шат болох 1990–2005 онд нэг эмэгтэйн төрүүлэх хүүхдийн дундаж

тоо 4.42-оос 1.95 хүртэл огцом буурч, хүн амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшин болох 2.1-ээс доош орсон.

**Зураг 4.4: Ажиглагдсан ТНК ба темпо-зассан ТНК\*-ийн харьцуулалт, 1990–2024**



**Эх үүсвэр:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Хоёрдугаар үе шат буюу 2005–2019 онд төрөлтийн түвшин харьцангуй тогтворжиж, бага зэргийн өсөлт ажиглагдан, ойролцоогоор 2.5 орчимд хэлбэлзэж байв. Харин гуравдугаар үе шат болох 2020–2024 онд төрөлтийн түвшин дахин буурах хандлагад шилжиж, дунджаар 2.32 хүртэл буурсан байна.

Темпо-зассан ТНК\* болон ажиглагдсан ТНК-ийн хоорондын зөрүү нь төрөлтийн цаг хугацааны буюу темпо нөлөөг шүүн арилгаж, эмэгтэйчүүдийн бодит төрөх хүслийг илүү тодорхой илэрхийлэх хүн ам зүйн чухал хэмжүүр болдог. Монгол Улсын хувьд энэхүү хоёр үзүүлэлтийн харьцуулалт нь төрөлтийн өөрчлөлтөд хамаарах гурван үндсэн хэв маяг ажиглагдаж байгааг харуулж байна (Б. Энхцэцэг, Г.Пагмадулам, 2017).


- Эхний хэв маяг болох 1990-2005 оны хугацаанд темпо-зассан ТНК\* ажиглагдсан ТНК-ээс тогтмол өндөр байж, дундажаар 0.3-0.6 пунктээр илүү байсан нь төрөх насыг хойшлуулсны улмаас ажиглагдсан коэффициент бодит төрөх хүслээс доогуур харагдаж байсныг илтгэж байна. Энэ үед зөрүү хамгийн их болж, ялангуяа 1996-2000 онд 0.7-0.8 пунктийн зөрүүтэй болсон нь эдийн засгийн шилжилт, хүндрэлийн үетэй холбоотой байж боломжтой.
- Хоёрдугаар хэв маяг болох 2005-2019 оны нөхөлтийн үед харьцаа эсрэгээр солигдож, ажиглагдсан ТНК темпо-зассан ТНК\*-ээс 0.1-0.4 пунктээр өндөр байж, хойшлогдсон төрөлтийн нөхөлт явагдаж байв. Хамгийн их нөхөлт 2008-2012 онд ажиглагдаж, энэ үед +0.5 пункт хүртэлх зөрүү ажиглагдсан.
- Гуравдугаар хэв маяг болох 2020-2024 онд төрөлтийн зөрүүний байдал дахин анхны байдалдаа буцаж, темпо-зассан ТНК\* ажиглагдсан ТНК-ийг давж эхэлсэн нь шинэ хойшлуулалтын давалгаа эхэлж буйг баталгаажуулж байна. Тухайлбал, 2024

онд энэ зөрүү 0.15 пункт хүртлээ нэмэгдсэн нь төрөлтийн түвшин цаашид буурах хандлага эхэлснийг анхааруулж буй хэрэг юм.

#### 4.2.2 Темпо нөлөөний хэмжээ (Tempo Effect Share)

Шинжилгээнд 1990–2024 оны хугацаанд ТНК-д ажиглагдсан богино хугацааны огцом өсөлт, бууралтын хэдэн хувийг темпо буюу төрөх насны шилжилтийн нөлөө тайлбарлаж байгааг тооцох нь бодит төрөлтийн түвшнийг зөв үнэлэхэд зайлшгүй шаардлагатай. Иймээс темпо нөлөөг шүүн арилгасан төрөлтийн түвшин (ТНК\*)-д темпо өөрчлөлт хэдэн хувийн нөлөө үзүүлснийг тооцож, үр дүнг Зураг 4.5-д дүрслэн харуулав.

**Зураг 4.5: Жил тутмын ТНК дэх темпо өөрчлөлтийн нөлөөний хувь хэмжээ, 1990–2024.**



**Эх үүсвэр:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Зургаас харахад темпо нөлөөний хувь хэмжээ 1990–2024 оны хооронд нэлээд их хэлбэлзэлтэй байжээ. Энэхүү хэлбэлзэл тод илэрсэн гол үе шатуудад темпо нөлөөний хувь хэмжээ дараах байдлаар ажиглагдаж байна. Үүнд:


- Төрөлтийн огцом бууралтын үед, тухайлбал 1992 онд ажиглагдсан ТНК 3.57 байсан бол темпо нөлөөг арилгасан бодит төрөлтийн түвшин (ТНК\*) 2.82 буюу эмэгтэйчүүд дунджаар 2–3 хүүхэд төрүүлэх хандлагатай байсныг харуулж байна. Энэ хоёр үзүүлэлтийн зөрүү нь шилжилтийн эхэн үед ажиглагдсан төрөлтийн нийт бууралтын (–26.7 хувийн зөрүү) дөрөвний нэгээс илүү нь төрөх нас хойшилсонтой холбоотой темпо нөлөөнөөс шалтгаалсныг илтгэнэ.
- Төрөлт өсөлттэй 2014 онд ажиглагдсан ТНК 3.01 байсан бол темпо нөлөөг арилгасан бодит төрөлтийн түвшин (ТНК\*) 4.71-д хүрчээ. Хоёр үзүүлэлтийн хоорондын +36.1 хувийн зөрүү нь темпо нөлөөгөөр тайлбарлагдах бөгөөд өмнөх жилүүдэд хойшлогдсон төрөлтийн “нөхөлт” нэг дор илэрснээр ажиглагдсан өсөлтийг бүрэн тайлбарлаж болохыг харуулж байна.
- Төрөлтийн хэт хэлбэлзэл аажмаар тогтворжиж эхэлсний дараах сүүлийн жилүүдэд ажиглагдсан бууралтын ойролцоогоор зургааны нэг буюу 13.9 хувь нь темпо нөлөөгөөр тайлбарлагдаж байна. Харин энэхүү бууралтын цаад шалтгаан нь төрөх насны шилжилт зэрэг цаг хугацааны хүчин зүйл үү, эсвэл төрөлтийн бодит тоо, зан

төлөвийн өөрчлөлттэй холбоотой квантум нөлөө юу гэдгийг темпо ба квантум нөлөөг тусад нь задалж шинжилснээр илүү тодорхой тайлбарлах боломжтой юм.

### 4.2.3 Төрөлтийн өөрчлөлт дэх темпо ба квантум нөлөө

ТНК-ийн өөрчлөлтийг темпо (цаг хугацааны хүчин зүйл) болон квантум (тооны хүчин зүйл) гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүнд задлан шинжлэх нь төрөлтийн бууралт, өсөлтийн жинхэнэ шалтгааныг тодорхойлох чухал арга зүй<sup>4</sup> юм. Темпо нөлөө нь эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх насыг хойшлуулах эсвэл түргэсгэхтэй холбоотой цаг хугацааны өөрчлөлтийг илэрхийлдэг бол квантум нөлөө нь эмэгтэйчүүдийн амьдралын туршид төрүүлэх хүүхдийн нийт тоонд гарч буй бодит өөрчлөлтийг тусган харуулдаг.

**Зураг 4.6: Төрөлтийн түвшин дэх өөрчлөлт, бодит ба нас хойшлуулалтын нөлөөгөөр, 5 жилийн хугацааны чиг хандлагаар, 1990–2024**



**Эх сурвалж:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

**Хугацааны чиг хандлага:** ТНК 1990–1994 оны хооронд нийт 1.62 пунктээр буурахад үүний 31 хувийг квантумын нөлөө, 69 хувийг темпо нөлөө тайлбарлаж байна. Энэ нь шилжилтийн эхний үед эмэгтэйчүүд төрүүлэх хүүхдийнхээ тоог бодитоор цөөрүүлэхээс илүүтэйгээр төрөх хугацааг хойшлуулах хандлага давамгайлж байсныг илтгэнэ. Тухайн үед темпо нөлөө  $-1.11$  пунктэд хүрсэн нь эдийн засгийн хүнд нөхцөл байдал төрөлтийн цаг хугацаанд хүчтэй нөлөөлснийг тод харуулж байна.

Харин 1995–1999 оны хугацаанд энэ харьцаа эсрэгээр өөрчлөгдөж, төрөлтийн бууралтын 96 хувийг квантумын бууралт ( $-0.44$  пункт), ердөө 4 хувийг темпо нөлөө ( $-0.02$  пункт) тайлбарласан байна. Энэ нь эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх хугацааг түр хойшлуулах бус, харин амьдралынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоог бодитоор цөөрүүлэх шийдвэр гаргаж эхэлснийг илтгэж байна.

**Нөхөлтийн үеийн онцлог:** Төрөлтийн өсөлт ажиглагдсан 2005–2009 оны хугацаанд нийт ТНК  $+0.76$  пунктээр нэмэгдэхэд үүний 92 хувийг темпо нөхөлт ( $+0.70$ ), харин ердөө 8 хувийг квантумын өсөлт ( $+0.06$ ) бүрдүүлсэн нь өмнөх жилүүдэд хойшлогдсон

<sup>4</sup>  $\Delta$  ТНК = квантумын өөрчлөлт ( $\Delta$ Quantum) + темпо нөлөө ( $\Delta$ Tempo)

төрөлт идэвхтэйгээр нөхөгдөж байсныг баталж байна. Энэ хугацаанд эмэгтэйчүүдийн амьдралын туршид төрүүлэх хүүхдийн тооны талаарх бодит шийдвэр бараг өөрчлөгдөөгүй боловч хойшлогдсон төрөлтүүд цаг хугацааны хувьд нөхөгдсөн байна.

Үүний дараах 2010–2014 оны үед квантум болон темпо нөлөө эсрэг чиглэлтэй үйлчилж, квантумын эерэг өөрчлөлт (+1.11 пункт) нь темпо нөлөөний сөрөг нөлөөг (–0.52 пункт) давснаар нийт төрөлтийн түвшин +0.59 пунктээр өсжээ. Энэхүү өөрчлөлт нь эмэгтэйчүүдийн хүүхдийн тооны талаарх бодит шийдвэр эергээр өөрчлөгдөж, төрөх насыг цаашид хойшлуулах хандлага саарсан үеийг илэрхийлж байна.

**Сүүлийн жилүүдийн бууралт:** Сүүлийн үе шат болох 2020–2024 оны хугацаанд ажиглагдсан нийт бууралт (–0.43 пункт) нь голчлон квантумын сөрөг өөрчлөлтөөс (–0.58 пункт) шалтгаалсан бол темпо нөлөө харьцангуй бага хэмжээгээр эерэг (+0.15 пункт) байжээ. Өөрөөр хэлбэл, нийт бууралтын 135 хувийг квантумын нөлөө тайлбарлаж, харин темпо нөлөө –35 хувиар бууралтыг тодорхой хэмжээнд сааруулсан байна. Энэ дүн нь өнөөгийн төрөлтийн бууралт нь өмнөх жилүүдэд хойшлогдсон төрөлтийн нөхөлт дууссантай бус, харин эмэгтэйчүүдийн амьдралын туршид төрүүлэх хүүхдийн тооны талаарх бодит шийдвэр буурсантай холбоотойг илтгэж байна.

**Квантум индексийн хэлбэлзэл:** Квантум индексийг 1991 оны ТНК\*-ийн суурь түвшинг 3.6 гэж тооцоход уг индекс 2001–2005 онд хамгийн доод хэмжээнд буюу 64.8 хувьд хүрч, улмаар аажмаар сэргэсээр 2011–2015 онд 94.9 хувь болсон байна. Харин 2021–2024 оны сүүлийн хугацаанд квантум индекс 86.3 хувь болж буурсан нь эмэгтэйчүүдийн амьдралын туршид төрүүлэх хүүхдийн тооны талаарх хүсэл дахин сулран буурч эхэлснийг илтгэж байна.

Энэхүү задаргаанаас үзэхэд, Монгол Улсын төрөлтийн өөрчлөлт нь цаг хугацааны явцад өөр өөр механизмээр явагдаж ирсэн, тухайлбал, 1990-ээд оны эхэн үед темпо нөлөө давамгайлж, 2000-аад оны сүүл үеэс квантум нөлөө голлох болсон бол сүүлийн жилүүдэд квантумын бууралт дахин зонхилж байна. Иймээс хүн амын бодлого боловсруулахдаа эдгээр үе шат бүрд илэрч буй ялгаатай хүчин зүйлсийг онцгойлон харгалзан үзэх шаардлагатайг уг шинжилгээ тодорхой харуулж байна (Хавсралт Хүснэгт А2).

#### 4.2.4 Kitagawa хоёр бүрэлдэхүүний шинжилгээ: Насны бүтэц ба төрөх зан төлөв

Kitagawa-ийн аргын шинжилгээ нь ТНК-ийн өөрчлөлтийг төрөлтийн зан төлвийн өөрчлөлт болон насны бүтцийн өөрчлөлтөөр задлан тайлбарлах боломж олгодог, хүн ам зүйн ач холбогдол өндөртэй арга зүй юм. Энд төрөлтийн зан төлөв гэдэгт эмэгтэйчүүд хэдэн хүүхэд төрүүлэх, хэдэн насанд төрөх, төрөлтийн дарааллаа хэрхэн төлөвлөх зэрэг бодит шийдвэр, үйлдлийг хамтад нь ойлгодог. Уг аргыг ашигласнаар төрөлтийн өөрчлөлт нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн насны бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалсан уу, эсвэл тэдний хүүхэд төрүүлэх талаарх бодит шийдвэр, зан төлөв өөрчлөгдсөнөөс үүдэлтэй юу гэдэг асуултад тодорхой хариулт өгөх боломж бүрддэг.

Хүснэгт 4.3-аар 1990-2024 оны хооронд ажиглагдсан ТНК-ийн өөрчлөлтийн Kitagawa задаргааг, сонгосон интервалаар харуулав. Интервалыг ТНК-н өөрчлөлтийн ерөнхий чиг хандлагатай уялдуулан сонгосон. Хүснэгтээс харахад, 1990–2005 оны хугацаанд

ТНК нийтдээ 2.45 пунктээр буурахад төрөлтийн зан төлвийн өөрчлөлт –0.54 пунктийн сөрөг хувь нэмэр оруулсан бол насны бүтцийн өөрчлөлт ердөө +0.02 пунктийн эерэг нөлөө үзүүлжээ. Энэ нь шилжилтийн үед эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх талаарх шийдвэр, хандлага огцом өөрчлөгдөж, харин нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо, бүтцийн өөрчлөлтийн нөлөө харьцангуй бага байсныг илтгэнэ.

**Хүснэгт 4.3: ТНК-ийн өөрчлөлтийн Kitagawa задаргаа, сонгосон интервалаар, 1990-2024**

Интервал	Эхний ТНК	Сүүлчийн ТНК	ΔТНК	Зан төлвийн өөрчлөлт	Насны бүтцийн өөрчлөлт
1990–2005	4.42	1.97	-2.45	-0.54	+0.02
2005–2015	1.97	3.01	+1.05	+0.22	-0.02
2015–2019	3.01	2.99	-0.03	-0.01	-0.00
2019–2024	2.99	2.32	-0.66	-0.14	+0.00

**Эх сурвалж:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Иймээс уг хугацаанд нийгэм, эдийн засгийн бусад нөхцөл байдал, хүчин зүйлсийн нөлөөгөөр эмэгтэйчүүд хүүхэдтэй болохоо зогсоох эсвэл хойшлуулах шийдвэр гаргаж, төрөлтийн зан төлөв бодитоор өөрчлөгдсөн нь ажиглагдаж байна.

Харин 2005–2015 оны өсөлтийн хугацаанд ТНК нийтдээ 1.05 пунктээр нэмэгдэхэд төрөлтийн зан төлвийн эерэг өөрчлөлт +0.22 пунктийн хувь нэмэр оруулсан бол насны бүтцийн өөрчлөлт –0.02 пунктийн хэмжээтэй бага зэргийн сөрөг нөлөө үзүүлжээ. Энэ үед Засгийн газраас хэрэгжүүлсэн мөнгөн тэтгэмжийн бодлого, эдийн засгийн харьцангуй тогтворжилт, мөн “Алтан гахай” жилийн нөлөө зэрэг хүчин зүйлс эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх хүсэл, шийдвэрт эергээр нөлөөлсөн байх магадлалтай. Насны бүтцийн ажиглагдсан бага хэмжээний сөрөг нөлөө (–0.02 пункт) нь шилжилтийн эхэн үе, ялангуяа 1990-ээд оны эхэн дэх төрөлтийн огцом бууралтаас шалтгаалан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо тодорхой хэмжээгээр цөөрсөнтэй холбоотой боловч уг нөлөө нь төрөлтийн зан төлвийн эерэг өөрчлөлтөөр бүрэн нөхөгдсөн байна.

Төрөлтийн харьцангуй тогтворжилт ажиглагдсан 2015–2019 оны хугацаанд ТНК –0.03 пунктээр бага зэрэг буурахад төрөлтийн зан төлвийн өөрчлөлт –0.01 пунктийн нөлөө үзүүлж, харин насны бүтцийн өөрчлөлт бараг ажиглагдаагүй байна. Энэ нь уг үед эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх талаарх шийдвэр тогтворжиж, нөхөн үржихүйн насны бүтэц ч мөн харьцангуй тогтвортой байсныг илтгэнэ.

Үүний дараах хугацаанд, тухайлбал 2019–2024 онд ТНК –0.66 пунктээр буурахад төрөлтийн зан төлвийн өөрчлөлт –0.14 пунктийн сөрөг хувь нэмэр оруулсан бөгөөд насны бүтцийн өөрчлөлтийн нөлөө мэдэгдэхүйц түвшинд илрээгүй хэвээр байна.

Kitagawa аргын шинжилгээний үр дүнгээс үзэхэд, Монгол Улсын төрөлтийн өөрчлөлтийг тайлбарлах гол хүчин зүйл нь насны бүтэц бус, харин эмэгтэйчүүдийн төрөлтийн зан төлвийн өөрчлөлт болох нь тодорхой харагдаж байна. Энэ нь бодлого боловсруулагчид нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоонд анхаарал төвлөрүүлэхээс илүүтэйгээр эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх хүсэл, боломж, бодит нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Насны бүтцийн нөлөө бүх хугацаанд 0.02-оос ихгүй байгаагаас харахад хүн амын насны бүтэц хурдтай өөрчлөгдөөгүй бөгөөд төрөлтийн бодлогын үндсэн чиглэл


нь нийгэм, эдийн засгийн орчныг сайжруулахад оршиж байгааг энэхүү шинжилгээ баталж байна.

### 4.3 Насны бүтэц ба оргил насны шилжилт

#### 4.3.1 Төрөлтийн насны бүлгийн тархалт

Монгол Улсын төрөлтийн статистикт насны бүлгүүд хоорондын хувь нэмрийн шилжилт нь төрөлтийн хэв маяг гүнзгий өөрчлөгдөж буйг илтгэх чухал үзүүлэлт юм. Зураг 4.7-д 1990–2024 оны хугацаанд жил бүрийн нийт төрөлтөд эхийн насны ялгаатай бүлгүүдийн эзлэх хувийн жин хэрхэн өөрчлөгдөж ирснийг харуулсан чиг хандлагыг дүрслэн үзүүлэв.

**Зураг 4.7: Жил тутмын төрөлтийн насны тархалтын чиг хандлага, насны бүлэг дэх төрөлтийн нийт төрөлтөд эзлэх хувиар, 1990–2024**



**Эх сурвалж:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Төрөлтийн насны бүтцэд ажиглагдах өөрчлөлтөөс харахад, 1990 онд 20–24 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнө нь хамгийн өндөр байсан боловч сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц буурчээ. Тухайлбал, уг насны бүлэг нийт төрөлтийн 33.8 хувийг бүрдүүлж байсан бол сүүлийн байдлаар энэ хувь 18.5 болж, бараг хоёр дахин багассан байна. Харин 25–29 насны бүлгийн хувь нэмэр 33.0 хувиас 27.0 хувь болж тодорхой хэмжээгээр буурсан ч харьцангуй тогтвортой хэвээр хадгалагджээ. Үүний зэрэгцээ 30–34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь 17.8 хувиас 26.7 хувь болж огцом өссөн нь төрөлтийн оргил нас дээд насны бүлгүүд рүү шилжиж буйг тодорхой харуулж байна.

Насны бүлгийн тархалтын шилжилтийн чиг хандлагыг гурван үе шатаар ангилж болно. Үүнд:

- Төрөлтийн насны бүтцэд 20–24 насны бүлэг давамгайлж байсан үе нь 1990–2012 оны хооронд үргэлжилсэн бөгөөд ялангуяа 1995–1999 онд уг насны бүлэг нийт төрөлтийн 37–39 хувийг эзэлж, оргил түвшиндээ хүрсэн байна. Мөн энэ хугацаанд

15–19 насны төрөлт харьцангуй өндөр, 7–9 хувийн түвшинд хадгалагдаж байсан нь залуу насанд төвлөрсөн төрөлтийн хэв маяг зонхилж байсныг илтгэн харуулж байна.

- Хоёрдугаар үе шатанд, өөрөөр хэлбэл 2013–2021 оны хугацаанд 25–29 насны бүлэг төрөлтөд тэргүүлэх байр суурь эзэлж, 2015–2018 онд нийт төрөлтийн 31–32 орчим хувийг бүрдүүлж байв.
- Харин 2022-2023 оны богино хугацаанд 30-34 насны бүлэг түр зуур давамгайлж, 27-28 хувь хувь нэмэр оруулсан нь төрөх насны цаашид хойшлохын дохио болж байна.

Онцгой анхаарал татаж буй өөрчлөлт нь 35–39 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн хувь нэмэр мэдэгдэхүйц нэмэгдсэн явдал юм. Тухайлбал, уг насны бүлгийн эзлэх хувь өмнө 6.9 хувь байсан бол сүүлийн байдлаар 19.4 хувь болж, бараг гурав дахин өссөн нь дэлхийн хөгжингүй орнуудад ажиглагддаг “хожуу төрөлт” (late fertility)-ийн хандлагатай нийцэж байна. Үүний зэрэгцээ 40–44 насны эмэгтэйчүүдийн төрөлт 2.0 хувиас 4.8 хувь болж хоёр дахин нэмэгдсэн нь нөхөн үржихүйн насны дээд хязгаар хүртэл төрөлт өргөжиж байгааг илтгэн харуулж байна.

Насны бүлгүүдийн шилжилт нь хүн амын моментумын нөлөөг тодорхой бий болгож байна. Тухайлбал, 1990-ээд онд харьцангуй цөөн төрсөн үеийнхэн өдгөө нөхөн үржихүйн насанд шилжин орж, тэдний тооны цөөн байдал нь төрөлтийн түвшин буурахад дахин нөлөөлж байна. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд ажиглагдаж буй 35 ба түүнээс дээш насны төрөлтийн өсөлт нь 2000-аад оны эхэн үед харьцангуй олноор төрсөн үеийнхэн хүүхэд төрүүлэхээ хойшлуулсны үр дүн, өөрөөр хэлбэл хожуу төрөлттэй холбоотой байх магадлалтай юм.

Энэхүү насны шилжилтийн үзэгдэл нь зөвхөн статистикийн түвшний өөрчлөлт бус, харин нийгмийн бүтэц, боловсролын тогтолцоо, хөдөлмөр эрхлэлтийн хэв маяг, эрүүл мэндийн системд өрнөж буй цогц өөрчлөлтийг тусгасан чухал үзүүлэлт юм. Иймээс цаашдын хүн ам, нийгмийн бодлого боловсруулахад насны бүлэг бүрийн онцлог хэрэгцээ, эрсдэл, боломжийг ялган харгалзан үзэх шаардлагатайг энэхүү хандлага тодорхой харуулж байна.

#### 4.3.2 Оргил (модал) нас ба темпо шилжилт

Шинжилгээний үр дүнгээс харахад, 1990–2024 оны хугацаанд Монгол Улсын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн төрөлтийн оргил нас 20–24-өөс 25–29, улмаар 30–34 насны бүлэг рүү үе шаттайгаар шилжсэн нь хүүхэд төрүүлэх насыг хойшлуулах үйл явц бодитоор явагдсаныг баталж байна (Хавсралт Хүснэгт А4).

Европын орнуудын туршлагад тулгуурлан Биллари (2004, х. 4) төрөлтийг хойшлуулахад нөлөөлдөг гурван үндсэн хүчин зүйлийг тодорхойлсон байдаг. Үүнд: хүн ам зүйн хоёр дахь шилжилт, эмэгтэйчүүдийн боловсролын түвшний дээшлэлт, мөн залуучуудын дундах ирээдүйн тодорхойгүй байдал орно. Эдгээр хүчин зүйлс Монгол Улсын нөхцөлд ч ажиглагдаж буйг судалгаанууд харуулж байна (Б. Энхцэцэг, 2024). Өөрөөр хэлбэл, төрөлтийн оргил нас хойшлох үйл явц нь Монгол Улсад явагдаж буй төрөлтийн темпо шилжилтийн тод илэрхийлэл бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, боловсролын түвшний ахиц, эмэгтэйчүүдийн амьдралын хэв маягт гарсан хувиралтай салшгүй уялдаа холбоотой юм.

Төрөлтийн оргил нас 1990–2012 оны хугацаанд 20–24 насанд төвлөрч, эмэгтэйчүүд ихэвчлэн залуу насандаа хүүхэд төрүүлж байжээ. Энэ хандлага нь социалист тогтолцооны үеийн хүн амын бодлого, мөн эрт гэрлэх нийтлэг хэв шинжтэй нягт холбоотой юм.

Төрөлтийн оргил нас 2013–2021 оны хугацаанд 25–29 нас руу хойшилсон нь эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших хугацаа уртасч, хөдөлмөр эрхлэлтийн идэвх нэмэгдэх, гэрлэлтийн нас хойшлох, мөн улс орны эдийн засгийн тогтворжилт сайжрах зэрэг хүчин зүйлсээс үүдэлтэй темпо шилжилтийг илэрхийлж байна.

Сүүлийн жилүүдэд, тухайлбал 2022–2023 онд төрөлтийн оргил 30–34 насанд шилжсэн нь COVID-19 цар тахал, нийгэм, эдийн засгийн тодорхойгүй байдал, орон сууцны хомсдол зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх шийдвэрээ хойшлуулсантай холбоотойгоор тайлбарлагдана.

Харин 2024 онд төрөлтийн оргил дахин 25–29 насны бүлэгт төвлөрсөн нь хожуу төрөлтийн давалгаа түр зуур саарч, эдийн засгийн тодорхой байдал нэмэгдэхийн хэрээр хүүхэд төрүүлэх шийдвэр харьцангуй эрт хэв шинж рүү шилжиж буйг илтгэж байна.

Ийнхүү төрөлтийн оргил нас жилээс жилд өөрчлөгдөн шилжиж буй нь Монгол эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэх шийдвэрийнхээ цаг хугацааг уян хатан байдлаар хойшлуулах, зарим үед наашлуулах зохицуулалт идэвхтэй явагдсаныг баталж байна. Энэ нь төрөх насыг хойшлуулах чиглэлийн темпо өөрчлөлт Монгол Улсад давамгайлж байгааг тодорхой нотолж байна.

#### **4.4 Төрөлтийн цаг хугацааны шинжилгээ**

Төрөлтийн цаг хугацааны шинжилгээг нэг үеийн (period) болон үелрэлийн (cohort) гэсэн хоёр үндсэн хэлбэрт ангилдаг. Дээр дурдсан бүх шинжилгээ нь нэг үеийн, өөрөөр хэлбэл тухайн хугацаанд ажиглагдсан төрөлтийн шинжилгээнд хамаарах бөгөөд богино хугацааны өөрчлөлт, шинээр илэрч буй хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Хэдий тухайн үеийн төрөлтийн ажиглагдсан ТНК болон темпо-зассан ТНК\*-ийн өөрчлөлтийг насны бүтэц, зан төлөв, квантум ба темпо нөлөөгөөр задлан тайлбарлаж байгаа ч темпо нөлөөг бүрэн дүүрэн илэрхийлж чаддаггүй. Харин нэг цаг үед төрсөн эмэгтэйчүүдийн үелрэлийн амьдралын туршид төрүүлсэн хүүхдийн дундаж тоог урт хугацааны өгөгдөлд тулгуурлан тооцож чадвал төрөлтийн зан төлөвт гарч буй бодит, суурь өөрчлөлтийг илүү нарийвчлалтай тодорхойлох боломж бүрддэг.

Манай шинжилгээнд ашигласан өгөгдөл нь 1990–2024 оны хугацааг хамарч байгаа тул үелрэлийн хувьд хангалттай урт цуваа биш боловч тодорхой хэмжээнд үелрэлийн шинжилгээ хийх боломж олгож байна. Тухайлбал, 1960–1970 онд төрсөн эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн насны төрөлтийн мэдээлэл бүрэн хамрагдсан бол 1975–1980 онд төрсөн эмэгтэйчүүдийн хувьд бараг бүрэн мэдээлэлтэй бөгөөд тэд 2024 онд 44–49 нас хүрч байна. Харин 1985 оноос хойш төрсөн эмэгтэйчүүдийн, ялангуяа 1990-ээд онд төрсөн үелрэлийн хувьд нөхөн үржихүйн үйл явц бүрэн дуусаагүй, дутуу мэдээлэлтэй байна. Иймээс 1990–2024 оны хугацаанд нөхөн үржихүйн насаа бүрэн дуусгасан болон бараг бүрэн дуусгасан (45–49 насны бүлгийн

сүүлийн мэдээлэл дутуу) эмэгтэйчүүдийн өгөгдөлд тулгуурлан, төрсөн он цагийн дагуу үелрэлийн шинжилгээг гүйцэтгэлээ.

#### 4.4.1 Үелрэл төрөлтийн нийлбэр коэффициентийн өөрчлөлт, чиг хандлага

1990–2024 оны нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн насны бүлэг дэх төрөлтийн мэдээлэлд тулгуурлан 1960–1980 онд төрсөн үелрэлүүдийн амьдралынхаа туршид төрүүлсэн хүүхдийн тоо (CFR)-ийг тооцоход дараах үр дүн гарсан. Хүснэгт 3-т 1960–1980 онд төрсөн Монгол эмэгтэйчүүдийн үелрэл төрөлтийн нийлбэр коэффициент (Үелрэл-ТНК) болон тэдгээр нь нөхөн үржихүйн нас буюу төрөх боломжит насыг бүрэн дуусгасан эсэхийг төрсөн үеэр нь зэрэгцүүлж харуулав.

#### Хүснэгт 4.4: Үелрэл ТНК, эхийн төрсөн он ба нөхөн үржихүйн насаа гүйцээсэн байдлаар, 1960-1980 онд төрсөн эмэгтэйчүүдийн хувьд

Үелрэл (төрсөн он)	Үелрэл-ТНК	Нөхөн үржихүйн насаа гүйцээсэн байдал
1960 оны үелрэл	4.39	Бүрэн
1965 оны үелрэл	3.59	Бүрэн
1970 оны үелрэл	2.94	Бүрэн
1975 оны үелрэл	2.68	Бараг бүрэн
1980 оны үелрэл	2.58	Бараг бүрэн

**Эх сурвалж:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

**Тэмдэглэл:** Үелрэл-ТНК гэдэг нь тухайн үеийн эмэгтэйчүүд амьдралынхаа туршид хэдэн хүүхэд төрүүлдэг байсныг харуулах кохортын (насны бүлгийн) дундаж үзүүлэлт юм.

Амьдралын туршид төрүүлэх хүүхдийн тоо үелрэл хооронд мэдэгдэхүйц ялгаатай байгааг шинжилгээ харуулж байна. Тухайлбал, 1960 онд төрсөн эмэгтэйчүүд дунджаар 4–5 хүүхэд төрүүлж байсан бол үелрэл ахих тусам энэ тоо буурч, 1980 онд төрсөн үелрэлийн эмэгтэйчүүдийн хувьд дунджаар 2–3 хүүхэдтэй байна. Энэхүү өөрчлөлт нь төрөлтийн хандлага түүхэн хугацаанд эрс хувирч буйг нотлох статистик баталгаа юм. Мөн Монгол Улсад төрөлтийн шилжилт, улмаар төрөлтийн бууралт бодитоор явагдаж байгааг тодорхой харуулж байна.

#### 4.4.2 Хугацааны болон үелрэл ТНК-ийн харьцуулалт харьцуулалт

Хүснэгт 4.5-д тухайн үеийн ТНК, үелрэлийн ТНК, мөн төрөх насыг хойшлуулахтай холбоотой темпо нөлөөний чиг хандлагыг 10 жилийн интервалаар харьцуулан үзүүлж, төрөлтийн шилжилтийн механизм болон үелрэл хоорондын ялгааг тодорхой харуулав.

#### Хүснэгт 4.5: Тухайн хугацааны болон нэг үед төрсөн үелрэлийн ТНК-ийн дундаж харьцуулалт ба темпо нөлөө, 10 жилийн интервалаар, 1990-2024

Хугацаа	Тухайн хугацааны ТНК дундаж	Үелрэлийн ТНК дундаж	Темпо нөлөө
1990–2000	2.92	3.64	-0.72
2000–2010	2.25	2.74	-0.49
2010–2020	2.83	2.58	+0.24
2020–2024	2.63	-	-

**Эх сурвалж:** Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Хүснэгтээс харахад, тухайн үеийн жил бүрийн ТНК ба бодит үелрэл-ТНК-ийн хоорондын зөрүү (-0.72, -0.49) нь 1990–2010 оны хугацаанд ажиглагдсан төрөлтийн түвшний бууралтын гол хэсэг “темпо нөлөө”, өөрөөр хэлбэл, төрөх насыг хойшлуулах

үзэгдлээс шалтгаалсныг тодорхой харуулж байна. Хэдийгээр 1960–1980 оны хооронд төрсөн эмэгтэйчүүд амьдралынхаа туршид төрүүлсэн хүүхдийн тоо тухайн үеийн ажиглагдсан төрөлтийн түвшнээс харьцангуй өндөр байсан ч энэ нь төрөх насыг хойшлуулснаас үүссэн бууралтыг бүрэн нөхөхүйц хэмжээнд хүрээгүй байна. Иймээс уг хугацаанд ажиглагдсан төрөлтийн бууралтын дийлэнх шалтгаан нь бодит зан төлвийн огцом өөрчлөлт бус, харин түр зуурын, насны шилжилттэй холбоотой темпо нөлөө байсан гэдгийг энэхүү шинжилгээ баталж байна.

Анх удаа эерэг темпо нөлөө буюу өмнөх жилүүдэд хойшлогдсон төрөлтийн нөхөлт (“catch-up effect”) илэрсэн үе нь 2010–2020 оны хугацаа байв. Энэ үед тухайн хугацаанд ажиглагдсан төрөлтийн түвшин (ТНК = 2.83) нь бодит үелрэлийн ТНК-ээс (2.58) өндөр гарсан байна. Ийм үзэгдэл нь өмнөх хугацаанд төрөх насыг хойшлуулсны улмаас хуримтлагдсан төрөлт тодорхой үед эргэн нөхөгдөх үед ажиглагддаг бөгөөд улмаар тухайн үеийн ТНК түр хугацаанд бодит үелрэлийн түвшнээс давж гарах боломжтойг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр баталж байна.

Сүүлийн тайлант хугацаанд, тухайлбал 2020–2024 онд ажиглагдсан ТНК бага зэрэг буурсан боловч үелрэлийн үзүүлэлтүүд бүрэн бүрдээгүй байгаа тул темпо нөлөөг эцэслэн тооцох боломж одоогоор хязгаарлагдмал байна. Эндээс харахад “темпо нөлөө” давамгайлж байсан чухал үе болох 1990–2010 онд төрөлтийг дэмжих бодлого илүү эрчимтэй хэрэгжсэн тохиолдолд бодлогын үр нөлөө өндөр гарах боломж байсныг дүгнэж болно. Харин 2010–2020 оны хугацаанд өмнөх жилүүдэд хойшлогдсон төрөлтүүдийн нөхөн гүйцэлт богино хугацаанд өсөлт авчирсан ч, төрөлтийн бодит тоо буюу квантумын бууралт үргэлжилсээр байсан тул урт хугацаанд төрөлтийн түвшин буурах чиг хандлага давамгайлах төлөвтэй байгааг энэхүү шинжилгээ харуулж байна.

Иймээс бодлогын хувьд богино хугацаанд гэр бүл эхлүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг (орон сууц, тогтвортой ажлын байр, хүүхэд асрах дэмжлэг) хэрэгжүүлэхийн зэрэгцээ урт хугацаанд олон хүүхэдтэй байхыг дэмжих, урамшуулах бодлогыг (татварын зохицуулалт, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах) цогцоор нь баримтлах боломжтой.

#### 4.5 Төрөлтийн талаарх ирээдүйн таамаглал

Монгол Улсын төрөлтийн талаарх ирээдүйн таамаглалыг 4 хувилбараар боловсруулж НҮБ-ийн 2024 оны дундаж хувилбартай харьцуулан үр дүнг Хүснэгт 4.6, Зургаар харуулав.

**Хүснэгт 4.6: Монгол Улсын төрөлтийн түвшний 2024-2050 оны таамаглал, 4 хувилбараар, НҮБ-ын тооцооллын дундаж хувилбартай харьцуулсан байдлаар**


Он	Дээд хувилбар	Суурь хувилбар	Доод хувилбар	Дундаж хувилбар (ТНК+ТНК*) <sup>a</sup>	НҮБ WPP 2024 (дунд) <sup>b</sup>
2024	2.32	2.32	2.32	2.51	2.63
2025	2.39	2.31	2.26	2.49	2.58
2026	2.46	2.30	2.20	2.47	2.54
2027	2.53	2.30	2.14	2.45	2.50
2028	2.60	2.29	2.07	2.43	2.46

2029	2.67	2.28	2.01	2.41	2.42
2030	2.74	2.27	1.95	2.39	2.39
2031	2.72	2.23	1.92	2.37	2.36
2032	2.70	2.18	1.89	2.35	2.33
2033	2.68	2.14	1.86	2.33	2.30
2034	2.66	2.09	1.83	2.31	2.28
2035	2.64	2.05	1.80	2.29	2.25
2036	2.62	2.03	1.77	2.26	2.22
2037	2.60	2.01	1.74	2.23	2.20
2038	2.58	1.99	1.71	2.21	2.18
2039	2.55	1.97	1.68	2.18	2.16
2040	2.52	1.95	1.65	2.15	2.14
2041	2.49	1.93	1.64	2.12	2.12
2042	2.46	1.91	1.63	2.09	2.10
2043	2.43	1.89	1.62	2.07	2.08
2044	2.40	1.87	1.61	2.04	2.07
2045	2.37	1.85	1.60	2.01	2.05
2046	2.34	1.83	1.59	1.98	2.04
2047	2.31	1.81	1.58	1.95	2.02
2048	2.28	1.79	1.57	1.93	2.01
2049	2.25	1.77	1.56	1.90	2.00
2050	2.22	1.76	1.55	1.87	1.99

Тэмдэглэл: <sup>a</sup> - 1990-2024 оны хоорондох ажиглагдсан болон темпо тооцсон ТНК-уудын дундаж хандлага дээр үндэслэсэн.

<sup>b</sup> -- World Population Prospects: The 2024 Revision-н тооцооллын дундаж хувилбар

**Зураг 4.8: Монгол Улсын 1990-2050 оны төрөлтийн түвшин (ТНК), ажиглагдсан ТНК ба олон хувилбарт таамаглалууд**



**2024-2050 оны тооцооллын тайлбар:**

**Дээд хувилбар:** Төрөлтийн түвшин 2024 оны 2.32-аас эхлэн 2025-2027 онд эрчимтэй, зорилтод бүлэгт чиглэсэн бодлого явуулбал түүний үр дүнд 2.53 хүрч, 2028-2030 онд

2005-2014 үелрэлийн нөлөөгөөр 2.74-д хүрч оргил цэгтээ хүрнэ. Харин 2031-2035 онд 2.64 болж бага хэмжээгээр буурч, 2036-2040 онд 2.52, 2041-2045 онд 2.37, эцэст нь 2046-2050 онд 2.22-д хүрч эргэн нөхөгдөх түвшнээс арай дээгүүр тэнцвэржинэ.

**Суурь хувилбар:** ТНК 2024 оны 2.32-аас 2025-2027 онд бодлогын улмаас 2.30 болж бага тогтворжиж, 2028-2030 онд үелрэлийн хэсэгчилсэн<sup>5</sup> нөлөөгөөр 2.27 болно. Харин 2031-2035 онд 2.05 хүрч эргэн нөхөгдөх түвшнээс доош унаж, 2036-2040 онд 1.95, 2041-2045 онд 1.85, эцэст нь 2046-2050 онд 1.76-д хүрч НҮБ таамаглалтай нийцэж тэнцвэржинэ.

**Доод хувилбар:** Төрөлтийн түвшин 2024 оны 2.32-аас 2025-2027 онд 2.14 хүрч хурдтай буурч, 2028-2030 онд 1.95 болж эргэн нөхөгдөх түвшнээс доош орно. 2031-2035 онд үелрэлийн импульс алдагдаж 1.80, 2036-2040 онд 1.65, 2041-2045 онд 1.60, эцэст нь 2046-2050 онд 1.55-д хүрнэ.

**Дундаж хувилбар (ТНК+ТНК\*):** Монгол Улсын ажиглагдсан болон темпо тооцсон ТНК-н дундаж утга 2024 оны 2.51-ээс 2025-2030 онд бодлогын хэрэгжилтийн хэсэгчилсэн нөлөөний улмаас 2.39 болж, 2031-2035 онд алтан цонхны хэсэгчилсэн ашиглалтаар 2.29, 2036-2040 онд 2.15, 2041-2045 онд 2.01, эцэст нь 2046-2050 онд 1.87-д хүрч НҮБ-н тооцооллын дундаж хувилбартай ойролцоо түвшинд очино.

**Таамаглалын цаг хугацааны явц дахь өөрчлөлтийн онцлог:** Таамаглалаас харахад, 2024-2030 онд бүх хувилбар янз бүрийн чиглэлд салж, 2030-2035 онд 2005-2014 онд төрсөн үелрэлийн нөлөөний оргил үе буюу "алтан цонх" үүсч, 2035-2040 онд эргэн нөхөгдөх түвшнээс доош унах эсэх шийдэгдэж, 2040-2050 онд урт хугацааны тэнцвэрийн түвшин тогтоно.

Энэ дөрвөн хувилбарын нийт өөрчлөлт 2024-2050 оны хооронд дээд хувилбарт 0.10 пунктийн бууралт, суурь хувилбарт 0.56 пунктийн дунд бууралт, доод хувилбарт 0.77 пунктийн их бууралт, дундаж хувилбарт 0.64 пунктийн НҮБ стандарт бууралтыг тус тус харуулж байна.

---

<sup>5</sup> 2005-2014 онд төрсөн үелрэлийн зөвхөн тодорхой хэсэг нь хүүхэд төрүүлэх.

**Хүснэгт 4.7: Монгол Улсын төрөлтийн талаарх ирээдүйн түвшний 4 хувилбарын тооцооллын нөхцөл, төсөөлөл**

Хувилбар	2024–2050 чиглэл / түвшин	Бодлогын орчин	Хүсэмжит хүүхдийн тоо	Темпо өөрчлөлт / MAC*	2005–2014 үелрэлийн ашиглалт	Bongaarts завсрын хүчин зүйлс (M, C, I, A)	Оргил нас / насны бүтэц
Дээд	2024–2030 өсөлт (2.32→2.74), дараа нь зөөлөн буурна, 2050≈2.22	Иж бүрэн, эрчимтэй: орон сууц–санхүүжилт, хүүхэд асрах дэд бүтэц, татвар, уян ажил, нөхөн үржихүй/хүүхдийн ЭМ, үнэт зүйл–боловсрол, гэр бүл гэх мэт	2.6–2.8, 2+ буюу дараагийн хүүхэд төрүүлэх магадлал нэмэгдэх	төрөлтийн нөхөлт +5–8% (2025–2030); MAC 28.5→27.5 (өсөлт удааширна/буурна)	Бүрэн (ТНК-н өөрчлөлт +0.3–0.5 пункт); дээд үе: 2028–2035	Иж бүрэн бодлогоор гэрлэлт/хамтран амьдрах хэлбэрийг дэмжих, жирэмслэлтээс хамгаалах – төлөвлөлт, төрсний дараах түр үргүйдэл богиносж, үр хөндөлт багасах магадлалтай	25–29 давамгайлал хадгалагдана, 30–34/35–39 тогтвортой хэвээр байна
Суурь	Тогтвортой бууралт, 2050≈1.76	Өнөөгийн бодлогын түвшинг хадгална	2.4–2.6, төвийг сахих хандлагатай	Postponement үргэлжилнэ; TFR–TFR* зөрүү багасна; MAC 28.5→29.0	Хэсэгчлэн (+0.1–0.2 пункт)	Одоогийн байдлыг хадгалбал гэрлэлт тогтвортой, жирэмслэлтээс хамгаалах хэрэглээ, түр үргүйдэл хэвийн, үр хөндөлт дундаж байх магадлалтай	25–29 буурч, 30–34 тогтвортой хэвээр байна
Доод	Хурдтай бууралт, 2050≈1.55	Тогтворгүй/дутагдалтай: санхүүжилт, дэмжлэг сул	1.8–2.0, 2+ буюу дараагийн хүүхэд төрүүлэх магадлал буурах	Хойшлуулалт хүчтэй, төрөлтийн нөхөлт сул; MAC ≥30.5 (28.5→31.0+)	Алдагдана	Бодлого сул үед гэрлэлт ↓, хамгаалах хэрэглээ өндөр + үр хөндөлт давамгайл, түр үргүйдэл уртсаж, үр хөндөлт өсөх магадлалтай	Бүх насанд ASFR буурна; 25–29 огцом доош; хожуу төрөлт давамгайл
Дундаж	2025–2035 бага, 2036–2050 тогтвортой бууралт, 2050≈1.87	Хэсэгчлэн сайжруулна	2.2–2.4, тогтвортой	2025–2035 бага зэргийн төрөлтийн нөхөлт (+1–3%); 2036+ зан төлөв давамгайлна	Дунд зэрэг (+0.15–0.3 пункт)	Хэсэгчилсэн бодлогоор гэрлэлт бага зэрэг ↑, хамгаалах хэрэглээ – төлөвлөсөн, түр үргүйдэл дундаж, үр хөндөлт бага түвшинд тогтвортой байх магадлалтай	25–29 бага зэрэг буурч, 30–34 тогтвортой хэвээр, 35–39 бага өснө

Тэмдэглэл: MAC\* - хүүхэд төрүүлэх дундаж нас

## БҮЛЭГ 5: ТӨРӨЛТ, ГЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Төрөлт буурч, гэрлэлт хойшлох хандлага эрчимжиж буй нөхцөлд залуучуудын дундаж хандлагыг судалж, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг ойлгох, цаашдын таамаглал боловсруулах болон бодлого төлөвлөлтөд ашиглах зорилгоор Нийгмийн үзүүлэлтийн түүврийн нэмэлт судалгааг “Төрөлт, гэрлэлтийн хандлага” сэдвээр 15–34 насны залуучуудын дунд тусгайлан явуулсан. Энэ бүлэгт уг судалгааны гол үр дүнг танилцуулж байна. Судалгаанд нөхөн үржихүйн насны 15–34 насны 817 эмэгтэй хамрагдсан.

### 5.1 Төрөлтийн талаарх хандлага

Монгол Улсад явагдаж буй төрөлтийн бууралтын талаарх хариулагчдын хандлагыг Хүснэгт 5.1-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 45.4 хувь нь Монгол Улсад төрөлтийн бууралт явагдаж байгааг мэдэж байна гэж хариулсан бол 54.3 хувь нь энэ талаар мэдэхгүй байгаагаа илэрхийлжээ.

**Хүснэгт 5.1: Монгол Улсын төрөлтийн тоо буурч байгаа талаарх мэдлэг**

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, Монгол Улсад сүүлийн жилүүдэд төрөлтийн тоо буурч байгааг мэдэж байгаа эсэхээр, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат					
	Монгол Улсад төрөлтийн тоо буурч байгаа талаар мэдэж байгаа эсэх			15-34 насны эмэгтэйчүүд	
	Тийм	Үгүй	Хариулаагүй	Хувь	Тоо
<b>Бүгд</b>	45.4	54.3	0.3	<b>100.0</b>	817
<b>Хот, хөдөө</b>					
Хот	47.5	52.3	0.2	100.0	621
Хөдөө	38.7	60.9	0.4	100.0	196
<b>Хотжилтын түвшин</b>					
Хот	50.7	49.3	0.0	100.0	364
Суурин газар, хагас нягтралтай	41.8	58.2	0.0	100.0	222
Хөдөө	40.6	58.4	1.0	100.0	231
<b>Насны бүлэг</b>					
15-17	31.4	68.6	0.0	100.0	189
18-20	32.5	67.5	0.0	100.0	84
21-24	63.7	36.3	0.0	100.0	148
25-29	45.9	53.0	1.2	100.0	162
30-34	49.6	50.3	0.2	100.0	233
<b>Төрөлтийн тоо</b>					
0	38.4	61.6	0.0	100.0	402
1	53.4	46.6	0.0	100.0	127
2+	52.1	47.9	0.0	100.0	286
<b>Гэрлэлтийн байдал</b>					
Гэрлэж байсан/Хамтран амьдрагчтай байсан	51.6	48.4	0.0	100.0	446
Огт гэрлээгүй	38.6	61.4	0.0	100.0	361
Хариулаагүй	(*)	(*)	(*)	100.0	9
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Доогуур	40.2	59.5	0.3	100.0	169
Дунджаас доогуур	49.2	50.6	0.2	100.0	187
Дундаж	45.7	53.4	0.9	100.0	155
Дунджаас дээгүүр	36.8	63.2	0.0	100.0	136
Дээгүүр	53.1	46.9	0.0	100.0	170


(\*) 25-аас цөөн жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

Ялгаатай байдлаар авч үзвэл, Монгол Улсад төрөлтийн тоо буурч байгааг мэдэхгүй гэж хариулсан хувь тодорхой бүлгүүдэд харьцангуй өндөр байна. Тухайлбал, хөдөө орон нутагт (хөдөө 60.9 хувь, хотод 52.3 хувь), залуу насны бүлэгт (15–20 насныхны дунд ойролцоогоор 68 хувь, харин 30–34 насныханд 50.3 хувь), хүүхэдгүй эмэгтэйчүүдийн дунд (61.6 хувь, харин 2 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд 47.9 хувь), мөн гэрлээгүй эмэгтэйчүүдийн дунд (61.4 хувь, харин гэрлэсэн буюу хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдэд 48.4 хувь) энэ хариулт бусад бүлгүүдтэй харьцуулахад илүү түгээмэл байна. Ерөнхийдөө, нас ахихын хэрээр төрөлтийн тоо буурч байгааг мэдэж байна гэж хариулах хувь нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа ч 21–24 насныхны хувьд уг мэдлэг бусад насны бүлгүүдээс харьцангуй өндөр байгаа нь онцлог байна.


Төрөлтийн тоо буурч буй нь анхаарал хандуулах шаардлагатай асуудал мөн эсэх тухай дараагийн асуултад хариулагчдын дийлэнх нь эерэг байр суурь илэрхийлжээ. Тодруулбал, нийт хариулагчдын 88.8 хувь үүнийг анхаарах шаардлагатай асуудал гэж үзсэн, үүнээс 47.6 хувь нь “маш их шаардлагатай”, 41.2 хувь нь “зарим талаараа шаардлагатай” гэж хариулсан байна. Харин ердөө 10 орчим хувь нь үүнийг асуудал биш гэж үзсэн байхад 7.6 хувь нь “анхаарах асуудал биш”, 2.4 хувь нь “огт асуудал биш” гэж хариулжээ.

“Та Монгол Улсын төрөлтийн тоонд хэр санаа зовдог вэ?” гэсэн асуултад хариулагчдын 51.8 хувь нь дунд зэрэг санаа зовдог гэж хариулсан байна. Харин ойролцоогоор 20 орчим хувь нь маш их болон их санаа зовдог гэж үзсэн бол 18 хувь нь бага санаа зовдог, 7.2 хувь нь огт санаа зовохгүй гэж хариулжээ.

**Зураг 5.1: Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад анхаарал хандуулах шаардлагатай эсэх**




**Зураг 5.2: Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад санаа зовж буй байдал**




Залуучуудын насны бүлгээр харвал, төрөлтийн тоо буурч байгаад “маш их анхаарал хандуулах шаардлагатай” гэж үзэх хувь нас ахихын хэрээр нэмэгдэх хандлагатай байна (15–17 насныханд 33.7 хувь, 30–34 насныханд 59.1 хувь). Харин “зарим талаараа анхаарал хандуулах шаардлагатай” гэсэн хариулт харьцангуй залуу бүлэгт илүү өндөр, тухайлбал, 15–17 насныханд 52.7 хувь, 30–34 насныханд 30.9 хувь байна.

Мөн нас нэмэгдэхийн хэрээр уг асуудалд санаа зовж байна гэж хариулах хувь өсөж буй бол “маш бага санаа зовж байна” гэсэн хариулт хамгийн залуу буюу 15–17 насныхны дунд хамгийн өндөр (17.9 хувь) байна. Харин бусад насны бүлгүүдэд энэ үзүүлэлт 1.6–9.2 хувийн хооронд хэлбэлзэж байна.

**Зураг 5.3: Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад анхаарал хандуулах шаардлагатай эсэх, насны бүлгээр**



**Зураг 5.4: Монгол Улсын төрөлтийн түвшин буурч байгаад санаа зовж буй байдал, насны бүлгээр**



Эдгээр хариултаас үзэхэд, Монгол Улсын залуучууд төрөлтийн тоо буурч байгаа эсэхийг бүрэн дүүрэн мэдэхгүй байгаа шинж ажиглагдаж байгаа ч уг асуудалд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж, тодорхой хэмжээнд санаа зовниж байгаа хандлага илэрч байна. Энэ байдал нь залуучуудын бүх насны бүлэгт ижил түвшинд илрэхгүй байна. Энэ нь “нас”-ны онцлог, мэдээлэлд өртөх байдал, амьдралын туршлага зэрэг хүчин зүйлсээр тайлбарлагдах боломжтой.

Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаануудтай санал нийлэх эсэхийг тодруулахад хэд хэдэн хүчин зүйл давамгайлсан илэрч байна.

**Зураг 5.5: 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, шалтгаануудаар**



Тухайлбал, эмэгтэйчүүдийн (нөхөн үржихүйн) эрүүл мэндийг 86.9 хувь, хүрээлэн буй орчны бохирдол — агаар, хөрсний бохирдлыг 86.5 хувь, орлогын баталгаагүй байдлыг 85.3 хувь нь чухал шалтгаан гэж үзжээ. Үүнээс гадна өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ 80.2 хувь, хүүхэд өсгөхөд итгэлгүй байдал 76.9 хувиар тус тус өндөр үнэлэгдсэн байна. Эдгээр хариултаас харахад төрөлтийн бууралтад зөвхөн эдийн засгийн хүчин зүйлс бус, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийгмийн нөхцөл байдалтай холбоотой шалтгаанууд мөн адил чухал нөлөө үзүүлж байгааг тодорхой харуулж байна.

Төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаануудтай санал нийлэх байдал нь эмэгтэйчүүд хүүхэдтэй эсэхээс хамааран нэлээд ялгаатай байна. Хүүхэдгүй эмэгтэйчүүдийн хувьд эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, орлогын баталгаагүй байдал, хувь хүний хөгжлийн асуудлуудтай санал нийлэх хувь харьцангуй өндөр байгаа бол хүүхдийн тоо нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн хүчин зүйлс, тухайлбал орлогын баталгаагүй байдал, эрүүл мэнд, орчны нөхцөл, ажлын цагийн зохицуулалт, хүүхэд өсгөх зардал зэрэг шалтгаануудыг онцлон дурдсан хариултауд давамгайлах хандлага ажиглагдаж байна.

**Хүснэгт 5.2: 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, хүүхэдтэй эсэх, гол шалтгаанаар**

Хүүхэдгүй	%	2+ хүүхэдтэй	%
Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд (нөхөн үржихүйн)	88.9	Орлогын баталгаагүй байдал	87.4
Орчны бохирдол (агаарын, хөрсний)	88.0	Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд (нөхөн үржихүйн)	85.9
Орлогын баталгаагүй байдал	84.2	Орчны бохирдол (агаарын, хөрсний)	82.6
Хүүхэд өсгөх итгэлгүй байдал	83.7	Ажлын цаг хэт урт	81.1
Өөрийгөө хөгжүүлэх	83.1	Өөрийгөө хөгжүүлэх	78.9
Хүүхэд өсгөх дэмжлэг дутмаг	76.4	Хүүхэд өсгөх зардал өндөр	73.5

Төрөлтийн тоо буурахад нөлөөлж буй шалтгаануудтай санал нийлэх байдал хот, хөдөөгөөр тодорхой ялгаатай байна. Хот суурин газарт орчны бохирдлыг хамгийн гол шалтгаан гэж нэрлэсэн бол хөдөө орон нутагт эмэгтэйчүүдийн (нөхөн үржихүйн) эрүүл мэндийг хамгийн өндөр хувьтайгаар онцолжээ. Харин хот, хөдөөгийн аль алинд нь орлогын баталгаагүй байдал дараагийн чухал шалтгаан болж, ижил түвшинд дурдагдсан байна.

**Хүснэгт 5.3: 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, хот, хөдөөгөөр, шалтгаанаар**

Хот	%	Хөдөө	%
Орчны бохирдол (агаарын, хөрсний)	89.6	Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд (нөхөн үржихүйн)	86.1
Орлогын баталгаагүй байдал	87.8	Орлогын баталгаагүй байдал	77.2
Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд (нөхөн үржихүйн)	87.1	Орчны бохирдол (агаарын, хөрсний)	76.9
Өөрийгөө хөгжүүлэх	81.9	Өөрийгөө хөгжүүлэх	75.1
Хүүхэд өсгөх итгэлгүй байдал	77.9	Ажлын цаг хэт урт	75.1
Хүүхэд өсгөх дэмжлэг дутмаг	75.6	Хүүхэд өсгөх дэмжлэг дутмаг	74.4

Насны бүлгээр харвал, орчны бохирдол (агаарын, хөрсний), эмэгтэйчүүдийн (нөхөн үржихүйн) эрүүл мэнд, орлогын баталгаагүй байдал зэрэг шалтгаануудтай санал нийлэх байдал бүх насны бүлгүүдэд нийтлэг өндөр байна. Гэсэн хэдий ч зарим насны бүлгүүдэд онцлог ялгаа тодорхой ажиглагдаж байна. Тухайлбал, 18–24 насныхны дунд өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ, хүүхэд өсгөхөд итгэлгүй байдал, хүүхэд өсгөх дэмжлэг дутмаг байдал зэрэг хувь хүнд чиглэсэн шалтгаануудтай санал нийлэх хувь бусад насны бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Харин нас ахихын хэрээр, ялангуяа 25–29 насныхны хувьд орон сууцтай болох өртөг өндөр, ажлын цаг хэт урт, төрөх болон хүүхэд өсгөх ачаалал ихсэх, эмэгтэйчүүдийн карьер тасалдах зэрэг бүтэц, амьдралын нөхцөлтэй холбоотой шалтгаануудтай санал нийлэх хандлага илүү давамгайлж байна.

**Хүснэгт 5.4: 15-34 насны эмэгтэйчүүдийн хувь, Монгол Улсад төрөлтийн тоо бага байгаагийн болзошгүй шалтгаантай санал нийлж буй хувиар, зарим насны бүлгээр, шалтгаанаар**

18-20	%	25-29	%
Хүүхэд өсгөх дэмжлэг дутмаг	88.3	Сууцтай болох өртөг өндөр	79.4
Хүүхэд өсгөх итгэлгүй байдал	85.3	Ажлын цаг хэт урт	77.0
Өөрийгөө хөгжүүлэх	83.8	Төрөх, хүүхэд өсгөх ачаалал	72.0
Сууцтай болох өртөг өндөр	76.7	Эмэгтэйчүүдийн карьер тасалдах	71.3

Хэрэв Монгол Улс цаашид хүн амаа өсгөх, эсвэл хүн амын өсөлтийг тогтвортой хадгалах зорилготой бол залуучуудын хандлага, үзэл бодол, ялангуяа төрөлтийн бууралтад нөлөөлж буй шалтгааны талаар өгсөн эдгээр хариултыг нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн ялгаатай байдлаар нь нарийвчлан авч үзэх шаардлагатай. Үүний үндсэн дээр бүлэг тус бүрийн хэрэгцээ, саад бэрхшээлд нийцсэн, бодит зорилт бүхий бодлого боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Хэдийгээр Монгол Улсын Засгийн газар хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах, ядуурлыг бууруулах, хүн амын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа ч эдгээр бодлого, үйл ажиллагаа нь хүн амын төрөлтийг бодитоор дэмжих түвшинд хангалттай нөлөө үзүүлж чадахгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Судалгааны үр дүнгээс харахад, төрөлтөд эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, тэр дундаа нөхөн үржихүйн асуудал онцгой чухал нөлөөтэй болох нь тодорхой нотлогдож байна. Үүний зэрэгцээ иргэдийн амьдрах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц, уялдаа бүхий бодлого зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдээс төрөлтийн төсөөлөлтэй холбоотойгоор хэд хэдэн асуулт асуусан. Үүнд: анхны хүүхдээ төрүүлэхэд тохиромжтой гэж үзэж буй дундаж нас, гэр бүлд зохимжтой гэж үзэх хүүхдийн дундаж тоо, мөн өөрсдөө хэдэн хүүхэдтэй болохыг хүсдэг талаарх хандлагыг тус тус тодруулсан.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн үзэж буйгаар анхны хүүхдээ төрүүлэхэд тохиромжтой дундаж нас 24.3 байна. Анхны хүүхдээ төрүүлэх тохиромжтой дундаж насны талаарх хариулт хот, хөдөөгөөр бага зэрэг ялгаатай байна. Хотод энэ нас дунджаар 24.5 байхад хөдөөд 23.7 гэж хариулсан нь ойролцоогоор нэг жилийн зөрүүтэй байна. Насны бүлгүүдийн хувьд ялгаа харьцангуй бага, 15–17 насныхан анхны хүүхдээ 24.7 насанд төрүүлэхийг тохиромжтой гэж үзсэн бол 30–34 насныхан 23.8 нас гэж

хариулжээ. Харин бусад насны бүлэг болох 18–29 насныхны дунджаар 24.5 насанд тохиромжтой гэж үзсэн байна.

**Хүснэгт 5.5: Төрөлтийн төсөөлөл: Эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх тохиромжтой дундаж нас**

Эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх тохиромжтой дундаж нас, Монгол Улс НҮТС+ 2025-26, 1-р шат		
Шинж байдлын үзүүлэлтүүд	Эмэгтэйчүүдийн анхны хүүхдээ төрүүлэх тохиромжтой дундаж нас	Хариулт өгсөн 15-34 насны эмэгтэйчүүдийн тоо
<b>Бүгд</b>	24.3	804
<b>Хот, хөдөө</b>		
Хот	24.5	612
Хөдөө	23.7	192
<b>Бүс</b>		
Баруун	24.6	105
Хангай	23.2	159
Төв	24.1	131
Зүүн	23.4	58
Улаанбаатар	24.9	351
<b>Хотжилтын түвшин</b>		
Хот	24.9	358
Суурин газар, хагас нягтралтай	24.0	219
Хөдөө	23.6	227
<b>Насны бүлэг</b>		
15-17	24.7	188
18-20	24.4	84
21-24	24.5	147
25-29	24.3	156
30-34	23.8	228
<b>Number of births</b>		
0	24.7	397
1	24.2	125
2+	23.8	282
Хариулаагүй	-	0
<b>Гэрлэлтийн байдал</b>		
Гэрлэж байсан/Хамтран амьдрагчтай байсан	23.8	441
Огт гэрлээгүй	24.9	358
Хариулаагүй	(*)	6
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>		
Доогуур	23.5	167
Дунджаас доогуур	23.5	183
Дундаж	24.0	150
Дунджаас дээгүүр	25.2	136
Дээгүүр	25.6	169

Байршлаар нь авч үзвэл, Улаанбаатар хотод 25 нас, Хангай болон Зүүн бүсэд 23 нас, Баруун болон Төвийн бүсэд 24 нас гэж үзсэн нь бүс нутгийн ялгааг илтгэж байна. Өрхийн аж байдлын түвшнээр харахад, доогуур түвшний өрхийн эмэгтэйчүүд анхны хүүхдээ арай эрт, дунджаар 23.5 насанд төрүүлэх нь тохиромжтой гэж үзсэн бол дээгүүр аж байдлын түвшинтэй эмэгтэйчүүдийн хувьд харьцангуй хожуу буюу 25.6 насанд тохиромжтой гэсэн хариулт өгчээ.

Гэр бүлд зохимжтой гэж үзэж буй хүүхдийн дундаж тооны талаарх төсөөллийг Хүснэгт 5.6-д үзүүлэв. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хариултаас харахад гэр бүлд зохимжтой хүүхдийн дундаж тоо 3.3 байна.

**Хүснэгт 5.6: Төрөлтийн төсөөлөл: Гэр бүлд зохимжтой гэж үзэж буй хүүхдийн дундаж тоо**

Гэр бүлд хэдэн хүүхэд зохимжтой талаарх дундаж тоо, эмэгтэйчүүдийн хариулснаар, Монгол Улс НҮТС+ 2025-26, 1-р шат		
	Гэр бүлд хэдэн хүүхэд зохимжтой талаарх дундаж тоо, эмэгтэйчүүдийн хариулснаар	Хариулт өгсөн 15-34 насны эмэгтэйчүүдийн тоо
<b>Бүгд</b>	3.3	790
<b>Хот, хөдөө</b>		
Хот	3.2	600
Хөдөө	3.8	190
<b>Бүс</b>		
Баруун	4.0	101
Хангай	3.5	158
Төв	3.3	129
Зүүн	3.5	54
Улаанбаатар	3.1	349
<b>Хотжилтын түвшин</b>		
Хот	3.1	356
Суурин газар, нягтралтай	3.4	215
Хөдөө	3.8	219
<b>Насны бүлэг</b>		
15-17	3.1	188
18-20	3.0	83
21-24	3.2	144
25-29	3.4	155
30-34	3.8	221
<b>Number of births</b>		
0	3.1	393
1	3.4	122
2+	3.7	275
Хариулаагүй	-	0
<b>Гэрлэлтийн байдал</b>		
Гэрлэж байсан/Хамтран амьдрагчтай байсан	3.6	432
Огт гэрлээгүй	3.1	353
Хариулаагүй	(*)	5
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>		
Доогуур	3.9	163
Дунджаас доогуур	3.4	182
Дундаж	3.5	144
Дунджаас дээгүүр	3.3	134
Дээгүүр	2.7	167

Гэр бүлд зохимжтой гэж үзэж буй хүүхдийн тооны талаарх төсөөлөл байршил, насны бүлэг, өрхийн аж байдлын түвшнээс хамааран ялгаатай байна. Тухайлбал, хотод дунджаар 3.2, хөдөөд 3.8 хүүхэд зохимжтой гэж үзсэн бол бүс нутгийн хувьд Баруун бүсэд 4.0, Улаанбаатар хотод 3.1, бусад бүсүүдэд дунджаар 3.5 байна. Насны бүлгээр авч үзэхэд, 15–17 насныхан гэр бүлд дунджаар 3 хүүхэд зохимжтой гэж хариулсан бол 30–34 насныхан 3.8 хүүхэд зохимжтой гэж үзжээ. Харин өрхийн аж байдлын түвшний хувьд доогуур түвшинтэй өрхийн эмэгтэйчүүд харьцангуй олон, ойролцоогоор 4 хүүхэд зохимжтой гэж үзсэн бол дээгүүр аж байдлын түвшинтэй эмэгтэйчүүдийн хувьд гэр бүлд зохимжтой хүүхдийн дундаж тоо 3-аас доогуур буюу 2.7 байна.

“Та хүүхэдгүй үе рүүгээ эргэн очлоо гэж төсөөлье. Хэдэн хүүхэдтэй болох сонголт танд байна гэвэл та хэдэн хүүхэд төрүүлэх байсан бэ?” гэсэн асуултаар төрөлтийн талаарх төсөөллийг тодруулахад судалгаанд хамрагдагсдын талаас илүү хувь буюу 52.1 хувь нь 3 ба түүнээс олон хүүхэдтэй болохыг хүсэж байна гэж хариулжээ. Харин гуравны нэг орчим (31 хувь) нь 2 хүүхэд, аравны нэг орчим (9.5 хувь) нь 1 хүүхэдтэй болохыг хүсэж байгаагаа илэрхийлсэн байна. Хүүхэд хүсэхгүй буюу хүсдэггүй гэж хариулсан хувь харьцангуй бага, дөнгөж 2.4 хувь байна.

Нас, гэрлэлтийн байдлаар ялган харвал, харьцангуй залуу насны бүлэг (15–20 нас) болон огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн дунд 2 хүүхэдтэй болохыг хүсдэг гэсэн хариулт бусад бүлгүүдтэй харьцуулахад өндөр хувьтай байгаа нь ажиглагдаж байна.

### Хүснэгт 5.7: Төрөлтийн төсөөлөл: Хүсэмжит хүүхдийн тоо

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүүхэдтэй болох талаарх төсөөллөөр, Монгол Улс НҮТС+ 2025-26, 1-р шат								
	Хэдэн хүүхэдтэй болохыг хүсдэг эсэх					Хариу- лаагүй	Нийт	15-34 насны эмэгтэйчүү- дийн тоо
	Хүсдэггүй	Нэг	Хоёр	Гурав, +	Бусад			
<b>Бүгд</b>	2.4	9.5	31.4	52.1	3.6	1.0	<b>100.0</b>	817
<b>Хот, хөдөө</b>								
Хот	2.9	10.5	31.9	50.9	3.3	0.6	100.0	621
Хөдөө	1.1	6.3	29.9	55.9	4.8	2.1	100.0	196
<b>Насны бүлэг</b>								
15-17	2.0	11.3	52.2	30.8	2.2	1.4	100.0	189
18-20	1.6	16.1	46.7	30.6	2.1	3.0	100.0	84
21-24	5.6	2.8	18.5	71.3	1.9	0.0	100.0	148
25-29	3.8	7.7	22.7	61.3	3.3	1.2	100.0	162
30-34	0.2	11.1	23.2	58.6	6.7	0.3	100.0	233
<b>Гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэж байсан/ Хамтран амьдрагчтай байсан	2.6	7.9	22.6	61.1	4.9	0.8	100.0	446
Огт гэрлээгүй	2.3	11.6	42.8	41.1	1.5	0.7	100.0	361

Төрөлтийн төсөөллийн талаарх энэхүү судалгааны үр дүн нь өмнөх НҮЭМС болон НҮТС-ын дүнтэй нэлээд төстэй (шууд харьцуулах боломж хязгаарлагдмал ч) дүр зургийг харуулж байна. Эдгээр судалгааны үр дүнгээс харахад, сүүлийн 25 гаруй жилийн хугацаанд гэр бүлд зохимжтой хүүхдийн тоонд бараг өөрчлөлт гараагүй, дунджаар 3–4 хүүхэд гэсэн төсөөлөл тогтвортой хадгалагдаж ирсэн байна. Тухайлбал, 1998 онд зохимжит хүүхдийн тоо 3.3, 2003 болон 2008 онд 3.2, харин 2013, 2018 онуудад ижилхэн 3.4 байсан.

Үүнээс дүгнэхэд, Монгол Улсад “олон” хүүхэдтэй байх нь зохимжтой гэсэн үзэл залуучуудын дунд ч хэвээр хадгалагдаж байна гэж хэлж болно. Гэсэн хэдий ч төрөлт хойшлох, хүүхэд төрүүлэх нас урагш бус хойш шилжиж буй хандлага, мөн хамгийн залуу насны бүлэг болох 15–17, 18–20 насныхны дунд 1–2 хүүхэдтэй болохыг хүсэж байна гэсэн хариултын хувь харьцангуй өндөр байгаа зэрэг өөрчлөлтийг онцгойлон анхаарах шаардлагатай байна.

Одоо төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээнүүд болон тэдгээр нь хүүхэдтэй болох шийдвэрт хэрхэн нөлөөлж буй талаарх хариултыг авч үзье.


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дийлэнх буюу 77.6 хувь нь төрөөс хэрэгжүүлж буй одоогийн бодлого, арга хэмжээнүүдийг гэр бүлд хангалтгүй гэж үнэлсэн, үүнээс 49.9 хувь нь “хангалтгүй”, 27.7 хувь нь “маш хангалтгүй” гэж хариулжээ. Харин ердөө 20 орчим хувь нь төрийн өнөөгийн арга хэмжээнүүдийг хангалттай гэж үзсэн байна.

**Зураг 5.6: Төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээнүүд гэр бүлд хангалттай гэж үзсэн байдал**



Насны бүлгээр харахад, төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээг гэр бүлд хангалттай гэж үнэлсэн хариултын хувь 15–17 насныхны дунд бусад насны бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. Харин “маш хангалтгүй” гэж үнэлсэн хариултын хувь 20-оос дээш насныхны дунд илүү өндөр байгаа нь нас ахихын хэрээр бодлогын бодит хэрэгжилт, үр нөлөөг илүү шүүмжлэлтэй үнэлэх хандлага нэмэгдэж байгааг илтгэж байна.


**Зураг 5.7: Төрөөс хүүхэд төрүүлэх, өсгөн хүмүүжүүлэхэд чиглэсэн өнөөгийн арга хэмжээнүүд гэр бүлд хангалттай гэж үзсэн байдал, насны бүлгээр**



“Ямар арга хэмжээ авах нь таны хүүхэдтэй болох шийдвэрт нөлөөлөх вэ?” гэсэн асуултад хариулагчдын ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь хүүхэд төрүүлэх үед

олгох мөнгөн тэтгэмжийг онцолсон байна. Мөн дөрвөн хүн тутмын нэг нь орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх, таван хүн тутмын нэг нь сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах болон хүүхэд төрүүлсний дараа гурван жилийн цалинтай чөлөө олгох нь чухал гэж хариулжээ. Харин зургаан хүн тутмын нэг нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох, найман хүн тутмын нэг нь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

**Зураг 5.8: Хүүхэдтэй болох шийдвэрт нөлөөлөх төрийн арга хэмжээ**




Судалгааны үр дүнг ерөнхийд нь дүгнэвэл, төрөлтийн талаарх хандлага харьцангуй эерэг байна гэж үзэх үндэслэлтэй байна. Тодруулбал, хүүхдүүд бидний амьдралыг илүү аз жаргалтай болгодог гэж дийлэнх олонх (95%) үзэж, улсын хэмжээнд төрөлтийн тоо буурч буйд анхаарал хандуулж, тодорхой хэмжээнд санаа зовниж, анхны хүүхдээ харьцангуй эрт төрүүлэх, цаашлаад “олон хүүхэдтэй” болох хүсэл сонирхол хадгалагдаж буй нь ажиглагдлаа. Гэсэн хэдий ч төрөөс одоогоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хангалтгүй гэж үнэлэгдэж байгаа тул төрөлтийг бодитоор дэмжихийн тулд эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, хувь хүний хөгжил зэрэг олон талт хүчин зүйлсийг хамарсан цогц, уялдаа бүхий бодлого хэрэгжүүлэх шаардлагатайг судалгааны үр дүн тодорхой харуулж байна.

## 5.2 Гэрлэлтийн талаарх хандлага

Одоо гэрлэлтийн талаарх хандлагыг авч үзье. Эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн анх гэрлэхэд хамгийн тохиромжтой гэж үзэж буй насны талаарх үзэл бодлыг хүйсээр нь зэрэгцүүлэн Зураг 5.9-д харууллаа. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь анхны гэрлэлтийн “тохиромжтой нас”-ыг 24–26 нас гэж үзэж байна. Тодруулбал, 15–34 насны эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь эмэгтэй хүн 24–26 насанд, 51.7 хувь нь эрэгтэй хүн мөн энэ насанд гэрлэх нь хамгийн тохиромжтой гэж хариулжээ. Үүнээс харахад, Монгол Улсад анхны гэрлэлтийн зохимжит нас 20-иод насны дунд үе дээр төвлөрсөн хэвээр байна.

**Зураг 5.9: Эмэгтэй, эрэгтэй хүний анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой насны талаарх хүлээлт**



Гэсэн хэдий ч эрэгтэйчүүдийн хувьд 27–29 нас (15.4 хувь) болон 30–32 нас (13.9 хувь)-ыг тохиромжтой гэж үзэх хариултын хувь харьцангуй өндөр байгаа нь хүйсийн ялгаатай хандлага оршсоор байгааг илтгэж байна. Энэ нь нийгэмд эрчүүдийг эмэгтэйчүүдээс арай хожуу, эдийн засгийн хувьд тогтворжсоны дараа гэрлэх ёстой гэсэн нийтлэг хүлээлттэй холбоотой гэж тайлбарлагддаг (Allendorf et al., 2017, pp. 1478–1479; Kalmijn, 2011, pp. 271–276; Chu et al., 2018, pp. 2358–2360). Ийм хүлээлт нь анхны гэрлэлт, улмаар анхны төрөлт хойшлох (postponement) нөхцөлийг бүрдүүлж, тухайн үеийн төрөлтийн түвшинд темпо нөлөө үүсгэх боломжтойг харуулж байна.

Гэрлэх насны талаарх нийгэм, хүн ам зүйн бүлгүүдийн ялгаатай хүлээлтийг Хавсралт Б дэх Хүснэгт Б1-д дэлгэрэнгүй үзүүлсэн болно (энд дурдаагүй тоон үр дүнг хавсралтаас харна уу).

Орон нутгийн ялгааг авч үзвэл, хөдөө орон нутагт гэрлэлтийн насыг харьцангуй залуугаараа төсөөлөх хандлага илүү ажиглагдаж байна. Тухайлбал, хөдөөгийн эмэгтэйчүүдийн 17.7 хувь нь эмэгтэй хүнд 21–23 нас тохиромжтой гэж үзсэн нь хотын эмэгтэйчүүдийн дунд илэрсэн 9.0 хувьтай харьцуулахад бараг хоёр дахин өндөр үзүүлэлт юм. Эрэгтэйчүүдийн хувьд ч мөн адил хөдөөд 24–26 насыг тохиромжтой гэж үзэх хувь (56.1 хувь) өндөр бөгөөд 30-аас дээш насыг дэмжих хандлага хот суурин газартай харьцуулахад бага байна.

Харин хот суурин газарт эмэгтэйчүүд хожуу гэрлэлтийг харьцангуй илүү хүлээн зөвшөөрч буй нь ажиглагдаж байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн 11.9 хувь нь эмэгтэй хүнд 27–29 нас тохиромжтой гэж үзсэн бол эрэгтэйчүүдийн хувьд 27-оос дээш насыг тохиромжтой гэж сонгосон хариултын хувь илүү өндөр байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б1).

Бүс нутгаар авч үзвэл, Баруун бүс гэрлэлтийн насны талаарх ойлголт хамгийн нягт төвлөрсөн бүсээр тодорч байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн 63.6 хувь, эрэгтэйчүүдийн 70.1 хувь нь 24–26 насыг анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой нас гэж үзсэн нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

Харин Зүүн бүсэд маш залуу (18–20 нас) болон харьцангуй хожуу (30–32 нас) гэрлэлтийг дэмжих хандлага зэрэгцэн оршиж байгаа нь бусад бүсүүдээс ялгарах сонирхолтой дүр зургийг харуулж байна. Тухайлбал, Зүүн бүсийн эмэгтэйчүүдийн 13.9 хувь нь эмэгтэй хүнд 18–20 нас тохиромжтой гэж үзсэн нь улсын дунджаас (5.2 хувь) 2.7 дахин өндөр үзүүлэлт болж байна.

Улаанбаатар хотын хувьд харьцангуй хожуу гэрлэлтийг дэмжих хандлага бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр байгаа нь онцлог ажиглагдаж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б1).

Судалгаанд оролцогчдын нас ахихын хэрээр “гэрлэхэд тохиромжтой” гэж үзэх нас мөн адил урагшилж байгаа хандлага ажиглагдаж байна. Залуу насны бүлгүүдийн хувьд гэрлэлтийн хамгийн тохиромжтой нас-ыг 24–26 нас гэж үзэх хариулт давамгай бөгөөд 15–17 насныхны 63.7 хувь, 18–20 насныхны 65.9 хувь нь энэ насыг онцолсон байна. Харин 21–24 болон 25–29 насныхны дунд 27–29 насыг тохиромжтой гэж үзэх хувь нэмэгдэж байгаа нь бодит амьдралын туршлага, боловсрол эзэмших хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлтэй уялдсан шийдвэрийн хойшлолт байж болохоор аж. Үүний зэрэгцээ 30–34 насныхны дунд 30–32 насанд гэрлэх нь тохиромжтой гэж үзэх хувь 20.1 хувьд хүрч, залуу насны бүлгүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байгаа нь нас ахих тусам гэрлэлтийн талаарх төсөөлөл бодит нөхцөл байдалтай илүү нийцэж өөрчлөгдөж байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б1).

Хүүхэдгүй эмэгтэйчүүдийн дунд эмэгтэй хүн 27–29 насанд гэрлэх нь тохиромжтой гэж үзэх хувь (15.1%) харьцангуй өндөр байгаа нь гэрлэлт ба төрөлтийг хоёуланг нь хойшлуулах стратеги давамгайлж байгааг илтгэж байна. Харин 2 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд эрт насанд гэрлэхийг зөвшөөрөх хандлага илүү байгаа нь зан төлөвийн бодит хэрэгжилт уламжлалт төсөөллөөс эрт эхэлснийг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б1).

Мэргэжлийн боловсролтой эмэгтэйчүүдийн дунд эрт гэрлэлтийг дэмжих хандлага харьцангуй хүчтэй байна. Тухайлбал, тэдний 30.0 хувь нь эмэгтэй хүн 21–23 насанд, 15.9 хувь нь бүр 18–20 насанд гэрлэх нь тохиромжтой гэж үзсэн нь дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хандлагатай эрс ялгаатай дүр зургийг харуулж байна. Үүний эсрэгээр дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтийн насыг хойшлуулах хандлага давамгай байна. Тодруулбал, тэдний 14.8 хувь нь эмэгтэй хүнд 27–29 насанд гэрлэх нь тохиромжтой гэж үзсэн бол эрэгтэйчүүдийн хувьд 27-оос дээш насыг дэмжсэн хариултын нийлбэр хувь ойролцоогоор 37 хувьд хүрчээ.

Одоогоор гэрлэсэн буюу хамтран амьдарч буй эмэгтэйчүүдийн дунд эмэгтэй хүн 21–23 насанд гэрлэхийг илүү тохиромжтой гэж үзэх хандлага ажиглагдаж байгаа бол огт гэрлэж байгаагүй эмэгтэйчүүдийн хувьд 27–29 насыг онцлон нэрлэх хандлага давамгайлж байна. Энэ ялгаа нь бодит туршлага дээр тулгуурласан гэрлэх насны төсөөлөл болон хүлээлт, төсөөлөлд суурилсан ойлголтын хооронд тодорхой зааг байгааг илтгэн харуулж байна.

Амьжиргааны түвшин дээшлэхийн хэрээр гэрлэх насыг хойшлуулах хандлага илүү тод илэрч байна. Тухайлбал, хамгийн чинээлэг бүлгийн эмэгтэйчүүдийн 24.3 хувь нь эмэгтэй хүнд 27–29 насанд гэрлэх нь тохиромжтой гэж үзсэн нь хамгийн доогуур орлоготой

бүлгийн үзүүлэлтээс (6.3 хувь) дөрөв дахин өндөр байна. Эрэгтэйчүүдийн хувьд ч мөн адил 27–29 насыг хамгийн тохиромжтой гэж үзэх хариулт 27.8 хувьд хүрчээ. Харин амьжиргааны түвшин доогуур бүлгийн дунд эмэгтэй хүнд 18–23 нас буюу харьцангуй залуу үед гэрлэх нь зохимжтой гэж үзэх хувь өндөр байна. Эдгээр ялгаанаас харахад, өндөр орлоготой бүлгүүдэд гэрлэлтийг хойшлуулах замаар төрөлтийг мөн хойшлуулж, улмаар төрөлтөд үзүүлэх темпо нөлөө харьцангуй хүчтэй илэрч болзошгүйг илтгэж байна.

Энэхүү судалгааны үр дүн нь Монгол Улсад гэрлэлтийн насны талаарх ойлголт боловсролын түвшин, амьжиргааны байдал, байршил зэрэг хүчин зүйлсээс хамааран хүчтэй давхраажиж байгааг тодорхой харуулж байна. Хотжилт, өндөр боловсрол, чинээлэг байдал нь гэрлэлтийн насыг, ялангуяа эмэгтэйчүүдийн хувьд, 20-иод насны дунд үеэс 20-иод насны сүүл, цаашлаад 30-аад нас руу шилжүүлэх хандлагыг өдөөж байна. Харин хөдөө орон нутагт амьдарч буй болон мэргэжлийн боловсролтой бүлгүүдийн дунд эрт гэрлэлтийг дэмжих уламжлалт хандлага харьцангуй тогтвортой хадгалагдсаар байгааг энэхүү шинжилгээ илтгэн харуулж байна.

Эмэгтэйчүүдийн гэрлэлтийг чухалчлах хандлагыг албан ёсны гэрлэлтийг хэр зэрэг ач холбогдолтойд тооцож буй байдал, хамтын амьдралын аль хэлбэрийг ерөнхийд нь илүү чухалчилж үздэг хандлага, мөн салалтыг хүлээн зөвшөөрөх эсэх гэсэн гурван үндсэн үзүүлэлтийн хүрээнд судалсан болно. Дараах тайлбарт багтаагаагүй дэлгэрэнгүй тоон үр дүнг Хавсралт Б дэх Хүснэгт Б2-оос харж болно.


Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь албан ёсны гэрлэлтийг өндөр ач холбогдолтой гэж үзэж байна. Тодруулбал, 57.9 хувь нь албан ёсны гэрлэлтийг маш чухал, 29.3 хувь нь чухал гэж үнэлсэн бөгөөд нийт дүнгээр бараг арван эмэгтэй тутмын найм нь (87.2 хувь) албан ёсны гэрлэлтэд өндөр ач холбогдол өгч байгаа нь харагдаж байна. Үүний зэрэгцээ хариулагчдын 73.2 хувь нь албан ёсны гэрлэлтийг хамтын амьдралын хамгийн чухал хэлбэр гэж үзсэн бол 15.1 хувь нь албан ёсны гэрлэлт болон хамтын амьдралыг хоёуланг нь чухалчилж байгаагаа илэрхийлжээ. Харин салалтын талаарх хандлагын хувьд 15.9 хувь нь огт хүлээн зөвшөөрөхгүй гэж хариулсан бол 30.9 хувь нь бүрэн хүлээн зөвшөөрнө, 49.2 хувь нь тодорхой нөхцөлд зөвшөөрнө гэж хариулсан байна. Эдгээр хариултаас харахад, салалтыг бүхэлд нь үгүйсгэхээс илүүтэйгээр нөхцөлтэйгээр хүлээн зөвшөөрөх хандлага эмэгтэйчүүдийн дунд давамгайлж байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Зураг 5.10-д 15–34 насны эмэгтэйчүүдийн амьдралын төлөвлөгөөндөө албан ёсны гэрлэлтэд өгч буй ач холбогдлын түвшин болон хамтын амьдралын аль хэлбэрийг илүү чухалчилж буй байдлыг хот, хөдөөгөөр харьцуулан дүрслэн харууллаа. Зурагт харуулснаар албан ёсны гэрлэлтийг чухалчлах хандлага хот, хөдөөгийн аль алинд нь ерөнхийдөө өндөр түвшинд байна. Тухайлбал, албан ёсны гэрлэлтийг “маш чухал” гэж үзсэн хувь хотод 57.8, хөдөөд 58.1 байгаа нь хоёр орчинд бараг ижил түвшинд байгааг илтгэнэ. Харин “чухал” гэж үнэлсэн хувь хотод 30.0, хөдөөд 26.8 хувь байгаа нь хот суурин орчинд албан ёсны гэрлэлтийг чухалчилж үзэх хандлага бага зэрэг илүү байгааг харуулж байна.

Албан ёсны гэрлэлтийг “дунд зэрэг” ач холбогдолтой гэж үзсэн хувь хотод 8.8, хөдөөд 6.6 хувь байгаа бол “бага зэрэг чухал” гэж хариулсан хувь хотод 1.7, хөдөөд 2.7 хувь

байна. Мөн “огт чухал биш” гэж үзсэн хувь хотод 1.3, хөдөөд 1.1 хувьтай байгаа нь албан ёсны гэрлэлтийн ач холбогдлыг бүрэн үгүйсгэх байр суурь нийтэд хязгаарлагдмал байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч “мэдэхгүй/хариулаагүй” гэсэн хариулт хотод 0.4 хувь байсан бол хөдөөд 4.7 хувь болж нэмэгдсэн нь хөдөө орон нутагт байр сууриа тодорхой илэрхийлэхгүй үлдэх тохиолдол харьцангуй түгээмэл байгааг харуулж байна.

**Зураг 5.10: Эмэгтэйчүүдийн (15-34 насны) амьдралын төлөвлөгөөнд албан ёсны гэрлэлтийн ач холбогдлын түвшин, ерөнхий ойлголтоор чухалд тооцогддог гэрлэлтийн хэлбэрүүд, хот хөдөөгөөр (%)**




Мөн “чухалчилдаг гэрлэлтийн хэлбэр”-ийн хувьд албан ёсны гэрлэлтийг чухал гэж үзэх хувь хотод 72.5, хөдөөд 75.2 хувь байгаа нь хот, хөдөөгийн аль алинд нь энэ хэлбэр давамгайл хэвээр байгааг нотолж байна. Үүний зэрэгцээ албан ёсны болон албан бус (хамтын амьдрал) хэлбэрийг хамтад нь чухалчлах хандлага хотод 16.7 хувь байгаа нь хөдөөд ажиглагдсан түвшнээс (10.0 хувь) өндөр бөгөөд хот суурин орчинд гэр бүлийн хэлбэрийн талаарх сонголт харьцангуй уян хатан байж болохыг илтгэнэ.

Харин хамтран амьдрах буюу албан бус холбоог чухалчлах хандлага хөдөөд 8.2 хувьтай байгаа нь хотынхтой (2.2 хувь) харьцуулахад илүү өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь хөдөө орон нутагт албан бус холбоог хүлээн зөвшөөрөх тодорхой бүлэг байгааг харуулж байна. Эцэст нь, гэрлэлтийн аль ч хэлбэрийг “чухалчилдаггүй” гэж хариулсан хувь хотод 4.8, хөдөөд 1.8 хувь байгаа бол “мэдэхгүй/хариулаагүй” гэсэн хариулт хотод 3.8, хөдөөд 4.7 хувьтай байгаа нь гэрлэлтийн хэлбэрийн талаарх асуултад хөдөө орон нутагт байр сууриа тодорхой илэрхийлэхгүй байх тохиолдол арай өндөр хэвээр байгааг илтгэж байна.

Зураг 5.11-д 15-34 насны эмэгтэйчүүдийн хувийн жинг салалтад хандах хандлагаар, хот хөдөөгөөр харьцуулж харуулав. Хот суурин газарт салалтыг бүрэн хүлээн зөвшөөрнө гэж хариулсан хувь 34.3, тодорхой нөхцөлд хүлээн зөвшөөрнө гэсэн хувь 51.8 байгаа нь нийлбэр дүнгээрээ арван эмэгтэй тутмын ес нь салалтыг ямар нэг хэлбэрээр зөвшөөрч байгааг илтгэж байна. Харин хөдөө орон нутагт салалтыг хүлээн зөвшөөрөх түвшин харьцангуй өндөр хэвээр байгаа ч хоттой харьцуулахад доогуур бөгөөд “огт зөвшөөрдөггүй” гэж хариулсан эмэгтэйчүүдийн хувь 31.0-д хүрч байгаа нь уламжлалт

гэр бүлийн тогтвортой байдлыг эрхэмлэх, гэр бүлийн задралаас зайлсхийх хандлага илүү хүчтэй байгааг харуулж байна.

**Зураг 5.11: Эмэгтэйчүүдийн (15-34 насны) салалтад хандах хандлагын хот, хөдөөгийн ялгаа (%)**



Бүс нутгийн ялгаатай байдлыг авч үзвэл, Баруун бүсэд албан ёсны гэрлэлтийг “маш чухал” гэж үзэх хувь хамгийн өндөр (63.3 хувь) байгаагаас гадна салалтыг “хүлээн зөвшөөрөхгүй” гэсэн хандлага мөн хамгийн өндөр түвшинд (43.1 хувь) илэрч байгаа нь уламжлалт үнэт зүйлс давамгайлж байгааг илтгэнэ.

Харин Хангайн болон Төвийн бүсүүдэд гэрлэлтийг өндөр ач холбогдолтойд тооцохын зэрэгцээ салалтыг “зарим тохиолдолд зөвшөөрнө” гэсэн хандлага ойролцоогоор 50 хувьтайгаар давамгайлж байгаа нь гэр бүлийн тогтвортой байдлыг эрхэмлэхийн зэрэгцээ уян хатан байр суурь баримталж байгааг харуулж байна.

Зүүн бүсийн хувьд албан ёсны гэрлэлтийг “маш чухал” гэж үзэх хувь харьцангуй бага (44.1 хувь), харин “чухал” гэж үнэлэх хувь өндөр (43.3 хувь) байгаа нь гэрлэлтийн ач холбогдлыг илүү уян хатан, шаталсан байдлаар үнэлэх хандлага давамгайлж байна.

Улаанбаатар хотод салалтыг бүрэн хүлээн зөвшөөрнө гэж үзэх хувь 36.8 хүрч, бусад бүсүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа бол “хүлээн зөвшөөрөхгүй” гэсэн хандлага хамгийн бага (7.7 хувь) байна. Энэ нь хот суурин орчинд гэр бүл, харилцааны асуудлыг илүү хувь хүний сонголт, тухайн нөхцөл байдалтай уялдуулан авч үзэх хандлага давамгайлж байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Насны бүлгээр, 18–20 болон 21–24 насныхны дунд албан ёсны гэрлэлтийг “маш чухал” гэж үзэх хувь хамгийн өндөр (71.8 ба 67.0 хувь) байгаа нь залуу насанд гэр бүлийн ирээдүйг уламжлалт, зорилгод суурилсан байдлаар төсөөлөх хандлага хүчтэй байна. Харин 30–34 насныхны хувьд салалтыг “хүлээн зөвшөөрөхгүй” гэж үзэх хувь (23.3 хувь) бусад насны бүлгүүдээс өндөр байгаа нь нас ахихын хэрээр бодит амьдралын туршлага, хариуцлагын мэдрэмжийг илүү харгалзан үзсэн, тогтвортой байдлыг эрхэмлэсэн болгоомжтой үнэлгээ давамгайлах хандлага ажиглагдаж байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүдийн хувьд албан ёсны гэрлэлтийг өндөр ач холбогдолтойд тооцохын зэрэгцээ салалтыг зарим тохиолдолд зөвшөөрнө гэж үзэх хандлага (51.4 хувь) давамгайлж байгаа нь гэр бүлийн тогтвортой байдлыг эрхэмлэхийн зэрэгцээ уян хатан байр суурь баримталж байгааг илтгэж байна. Харин хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд албан ёсны гэрлэлтийг маш чухал гэж үзэх хувь

62.3, чухал гэж үнэлэх хувь 21.9 байгаа бөгөөд хамтын амьдралын хэлбэрээс албан ёсны гэрлэлтийг онцгойлон чухалчилсан хариулт 76.6 хувьд хүрчээ. Үүний зэрэгцээ салалтыг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэх хувь 24.8 байгаагаараа бусад бүлгүүдээс өндөр байгаа нь хүүхдийн тоо нэмэгдэхийн хэрээр гэр бүлийн албан ёсны хэлбэр, тогтвортой байдлыг илүү чухалчлах хандлага давамгайлж буй юм (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дийлэнх нь албан ёсны гэрлэлтийг маш чухал (61.8 хувь) болон чухал (26.7 хувь) гэж үнэлсэн бөгөөд үүний зэрэгцээ 78.2 хувь нь хамтын амьдралын хэлбэрүүдээс албан ёсны гэрлэлтийг онцгойлон чухалчилж байгаагаар илэрхийлжээ. Мөн салалтыг бүрэн эсвэл тодорхой нөхцөлд зөвшөөрнө гэсэн хандлага 84.2 хувьд хүрсэн нь гэрлэлтийн үнэт зүйлийг хадгалах байр суурь давамгайлж хэвээр байгаа ч бодит нөхцөл байдалд суурилсан, уян хатан үнэлгээ давхар оршиж байгааг харуулж байна. Харин боловсролын түвшин харьцангуй доогуур бүлгүүдэд (ажиглалтын тоо хязгаарлагдмал хэдий ч) салалтыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн хандлага илүү өндөр байгаа нь уламжлалт гэр бүлийн ойлголт, үнэт зүйлс илүү хүчтэй хадгалагдаж байгааг илэрхийлж буй хэрэг юм (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Гэрлэж эсвэл хамтран амьдарч байсан эмэгтэйчүүдийн дунд салалтыг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэх хувь харьцангуй өндөр (18.7 хувь) байгаа нь бодит амьдралын туршлагад суурилсан болгоомжлол, гэр бүлийн тогтвортой байдлыг эрхэмлэх хандлагатай уялдаж байна. Харин огт гэрлэж байгаагүй эмэгтэйчүүдийн хувьд салалтыг зарим тохиолдолд зөвшөөрнө гэсэн хандлага давамгайлж (54.0 хувь), гэр бүлийн харилцааг илүү уян хатан, олон хувилбартайгаар үнэлэх чиг хандлага ажиглагдаж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Халх өрхийн тэргүүнтэй эмэгтэйчүүдийн дунд албан ёсны гэрлэлтийг чухалчлахын зэрэгцээ салалтыг зарим тохиолдолд зөвшөөрнө гэсэн хандлага (50.3 хувь) давамгайлж байгаа нь уламжлалт үнэт зүйлс болон нөхцөл байдалд суурилсан уян хатан үнэлгээ хослон илэрч байгааг харуулж байна. Харин Казах, Дөрвөд, Буриад угсаатны бүлгүүдийн хувьд салалтыг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэх хувь харьцангуй өндөр (43.9 хувь) байгаа нь гэр бүлийн тогтвортой байдал, уламжлалт хандлагыг илүү хүчтэй баримталж байна. Үүний зэрэгцээ бусад угсаатны бүлгүүдэд салалтыг зарим тохиолдолд зөвшөөрнө гэсэн хандлага 62.2 хувьд хүрч байгаа нь гэрлэлтийн асуудлыг илүү олон хувилбараар, уян хатан байдлаар үнэлэх чиг хандлага тод илэрч байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).


Өрхийн аж байдлын түвшнээр харахад, салалтын талаарх хандлага тодорхой ялгаатай байна. Аж байдлын хамгийн доогуур түвшинтэй бүлэгт салалтыг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэх хувь харьцангуй өндөр (31.2 хувь) байгаа нь эдийн засгийн эмзэг нөхцөлд гэр бүлийн тогтвортой байдлыг онцгойлон чухалчлах хандлагатай нягт уялдаж байна. Харин аж байдлын хамгийн дээгүүр түвшинтэй бүлгийн хувьд салалтыг бүрэн зөвшөөрнө гэж үзэх хувь өндөр (48.1 хувь) байгаагаас гадна хүлээн зөвшөөрөхгүй гэсэн байр суурь бараг ажиглагдахгүй (0.8 хувь) байна. Энэ нь эдийн засгийн баталгаатай байдал нь гэр бүлийн харилцаа, шийдвэрийг илүү нөхцөлд суурилсан, уян хатан байдлаар үнэлэх боломжийг нэмэгдүүлж байгааг илтгэж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б2).

Зураг 5.12-т 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдийн тархалтын хувийг дүрслэн харуулав. Зургаас харахад гэрлэлтэд тавигдах

зайлшгүй нөхцлүүдийн дунд санхүүгийн тогтвортой байдал хамгийн өндөр ач холбогдолтой байгааг харуулж байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 37.0 хувь уг хүчин зүйлийг гэрлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзжээ. Үүний дараагаар тогтвортой ажлын байр (26.4 хувь) болон амьдрах сууцтай байх (25.1 хувь) нь харьцангуй өндөр хувь эзэлж, гэрлэлтийг эдийн засгийн болон амьдралын баталгаатай байдалтай шууд холбон ойлгож буй хандлага давамгайл байгааг илтгэнэ.

Харин хань болох хүний санал (19.8 хувь) болон эцэг, эхийн зөвшөөрөл (14.8 хувь) зэрэг харилцаа, уламжлалтай холбоотой хүчин зүйлс тодорхой ач холбогдолтой хэвээр байгаа ч эдийн засгийн нөхцлүүдтэй харьцуулахад доогуур түвшинд үнэлэгдэж байна. Боловсрол (12.2 хувь) болон бусад нөхцөлүүд (12.1 хувь) нь дунджаас доогуур түвшинд дурдагдсан бол жирэмслэлт (2.3 хувь)-ийг гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөл гэж үзсэн хувь маш бага байгаа нь гэрлэлт ба хүүхэд төрүүлэх шийдвэрийг тусад нь авч үзэх хандлага түгээмэл болсныг харуулж байна. Мөн хариулаагүй ангиллын хувь харьцангуй өндөр (13.5 хувь) байгаа нь зарим эмэгтэйчүүдийн хувьд гэрлэлтийн шаардлагын талаарх байр суурь бүрэн төлөвшөөгүй, тодорхой бус байж болзошгүйг илтгэж байна.

**Зураг 5.12: 15–34 насны эмэгтэйчүүдийн хувийн жингийн тархалт, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдээр (%)**



Хот, хөдөөгийн 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдийн тархалтын ялгааг Хүснэгт 5.8-д харьцуулан үзүүллээ. Хүснэгтээс харахад хот, хөдөөгийн эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтэд тавигдах шаардлагатай нөхцлүүдийн ач холбогдолд тодорхой ялгаа ажиглагдаж байна.

**Хүснэгт 5.8: Хот, хөдөөгийн 15–34 насны эмэгтэйчүүдийн хувь, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдээр (%)**

Хот	%	Хөдөө	%
Санхүүгийн тогтвортой байдал	40.6	Санхүүгийн тогтвортой байдал	25.7
Тогтвортой ажлын байр	28.3	Амьдрах сууцтай байх	25.3
Амьдрах сууцтай байх	25.0	Тогтвортой ажлын байр	20.4
Хань болох хүний санал	19.9	Хань болох хүний санал	19.3
Эцэг, эхийн зөвшөөрөл	14.8	Эцэг, эхийн зөвшөөрөл	14.9
Боловсрол	13.0	Бусад	13.4
Бусад	11.7	Боловсрол	9.9
Жирэмслэлт	3.0	Жирэмслэлт	0.3

Тодруулбал, хот суурин газарт амьдарч буй эмэгтэйчүүд гэрлэлтийг илүү эдийн засгийн баталгаанд суурилсан шийдвэр гэж үзэх хандлагатай байхад хөдөө орон нутагт амьдрах орчны баталгаа болон уламжлалт хүчин зүйлс харьцангуй жигд ач холбогдолтой хэвээр байгааг харуулж байна.

Хот суурингийн орчинд гэрлэлтийг санхүүгийн тогтвортой байдал (40.6 хувь) болон тогтвортой ажлын байр (28.3 хувь) зэрэг эдийн засгийн баталгаатай хамгийн хүчтэй холбон үзэж байгаа нь хотын амьдралын өндөр өртөг, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөлтэй шууд уялдаж байна. Үүний дараагаар амьдрах сууцтай байх (25.0 хувь) нь чухал нөхцөлд тооцогдож, гэрлэлтийг бие даасан амьдралын материаллаг суурьтай шууд холбон ойлгож буй хандлага давамгайлж байгааг илтгэж байна.

Харин хөдөө орон нутагт гэрлэлтэд тавигдах нөхцлүүдийн дунд санхүүгийн тогтвортой байдал (25.7 хувь) болон амьдрах сууцтай байх (25.3 хувь) ойролцоо түвшинд үнэлэгдэж байгаа нь эдийн засгийн болон орон сууцны баталгаа ижил ач холбогдолтой байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ тогтвортой ажлын байр (20.4 хувь) хот суурин газартай харьцуулахад доогуур үнэлэгдэж байгаа нь хөдөө орон нутагт албан ёсны хөдөлмөрийн зах зээл харьцангуй хязгаарлагдмал, өөр төрлийн амьжиргааны эх үүсвэрүүд илүү давамгайлж байгаатай холбоотой юм.

Хот, хөдөөгийн аль алинд нь хань болох хүний санал (хотод 19.9 хувь, хөдөөд 19.3 хувь) болон эцэг, эхийн зөвшөөрөл (хотод 14.8 хувь, хөдөөд 14.9 хувь) ойролцоо түвшинд илэрч байгаа нь харилцаа болон уламжлалтай холбоотой хүчин зүйлс тодорхой ач холбогдолтой хэвээр байгааг харуулж байна. Харин жирэмслэлтийг гэрлэлтэд зайлшгүй нөхцөл гэж үзэх хувь хотод 3.0 хувь, хөдөөд 0.3 хувьтай байгаа нь гэрлэлт болон хүүхэд төрүүлэх шийдвэрийг хооронд нь ялган, тусад нь авч үзэх хандлага нийтлэг болж байгааг илтгэж байна.

Бүс нутгийн ангиллаар, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдийн бүтэц тодорхой ялгаатай байна. Улаанбаатар хотод санхүүгийн тогтвортой байдал (45.6 хувь), тогтвортой ажлын байр (29.8 хувь) зэрэг эдийн засгийн баталгааг чухалчлах хандлага бусад бүсээс хамгийн өндөр байгаа нь нийслэлийн амьдралын өртөг, хөдөлмөрийн зах зээлийн өндөр өрсөлдөөнтэй шууд холбоотой. Харин Баруун бүсэд тогтвортой ажлын байр (31.6 хувь) болон амьдрах сууцтай байх (29.0 хувь) нөхцөлийг өндөр үнэлж байгаа нь бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт, амьдрах орчны тогтвортой байдлыг гэрлэлтийн гол суурь гэж үзэж буйг илтгэнэ.

Хангай болон Төвийн бүсэд амьдрах сууцтай байх (30.5 хувь; 27.7 хувь) болон хань болох хүний санал (29.5 хувь; 27.7 хувь) харьцангуй өндөр хувьтай байгаа нь эдийн засгийн болон харилцааны хүчин зүйлсийг хослон чухалчилж буйг харуулж байна. Харин Зүүн бүсэд гэрлэлтэд тавигдах нөхцөлүүдийн дунд тодорхой нэг хүчин зүйл илт давамгайлахгүй, мөн хариулаагүй хувь (31.6 хувь) өндөр байгаа нь гэрлэлтийн талаарх байр суурь харьцангуй тодорхой бус, тогтворжоогүй байж болзошгүйг илэрхийлж байж магадгүй (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Хотжилтын түвшнээр ангилж үзэхэд, гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүдийн ач холбогдол бүс бүрт ялгаатай байна. Хотын бүсэд санхүүгийн тогтвортой байдал (46.8 хувь), тогтвортой ажлын байр (30.2 хувь) зэрэг эдийн засгийн нөхцөлүүдийг гэрлэлтийн үндсэн шаардлага гэж үзэх хандлага хамгийн өндөр байгаа нь хотын амьдралын өртөг, хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнтэй уялдаж байна.

Суурин газар болон хагас нягтралтай бүсэд амьдрах сууцтай байх (29.2 хувь) болон хань болох хүний санал (25.0 хувь) харьцангуй өндөр хувьтай илэрч байгаа нь амьдралын орчны тогтвортой байдал, харилцааны хүчин зүйлсийг гэрлэлтийн шийдвэрт чухалчилж байгааг харуулж байна. Харин хөдөөгийн бүсэд санхүү, ажлын байр, орон сууц зэрэг нөхцөлүүд харьцангуй жигд түвшинд үнэлэгдэж, эцэг, эхийн зөвшөөрөл (18.1 хувь) хотын бүсээс илүү өндөр байгаа нь уламжлалт үнэт зүйлсийн нөлөө хадгалагдсаар байгааг илтгэнэ (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Насны бүлгийн ялгаагаар шинжилбэл, гэрлэлтэд тавигдах шаардлагуудын ач холбогдол тодорхой өөрчлөгдөж байна. Тухайлбал, 18–29 насны эмэгтэйчүүдийн хувьд санхүүгийн тогтвортой байдал болон тогтвортой ажлын байрыг гэрлэлтэд чухалчлах хандлага өндөр байгаа нь амьдралын сууриа бүрдүүлэх үе шаттай шууд уялдаж байгааг илтгэнэ.

Харин 30–34 насны бүлэгт амьдрах сууцтай байх (31.2 хувь) болон хань болох хүний санал (31.4 хувь) илүү өндөр хувьтай илэрч, бодит амьдралын туршлага, харилцааны чанарт тулгуурласан илүү тэнцвэртэй үнэлгээ давамгайлж байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ асуултад хариулаагүй хувь 15–17 насныханд (20.8 хувь) харьцангуй өндөр байгаа нь энэ насны бүлэгт гэрлэлтийн талаарх ойлголт, хүлээлт бүрэн төлөвшөөгүй байгаагийн илрэл гэж тайлбарлаж болно (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Хүүхэд төрүүлсэн эсэхээс хамааран гэрлэлтэд тавигдах шаардлагын ач холбогдолд тодорхой ялгаа ажиглагдаж байна. Хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүд санхүүгийн тогтвортой байдал (42.5 хувь) болон тогтвортой ажлын байрыг (25.7 хувь) илүү чухалчилж байгаа нь гэрлэлтийг эдийн засаг, амьдралын суурьтай нягт холбон ойлгож байгааг илтгэнэ.

Харин нэг хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд амьдрах сууцтай байх (32.9 хувь) онцгой ач холбогдолтой болж, хүүхэдтэй болсноор амьдрах орчны баталгааг илүү чухалчлах хандлага нэмэгдэж байгааг харуулж байна. Хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй бүлэгт хань болох хүний санал (26.3 хувь) болон бусад нөхцөлүүд (15.3 хувь) харьцангуй өндөр хувьтай илэрч, гэрлэлтийг илүү өргөн хүрээнд, бодит туршлага дээр суурилан үнэлэх чиг хандлага төлөвшиж буйг илтгэнэ (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Боловсролын түвшнээр авч үзэхэд, дээд боловсролтой эмэгтэйчүүд санхүүгийн тогтвортой байдал (41.5 хувь), тогтвортой ажлын байр (28.1 хувь)-ыг гэрлэлтэд зайлшгүй нөхцөл гэж үзэх нь өндөр байна. Харин техникийн болон мэргэжлийн боловсролтой бүлэгт амьдрах сууцтай байх (50.2 хувь) хамгийн өндөр хувьтай байгаа нь практик, бодит хэрэгцээнд суурилсан хандлага давамгайлж байгааг илтгэнэ. Бүрэн дунд боловсролтой бүлэгт нөхцөлүүд харьцангуй жигд үнэлэгдсэн нь гэрлэлтийн талаарх ойлголт илүү олон хүчин зүйлд тулгуурлаж байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Гэрлэж байсан буюу хамтран амьдарч байсан эмэгтэйчүүд амьдрах сууцтай байх (29.8 хувь) болон хань болох хүний санал (22.1 хувь)-ыг илүү чухалчилж байгаа нь бодит амьдралын туршлагаас үүдэн гэрлэлтийг харилцаа, хамтын амьдралын баталгаатай холбон ойлгож байгаагийн илэрхийлэл юм. Харин огт гэрлээгүй эмэгтэйчүүд санхүүгийн тогтвортой байдал (41.0 хувь) болон боловсрол (14.5 хувь)-ыг харьцангуй өндөр үнэлж байгаа нь гэрлэлтийг ирээдүйн амьдралын бэлтгэл, хувь хүний хөгжилтэй илүү холбон ойлгож байгааг харуулж байна (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).


Казах, дөрвөд, буриад өрхийн тэргүүнтэй эмэгтэйчүүдийн хувьд тогтвортой ажлын байр (35.6 хувь) болон амьдрах сууцтай байх (36.9 хувь)-ыг өндөр үнэлсэн нь гэрлэлтийг амьдралын бодит баталгаатай шууд холбож байгаагийн илрэл юм. Харин бусад угсаатны бүлэгт санхүүгийн тогтвортой байдал (60.1 хувь) онцгой өндөр хувьтай байгаа нь эдийн засгийн баталгааг хамгийн чухал нөхцөл гэж үзэж байгаагийн нотолгоо мөн (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Өрхийн аж байдлын түвшнээр авч үзэхэд, хамгийн дээд түвшний амьжиргаатай өрхөд санхүүгийн тогтвортой байдал (52.2 хувь) гэрлэлтэд тавигдах нэн тэргүүний шаардлага болж байхад доод түвшний өрхөд амьдрах сууцтай байх, хань болох хүний санал зэрэг нөхцөлүүд харьцангуй жигд үнэлэгдэж байв (Хавсралт Б дэх Хүснэгт Б3).

Ерөнхийд нь дүгнэхэд, 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтэд тавигдах зайлшгүй нөхцөлүүд нь эдийн засаг болон амьдралын бодит баталгаанд төвлөрсөн хэв шинжтэй байгааг харуулж байна. Үүний зэрэгцээ энэхүү үнэлгээ нь нийгэм, эдийн засгийн байдал, орон зайн ялгаа, амьдралын үе шат зэргээс хамааран харилцан адилгүй илэрч, гэрлэлтийг ойлгох хандлага нэгэн жигд бус, олон хүчин зүйлийн огтлолцолд бүрэлдэж байгааг илэрхийлж байна.

Гэрлээгүй үед хүүхэд төрүүлэх асуудалд 15–34 насны эмэгтэйчүүд хэрхэн хандаж байгааг Зураг 5.13-т дүрслэн харуулав.

**Зураг 5.13: 15–34 насны эмэгтэйчүүдийн хувийн жингийн тархалт, гэрлээгүй үед хүүхэд төрүүлэхийг хүлээн зөвшөөрөх байдлаар (%)**



Нийт 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд гэрлээгүй үед хүүхэд төрүүлэхийг бүрэн хүлээн зөвшөөрөх хандлага 33.1 хувь, зарим тохиолдолд зөвшөөрөх байр суурь 45.0

хувьтайгаар давамгайлж байгаа бол огт хүлээн зөвшөөрөхгүй гэсэн байр суурь 18.9 хувийг эзэлж байна.

Шинж байдлын үзүүлэлтүүдээр ялгааг харвал (Хавсралт хүснэгт 4.11.2\*), хотын эмэгтэйчүүдийн дунд бүрэн хүлээн зөвшөөрөх хувь (36.0 хувь) хөдөөгийнхөөс (23.9 хувь) өндөр байгаа бол огт хүлээн зөвшөөрөхгүй хандлага хөдөөд (27.3 хувь) хотынхоос (16.3 хувь) илүү байна. Бүс нутгийн хувьд Баруун бүсэд огт хүлээн зөвшөөрөхгүй байр суурь хамгийн өндөр (45.5 хувь), харин Хангай болон Төвийн бүсэд зарим тохиолдолд гэсэн байр суурь давамгайлж байна. Улаанбаатар хотод бүрэн хүлээн зөвшөөрөх хувь (39.2 хувь) харьцангуй өндөр байна.

Хотжилтын түвшин, боловсрол, өрхийн аж байдлын түвшингээр авч үзэхэд хотын, их, дээд боловсролтой, өрхийн аж байдлын дээд түвшний эмэгтэйчүүдийн дунд гэрлэхээс өмнө хүүхэд төрүүлэхийг бүрэн хүлээн зөвшөөрөх хандлага харьцангуй өндөр байна. Харин хөдөөгийн, аж байдлын доод түвшин дэх бүлэг болон Казах, Дөрвөд, Буриад өрхийн тэргүүнтэй бүлэгт огт хүлээн зөвшөөрөхгүй байр суурь илүү түгээмэл байгаа нь уламжлалт гэр бүлийн ойлголт, соёлын нөлөө хүчтэй хэвээр байгааг илтгэнэ.

Нас, төрөлтийн тооны хувьд залуу болон хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүдэд зарим тохиолдолд гэрлээгүй байхдаа хүүхэд төрүүлж болох юм гэсэн байр суурь давамгайлж, харин хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд бүрэн хүлээн зөвшөөрөх хувь нэмэгдэж байна.

Хавсралт Б дэх Хүснэгт Б4-т 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд гэрлэлтийн асуудлаар гэр бүл, үе тэнгийнхэн, нийгэм болон бусад эх сурвалжаас дарамт, нөлөөлөл мэдэрсэн эсэхийг нарийвчлан харуулсан. Судалгааны үр дүнгээс харахад, Монголын залуу эмэгтэйчүүдийн дийлэнх нь (95.5 хувь) гэрлэлттэй холбоотойгоор ямар нэгэн дарамт, нөлөөлөл мэдрээгүй гэж хариулсан нь гэрлэх асуудалд хувь хүний эрх чөлөө, бие даасан шийдвэр гаргах боломж харьцангуй өндөр түвшинд байгааг илтгэнэ. Гэсэн хэдий ч дарамт, нөлөөлөл мэдэрсэн цөөнхийн (4.5 хувь, n=817) дунд тэдний талаас илүү хувь буюу 55.5 хувь (n=37) нь уг нөлөөлөл гэрлэлтийн талаарх хувийн шийдвэрт нь бодитой нөлөө үзүүлсэн гэж хариулсан нь зарим бүлгийн хувьд нийгэм, ойрын орчны шахалт шийдвэр гаргалтад чухал хүчин зүйл болж байгааг харуулж байна.

Орон зайн хувьд дарамт, нөлөөлөл мэдэрсэн хувь Улаанбаатар хотод (6.1 хувь) болон хотын орчинд (5.9 хувь) харьцангуй өндөр байгаа бол хөдөө орон нутагт (3.6 хувь) доогуур түвшинд илэрч байна. Насны бүлгийн хувьд дарамт, нөлөөлөл мэдэрсэн хувь 21–24 насныханд (6.8 хувь) болон 25–29 насныханд (5.8 хувь) илүү өндөр байгаа нь амьдралын энэ үе шатанд гэрлэлттэй холбоотой нийгмийн хүлээлт илүү хүчтэй байж болзошгүйг илтгэнэ.

Төрөлтийн тоогоор авч үзэхэд, нэг хүүхэдтэй эмэгтэйчүүдийн дунд (9.6 хувь) дарамт, нөлөөлөл мэдэрсэн хувь хамгийн өндөр байгаа бол хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйчүүдэд (1.1 хувь) хамгийн бага байна. Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн дунд (6.8 хувь) дарамт, нөлөөлөл мэдэрсэн хувь бусад боловсролын түвшнээс өндөр байна.

Өрхийн аж байдлын түвшнээр, дээд түвшний өрхийн эмэгтэйчүүдийн дунд (8.8 хувь) дарамт, нөлөөлөл мэдэрсэн хувь харьцангуй өндөр байгаа нь эдийн засгийн болон

нийгмийн орчин тэлэхийн хэрээр гэрлэлтийн талаарх хүлээлт, нөлөөлөл нэмэгдэх боломжтойг харуулж байна. Дарамт, нөлөөлөл нь гэрлэлтийн талаарх хувийн шийдвэрт хэрхэн нөлөөлснийг нарийвчлан ангилахад ажиглалтын тоо цөөн (n=21) тул тайлбарлах боломж хязгаарлагдмал байна.

Ерөнхийд нь авч үзвэл, гэрлэлтийн талаарх нийгмийн дарамт 15–34 насны эмэгтэйчүүдийн дунд түгээмэл бус (4.5 хувь) боловч, уг дарамтыг мэдэрсэн тохиолдолд хувь хүний гэрлэлтийн шийдвэрт бодитой нөлөө үзүүлэх магадлал өндөр байна.

Гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэр нь хувь хүний дотоод үнэт зүйлсээс гадна гэр бүл, хосын харилцаа, үе тэнгийнхэн, нийгмийн нийтлэг хандлага, мэдээллийн орчин зэрэг олон түвшний хүчин зүйлсийн нөлөөн дор бүрэлддэг цогц үйл явц юм.

Хавсралт Б дэх Хүснэгт Б5-д 15–34 насны эмэгтэйчүүдийн гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэрт нь аль хувь хүний болон нийгэм-соёлын хүчин зүйлс нөлөөлсөн эсвэл цаашид нөлөөлөх магадлалтай байгааг орон зайн, насны, боловсролын болон нийгэм-эдийн засгийн ялгаатай бүлгүүдээр харьцуулан харууллаа.

Гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэрт 15–34 насны эмэгтэйчүүдийн хувьд өөрийн хүсэл сонирхол, хувийн үнэт зүйлс (89.5 хувь) болон хос буюу хамтран амьдрагчийн санал (87.4 хувь) хамгийн өндөр нөлөөтэй хүчин зүйлсээр тодорч байна. Үүний дараагаар гэр бүлийн гишүүдийн санал (59.4 хувь) тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа бол үе тэнгийнхэн (25.7 хувь), нийгмийн нийтлэг хандлага, уламжлалт үнэлэмж (15.4 хувь), нийгмийн сүлжээ болон цахим орчны нөлөөлөл (7.5 хувь) нь харьцангуй бага нөлөө үзүүлж байгааг харуулж байна.

Орон зайн хувьд хот, Улаанбаатар хотод хувь хүний болон хосын нөлөө илүү давамгайлж (өөрийн хүсэл сонирхол: 94.9 хувь; хосын санал: 91.6 хувь), харин хөдөө орон нутаг болон зарим бүс нутагт гэр бүлийн (57.7–65.4 хувь), уламжлалт (19.2–26.0 хувь) болон үе тэнгийн нөлөө (29.1–35.8 хувь) харьцангуй өндөр илэрч байна.

Нас, төрөлтийн тоо, боловсролын ялгаагаар, залуу, огт гэрлээгүй болон хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүдэд гэр бүл (62.9–66.7 хувь) болон үе тэнгийн нөлөө (31.1–39.0 хувь) илүү мэдрэгдэж байгаа бол нас ахих, хүүхэдтэй болох, боловсролын түвшин өсөхийн хэрээр хувь хүний сонголт (91.6–98.6 хувь) болон хосын харилцааны нөлөө (87.1–93.1 хувь) давамгайлах хандлага ажиглагдаж байна.

Ерөнхийдөө, гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэр нь 15–34 насны эмэгтэйчүүдийн хувьд гадаад нийгмийн шахалтаас илүүтэйгээр хувь хүний үнэт зүйлс болон хосын харилцаанд суурилсан шинжтэй (89.5–87.4 хувь) бөгөөд энэ хандлага нь нийгэм-соёлын орчин, амьдралын үе шаттай уялдан өөр өөрөөр илэрч байна.

## **БҮЛЭГ 6: ТӨРӨЛТИЙН ТАЛААРХ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭ**

Энэ бүлэгт төрөлтийг дэмжих чиглэлээр улс орнуудад хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг санхүүгийн дэмжлэг, хүүхэд асаргааны үйлчилгээ, ажил–гэр бүлийн тэнцвэр гэсэн гурван үндсэн чиглэлээр нэгтгэн, тэдгээрийн сайн туршлага, бодлогын сургамжийг тодорхойллоо. Судалгаанд Европ, Хойд Америк, Зүүн Ази, Төв Азийн орнуудын жишээг хамруулж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, хязгаарлалт, харьцангуй давуу талыг тодруулав. Мөн Монгол Улсын өнгөрсөн болон өнөөгийн хүн амын төрөлтийг дэмжих бодлого, гол арга хэмжээний талаар хийсэн дүн шинжилгээг танилцуулж байна.

### **6.1 Дэлхийн улс орнуудын бодлого, арга хэмжээ**

Дэлхийн олон улс хүн амын төрөлтийг дэмжих бодлогоо мөнгөн тэтгэмж, орон сууц, татварын урамшуулал, чанартай хүүхэд асаргааны үйлчилгээ, уян хатан хөдөлмөр эрхлэлтийн чиглэлд цогцоор төлөвлөж, “Ажил - Гэр бүл”-ийн тэнцвэрийн зохицлыг бодлогоор шийдэхээр ажиллаж байна. Тэдний хувьд богино хугацааны бэлэн мөнгөн урамшууллаас илүүтэй тогтвортой үйлчилгээ ба дэд бүтэц, зөвхөн эхчүүд бус эцгүүдийн чөлөөг бодитоор дэмжих хүйсийн тэгш оролцоо, зорилтот бүлэгт чиглэсэн, өгөгдөлд суурилсан хэрэгжилтийн удирдлага менежментийг чухалчилж байна. Төрөлтийг дэмжих бодлого амжилттай хэрэгжих эсэх нь нэг удаагийн тэтгэмж бус, харин амьдралын мөчлөг дагасан бодлогын багц буюу хүүхэд асаргааны үйлчилгээ, сургуулийн хүртээмж, түрээс/ипотекийн зээлийн дэмжлэг, эцэг, эхийн уян хатан ажлын горим, татварын хөнгөлөлтөөс ихээхэн хамаарч байгаа нь өнгөрсөн үеийн туршлагаас харагдаж байна. Төрөлтийг дэмжих бодлого цогц хандлагатай бол төрөлтийн шийдвэрт нөлөөлдөг эдийн засаг, цаг хугацаа, нийгмийн хэм хэмжээний саад зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөллийг бууруулах боломжтой аж.

Санхүүгийн дэмжлэг нь төрөлтийг дэмжих бодлогын хамгийн өргөн хэрэглэгддэг хэрэгсэл юм. Олон улс хүүхдийн мөнгөн тэтгэмж, татварын хөнгөлөлтийг төрөлтийн шийдвэрт нөлөөлөх үндсэн хөшүүрэг болгон ашиглаж ирсэн. Ялангуяа, шууд мөнгөн тэтгэмж, хүүхдийн тооноос хамаарсан нэмэгдэл, татварын хөнгөлөлт нь өрхийн санхүүгийн дарамтыг бууруулах зорилгоор хэрэглэгдэж байна. Франц, Швед, Герман, Унгар, Польш зэрэг Европын улсууд, Сингапур, Япон, Өмнөд Солонгос зэрэг Азийн улсууд мөнгөн тэтгэмж, татварын дэмжлэгийг урт хугацаанд хэрэгжүүлж байна. Гэхдээ богино хугацааны тэтгэмж нь төрөлтөд түр зуурын нөлөө үзүүлж, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахгүй байгааг эдгээр улс орнуудын туршлага харуулж байна.

Хүүхэд асаргааны үйлчилгээ нь төрөлтийн бодлогын “далд хөдөлгүүр” гэж хэлж болохоор чухал хэрэгсэл юм. Учир нь хүүхэд асаргааны үйлчилгээ сайн байвал эцэг, эхийн ажил эрхлэлт хадгалагдаж, хоёр дахь хүүхэдтэй болох шийдвэр “боломжтой” болж хувирдаг. Тухайлбал, Франц, Швед, Герман, Канад зэрэг орнууд 0–3 наснаас эхлэн хүүхэд асрах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг төрийн баталгаатай, өргөн хүртээмжтэй болгосноор эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хадгалах боломжийг бүрдүүлсэн байна.

Ажил–гэр бүлийн тэнцвэрийг хангах бодлого нь төрөлтийн шийдвэрт шууд бус боловч маш хүчтэй нөлөө үзүүлдэг. Швед, Герман, Канад зэрэг орнууд урт хугацааны, уян хатан эцэг, эхийн чөлөөг хуульчилж, аавын заавал авах сар (father quota) нэвтрүүлснээр хүүхэд асрах үүргийг жендерийн хувьд тэнцвэржүүлж чадсан байна. Энэ нь эмэгтэйчүүдийн карьер тасалдах эрсдэлийг бууруулж, хоёр дахь болон дараагийн хүүхэд төрүүлэх

боломжийг нэмэгдүүлдэг аж. Ялангуяа, Шведийн 480 өдрийн эцэг, эхийн чөлөө нь өрхүүд өөрийн нөхцөлдөө тохируулан ашиглах боломжтой байдгаараа онцлог. Франц, Герман улсад уян хатан ажлын цаг, хагас цагаар ажиллах боломж, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн зохицуулалтууд нь хүүхэдтэй өрхийн хөдөлмөр эрхлэлтийг хадгалах чухал нөхцөл болж байна. Харин Япон, Өмнөд Солонгост урт ажлын цаг, ажил олгогчийн соёлын хатуу байдал нь хууль эрх зүйн боломж байгаа ч бодит хэрэгжилтийг хязгаарлаж, төрөлтийн бодлогын үр нөлөөг сулруулж байгаа нь бодууштай сургамж байна.

### *Европ, Хойд Америкийн орнуудын туршлага, сургамж*

**Франц** улс өндөр түвшний төрийн татаас буюу хүүхдийн мөнгө, татварын хөнгөлөлтийг олон жил тогтвортой хэрэгжүүлж ирсэн. Энэ нь өрхүүдийн хүүхэдтэй болох шийдвэрийг буюу эрсдэлийг багасгаж, урьдчилан төлөвлөх боломжтой болгож өгдөг. Франц хүүхдийн мөнгө, татварын хөнгөлөлт, нийгмийн үйлчилгээний дэмжлэгийг олон арван жилийн турш тасралтгүй хэрэгжүүлсэн нь төрөлтийн түвшинг Европын бусад орнуудтай харьцуулахад харьцангуй тогтвортой түвшинд хадгалахад нөлөөлсөн. Гэхдээ сүүлийн жилүүдэд орон сууц, амьжиргааны өртөг, ажил-амьдралын зохицуулалт зэрэг бүтцийн хүчин зүйлс хүчтэй нөлөөлж төрөлтийн түвшин бага зэрэг буурчээ. Өөрөөр хэлбэл, мөнгөн дэмжлэг өөрөө чухал ч тэр нь дангаараа баталгаат өсөлт авчрахгүй, харин хүүхэд асаргааны үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн орчинтой хослох шаардлагатай гэдгийг Францын жишээ сануулж байна.

#### **Шигтгээ 6.1. Франц: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

##### **Сайн туршлага**

- **Багц бодлого:** Мөнгө, татвар, үйлчилгээ, чөлөөг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлж ирсэн нь төр, өрхийн төлөвлөлтөд тодорхой байдлаар дэмжлэг үзүүлж чаддаг.
- **Хүүхэд харах үйлчилгээ/Сургуулийн өмнөх боловсрол:** Хамрагдалт маш өндөр, 3 наснаас бүх нийтэд, эцэг эхийн ажиллах боломж/шийдвэрийг дэмждэг.
- **Татварын уян хатан хэлбэр:** Хүүхдийн тоо өсөхийн хэрээр татварын ачаалал буурдаг.
- **Эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлсэн шинэчлэлүүд:** Эцэг/хамтрагчийн чөлөө олголт, сунгалт

##### **Сургамж**

- Төрөлтийн түвшин 2023–2025 онд эрс буурсан (ТНК 2024 онд 1.62 — Дайнаас хойших хамгийн бага түвшинд хүрсэн гэж үзэж буй). Үүнд орон сууц, амьжиргааны өртөг, ажил-амьдралын тэнцвэрт бус байдал зэрэг бүтцийн хүчин зүйл нөлөөлсөн.
- **СӨБ, ЕБ-ын салбарын хүний нөөц, хүртээмж:** Франц болон Европын хэмжээнд багш, асрагчийн хомсдол их.

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

Франц улсад хүүхэд асрах үйлчилгээний хүртээмж өндөр, өрх санхүүгийн болон хүүхэд асрах үйлчилгээний дэмжлэгийг нэг дороос авах боломж бүрдүүлсэн нь эмэгтэйчүүдийн ажиллах шийдвэр болон дараагийн хүүхэд төрүүлэх төлөвлөгөөнд эергээр нөлөөлж байна. Францад төрсний дараах эхийн амралт 16 долоо хоног байдаг бол эцгийн чөлөөг өргөжүүлж 28 хоног болгосон зохицуулалт хийсэн байна<sup>6</sup>. Ийм өөрчлөлт нь аавын оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд асаргааны ажлыг өрх дотор тэнцвэржүүлэх бодлогын зорилготой нийцэж байгаа юм.

**Герман** Kindergeld (сар бүрийн хүүхдийн мөнгө) болон Elterngeld (төрсний дараах орлогын орлуулалт) зэрэг хэрэгслүүдийг ашиглаж, гэр бүлийн орлогын бууралтыг

<sup>6</sup> <https://www.service-public.gouv.fr/particuliers/vosdroits/F3156?lang=en&ut>

зөөлрүүлдэг. Энэ нь өрхийн санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалж, хүүхэдтэй болох шийдвэрийг дэмжихэд чиглэсэн арга хэрэгсэл юм. Германы эцэг, эхийн тэтгэмж нь өмнөх орлогоос хамааран тооцогддог тогтолцоотой<sup>7</sup>. Гэхдээ орон сууцны бодлого (жишээ нь Baukindergeld зэрэг түр хугацааны хөтөлбөрүүд) нь төрөлтийн бодлогоос тусдаа, богино настай, мөн хүүхэд асаргааны хүний нөөцийн хомсдол зэрэг асуудал зарим бүсэд үргэлжилж байна. Энэ нь санхүүгийн дэмжлэгийг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан байдалтай хамт хэрэгжүүлэхгүй бол бодлогын нөлөө хязгаарлагдмал байдгийг харуулж байна.

### **Шигтгээ 6.2. Герман: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

#### **Сайн түршлага**

- **Kindergeld ба Elterngeld:** мөнгөн дэмжлэг ба орлогын орлуулалт нь өрхийн амьжиргааны тогтвортой байдалд зэрэг нөлөөтэй.
- Хүүхэд асаргааны эрх хуульчлагдсан нь ажил хөдөлмөр эрхлэлтийг бодитоор дэмжсэн.
- **ElterngeldPlus/Partnerschaftsbonus** нь аавын оролцоог нэмэгдүүлэхэд урамшуулал болсон.
- **Baukindergeld** зэрэг түр хөтөлбөр нь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, залуу өрхөд том дэмжлэг болсон.

#### **Сургамж**

- **Орон сууцны бодлого** төрөлтийн бодлогоос салангид, түр хугацааны урамшууллууд богино настай байна.
- **Хүүхэд асаргааны хүртээмж** зарим мужид хангалтгүй хэвээр (мэргэжлийн багшийн хомсдол).
- **Төрөлт нэмэгдэх нөхцөл хязгаарлагдмал** хэвээр – ТНК = 1.5 орчимд тогтсон ч орлогын түвшин, нийгмийн соёлын хүчин зүйлс томоохон хүчин зүйл хэвээр байна.

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

Германд Elterngeld-ийг ElterngeldPlus, Partnerschaftsbonus зэрэг хэлбэрээр уян хатан ашиглаж, хоёр эцэг эх зэрэгцэн ажил-асаргааны цагийг зохицуулах боломж олгож байна. Энэ төрлийн зохицуулалт нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг таслахгүй, “хоёр дахь хүүхэд”-ийн эрсдэлийг бууруулахад чиглэдэг арга хэрэгслийн нэг юм.

**Швед** улс бүх хүүхдэд суурь түвшний мөнгөн тэтгэмжийг универсал байдлаар олгохын зэрэгцээ олон хүүхэдтэй болон орлого багатай өрхөд нэмэлт, зорилтот дэмжлэг үзүүлэх хосолсон тогтолцоог нэвтрүүлж, нийгмийн тэгш байдлыг хангахад илүү үр дүнтэй ажиллаж байна.

### **Шигтгээ 6.3. Швед: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

#### **Сайн түршлага**

- Жендэрийн тэгш бодлого: (татварын систем, эцгийн заавал авах сарууд) Аавын оролцоог бодитоор нэмэгдүүлсэн.
- Бүх нийтийн асаргаа: Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг өндөр түвшинд хадгалсан.
- 480 өдрийн уян хатан чөлөө: Гэр бүл өөрийн нөхцөлдөө тохируулж ашиглах боломжтой.
- Орон сууцны татаас: Бага орлоготой өрхөд амьдралын баталгааг хангаж, нийгмийн тэгш байдлыг нэмэгдүүлсэн.
- Урт хугацааны тогтвортой бодлого: Төрийн дэмжлэгт иргэдийн итгэлийг бий болгосон.

#### **Сургамж**

- Универсал ба зорилтот хосолсон тэтгэмж хэрэгтэй (бүх хүүхдэд мөнгө, олон хүүхэдтэй, орлого багатайд нэмэлт).
- Цэцэрлэгийн хүртээмжийг хуульчилсан эрх болгох: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- Эцгийн квоттой чөлөө: Аавын оролцоог нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн карьерт дэмжлэг болно.
- Хувь хүний татварын тогтолцоо: Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг идэвхжүүлэх.
- Орон сууцны бодлогыг гэр бүл, хүүхэдтэй холбох: Бага орлоготой залуу өрхөд хүүхэдтэй болох шийдвэрийг хөнгөөчилнө.

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

<sup>7</sup> <https://familienportal.de/familienportal/meta/languages/family-benefits/parental-allowance-141952?utm>

Мөн бүх нийтийн хүртээмжтэй, төрийн хүүхэд асаргааны үйлчилгээ нь эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг тасалдуулахгүй байхад чухал нөлөө үзүүлж, хөдөлмөрийн зах зээлд оролцох түвшинг өндөр хэвээр хадгалах боломжийг бүрдүүлсэн.

Жендэрийн тэгш бодлогыг татварын тогтолцоо болон эцгийн заавал авах чөлөөний саруудтай уялдуулан хэрэгжүүлснээр аавуудын хүүхэд асрах үйл ажиллагаанд оролцоо бодитоор нэмэгдсэн байна. Тухайлбал, 480 өдрийн уян хатан эцэг, эхийн чөлөө нь гэр бүлүүд өөрсдийн амьдралын нөхцөл, хэрэгцээнд нийцүүлэн хүүхэд асрах хугацаагаа зохицуулах боломжийг олгосон. Мөн эцэг, эхийн чөлөөг зөвхөн ээжид бус, аавд ч оногдуулах нь чухал гэдгийг харуулсан.

Орон сууцны татаас, дэмжлэг нь бага орлоготой өрхийн амьдралын суурь баталгааг хангахын зэрэгцээ нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн бодлогын чухал хэрэгсэл болж байна. Урт хугацаанд тогтвортой хэрэгжсэн бодлого нь төрийн дэмжлэгт иргэдийн итгэлийг бий болгож, өрхүүдийн ирээдүйн төлөвлөлтөд эерэг нөлөө үзүүлсэн.

**Канад** улсын Canada Child Benefit (CCB) хөтөлбөр нь орлогын түвшинд суурилсан, татвар ногдуулдаггүй мөнгөн дэмжлэгийг бүх хүүхдэд хүргэх зорилготой хэрэгждэг. Үүний үр дүнд 2016–2020 оны хооронд хүүхдийн ядуурлын түвшин ойролцоогоор 10 хувиар буурсан нь энэхүү бодлогын бодит үр нөлөө гэж үзэж байна.

Канадын Квебек мужид хэрэгжүүлсэн хямд өртөгтэй хүүхэд асаргааны үйлчилгээ болох CPE болон уян хатан эцэг, эхийн даатгалын тогтолцоо QPIP нь эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох түвшинг Канадын бусад мужуудтай харьцуулахад илүү өндөр, ойролцоогоор 85 хувьд хүргэхэд нөлөөлсөн нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг огцом нэмэгдүүлсэн сайн жишээ байна.

#### **Шигтгээ 6.4. Канад: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

##### **Сайн туршлага**

- **ССВ:** Орлого-зорилтот, татваргүй, бүх хүүхдэд хүрдэг. Хүүхдийн ядуурлыг мэдэгдэхүйц бууруулсан (2016–2020 онд хүүхдийн ядуурлын түвшин 10% орчимд буурсан).
- **Quebec - ийн CPE ба QPIP:** эцэг/эхийн хөдөлмөр эрхлэлтийг огцом нэмэгдүүлсэн, эмэгтэйчүүдийн оролцоо Канадын бусад мужуудаас өндөр (85%).
- **\$10/өдөр цэцэрлэгийн зорилт:** Үйлчилгээний хүртээмжийг шууд нэмэгдүүлж байна.

##### **Сургамж**

- **Зөвхөн мөнгө бус, үйлчилгээтэй уялдуулах:** ССВ ба хямд цэцэрлэгийг зэрэг хэрэгжүүлснээр хамгийн үр дүнтэй.
- **Орон нутгийн онцлогийг тусгах:** Зарим мужийн жишээ шиг аймаг, бүс бүрийн хэрэгцээнд нийцсэн бодлого илүү үр дүнтэй.
- **Аавын оролцоог квотоор нэмэгдүүлэх:** QPIP-ийн туршлагаас харвал “Эцгийн тусгай сар” нь бодитой үр дүн гаргадаг.
- **Хүүхдийн ядуурлыг бууруулах гол хэрэгсэл:** Зорилтот мөнгөн тэтгэмж, татваргүй байдлыг улс орнууд нутагшуулах боломжтой.
- **Орон сууцны бодлогыг уялдуулах шаардлагатай:** Залуу гэр бүлд орон сууцны зээл, түрээсийн дэмжлэг төрөлтийг дэмжих хүчин зүйл болдог.

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

Канад улсад орлогын талаарх зорилтот мөнгөн дэмжлэгийг (ССВ) хямд өртөгтэй цэцэрлэгийн бодлоготой зэрэг хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй харагдаж байна. Тус

улсын засгийн газраас улс даяар дунджаар “өдөрт 10 ам.доллар”<sup>8</sup> хүүхэд асрах систем рүү шилжүүлэх зорилт тавьж, төлбөр бууруулах болон шинэ байр орон зайг нэмэх ажлыг мужуудтай хамтран хэрэгжүүлж байгаа нь үйлчилгээний хүртээмжийг бодлогоор дэмжих үйл ажиллагаа байна.

**Чех** улсын туршлагаас харахад хүүхдийн мөнгө, татварын бонусын тогтолцоо нь өрхийн орлогын дарамтыг тодорхой хэмжээнд хөнгөлдөг ч инфляцийн нөлөөгөөр бодит дэмжлэг сулардаг байна.

#### **Шигтгээ 6.5. Чех: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

##### **Сайн туршлага**

- *Parental Allowance*-ийн уян хатан тогтолцоо – Эцэг эх өөрсдийн хэрэгцээнд тохируулан авах боломжтой (2–3 жил).
- *Public Kindergarten*-ийн хүртээмж – 3–6 насны хамралт өндөр.
- *Татварын бонус* ба хүүхдийн мөнгө – Өрхийн орлого, *татварын ачааллыг* бууруулдаг.
- *Орон сууцны зээлд хүүхэд төрөхөд өр тэглэх механизм* – *Залуу өрхөд урамшуулал болдог.*

##### **Сургамж**

- *0–2 настай хүүхдийн асаргаа дутмаг: Эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг хязгаарладаг.*
- *Эцгийн оролцоо сул: Урт хугацааны чөлөөний ихэнхийг эмэгтэйчүүд авч, карьерт сөрөг нөлөөтэй.*
- *Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ харьцангуй бага: Инфляцийн нөлөөгөөр бодит дэмжлэг буурч байна.*
- *Төрөлтийн түвшин 1.6 орчимд тогтож, өсөлтөд нөлөө багатай.*

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

Тус улсын хувьд хүүхэд асрах тэтгэмж, татварын бонус, мөнгөн дэмжлэг зэргийг хэрэглэж, өрхийн татварын ачааллыг бууруулдаг ч 0–2 насны хүүхдийн асаргаа дутмаг, эцгийн оролцоо сул хэвээр байснаас эмэгтэйчүүдийн карьер тасалдах эрсдэл үүсдэг гэдгийг мөн онцолж байна. Энэ нь мөнгөний бодлого зөв байлаа ч асаргааны үйлчилгээний хэрэгцээ тодорхой түвшинд шийдэгдэхгүй бол хоёр дахь хүүхэд, дараагийн төрөлтөд тогтвортой түлхэц өгөхөд хэцүү гэдгийг илэрхийлж буй хэрэг юм.

#### **Зүүн Азийн орнуудын туршлага, сургамж**

Азийн орнуудаас Сингапур, Өмнөд Солонгос нь өндөр хэмжээний мөнгөн урамшуулал, татварын хөнгөлөлт олгож буй ч төрөлтийн түвшин тогтвортой өсөхгүй хэвээр байна. Энэ нь санхүүгийн дэмжлэг дангаараа хангалтгүй бөгөөд амьжиргааны өртөг, орон сууцны хүртээмж, ажлын соёл зэрэг бүтцийн хүчин зүйлс илүү хүчтэй нөлөөлдгийг харуулж байна.

**Сингапур** санхүүгийн олон түвшний хөшүүрэг (Baby Bonus, татварын хөнгөлөлт, орон сууцны бодлогын дэмжлэг гэх мэт)-ийг зэрэг ашигладаг. Сингапурын Baby Bonus Scheme<sup>9</sup> нь Cash Gift болон Child Development Account (CDA) зэрэг бүрэлдэхүүнтэйгээр хүүхэд өсгөх зардлыг даван туулахад чиглэдэг. Хүүхдийн тоо нэмэгдэх тусам шатлан өсдөг татварын хөнгөлөлт нь олон хүүхэдтэй болохыг санхүүгийн хувьд илүү ашигтай болгож, өрхүүдийг дараагийн хүүхэд төрүүлэхэд урамшуулдаг. Гэвч орлого өндөртэй, татвар төлөлт өндөртэй өрхөд татварын хөнгөлөлтийн ашиг илүү тусч, тэгш бус үр өгөөж өгч байгааг тус улсын туршлагаас харж болно. Энэ нь санхүүгийн бодлогыг зорилтот бүлэгт хүргэх загвар (универсал ба зорилтот хослол) чухал гэдгийг давхар нотолж байна.

<sup>8</sup> <https://www.canada.ca/en/employment-social-development/news/2025/03/toward-10-a-day-an-early-learning-and-child-care-background0.html?utm>

<sup>9</sup> <https://www.madeforfamilies.gov.sg/support-measures/raising-your-child/financial-support/baby-bonus-scheme?utm>

Орон сууцны хүртээмж нь төрөлтийн шийдвэрт нөлөөлөх чухал хүчин зүйл гэдгийг Сингапур улсын туршлагаас харж болно. Тус улсад залуу гэр бүлд чиглэсэн төрийн орон сууцны бодлого, хүүхдийн тоотой уялдсан татварын болон мөнгөн урамшуулал нь санхүүгийн дарамтыг бууруулахад чиглэсэн цогц шийдэл болж байна.

#### **Шигтгээ 6.6. Сингапур: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

##### **Сайн туршлага**

- Санхүүгийн болон татварын хөшүүргийг олон түвшинд хослуулсан.
- Эмэгтэйчүүдийн ажил, гэр бүлийн зохицлыг системтэйгээр бодлогоор дэмждэг.
- Нийгэмд гэр бүл, хүүхдийн үнэ цэнийг тогтвортой сурталчилдаг.
- Хүүхдийн тоогоор шатлан өсдөг татварын хөнгөлөлт нь олон хүүхэд төрүүлэхийг урамшуулдаг.
- Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмждэг байдал ажилтай эхчүүдэд илүү их хөнгөлөлт олгодог.
- Гэр бүлийн гишүүдийн оролцоог (өвөө, эмээ хүртэл) бодлогод хамруулсан нь онцлог.

##### **Сургамж**

- Бодлогоос үл хамааран төрөлтийн түвшин  $TNK=1.0$  орчим хэвээр байгаа.
- Залуучуудын гэрлэлтийн хандлага өөрчлөгдөж, карьер, санхүүгийн тогтвортой байдалд илүү анхаарч байгаа нь төрийн дэмжлэгийг бүрэн үр дүнтэй болгохгүй байна.
- Орлого багатай өрх татвар төлдөггүй тул хөнгөлөлтөөс хүртэх ашиг нь хязгаарлагдмал.
- Илүү өндөр орлоготой, татвар төлөлт өндөртэй өрхөд илүү их урамшуулал өгдөг бүтэцтэй.

Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт

Эмэгтэйчүүдийн ажил, гэр бүлийн амьдралыг зохицуулах боломжийг бодлогын түвшинд системтэйгээр дэмжсэнээр тэд хөдөлмөр эрхлэлтийг хадгалах, хүүхэдтэй болох шийдвэрээ уялдуулах нөхцөл бүрдсэн байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь ажилтай эхчүүдэд илүү их татварын болон санхүүгийн хөнгөлөлт олгох байдлаар хэрэгжиж, ажил ба эхийн үүргийг хослуулах боломжийг нэмэгдүүлсэн. Гэр бүлийн бодлогод зөвхөн эцэг, эхийг бус, өвөө, эмээ зэрэг өрхийн бусад гишүүдийн оролцоог хамруулсан нь хүүхэд асаргааг өрхийн түвшинд хуваалцах онцлог шийдэл болж байна.

Гэр бүл, хүүхдийн нийгэмд эзлэх үнэ цэнийг тогтвортой сурталчлах бодлого нь залуучуудын хандлагад нөлөөлж, гэр бүл төлөвлөлтийг дэмжих эерэг орчныг бүрдүүлсэн.

Гэвч сүүлийн жилүүдэд залуучуудын гэрлэх хандлага өөрчлөгдөж, карьер болон санхүүгийн тогтвортой байдалд илүү анхаарах болсон нь төрөөс олгож буй дэмжлэгийг бүрэн үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлж байна. Мөн орлого багатай олон өрх татвар төлдөггүй учраас татварын хөнгөлөлтөөс бодитоор хүртэх ашиг нь хязгаарлагдмал хэвээр байна.

**Өмнөд Солонгос** төрөлт бүрт урамшуулал, хүүхдийн мөнгө, татварын хөнгөлөлт зэрэг өндөр санхүүжилттэй бодлого явуулж ирсэн ч залуучуудын гэрлэх, хүүхэдтэй болох хандлага буурсан, орон сууцны үнэ, боловсролын дарамт, карьерын өрсөлдөөн зэрэг бүтцийн хүчин зүйлс бодлогын нөлөөг бууруулж байна. Хүүхдийн тэтгэмж (хүүхэд 8 хүртэл нас)-ийг сар бүр 100,000 воноор олгох зохицуулалт хуульд<sup>10</sup> туссан. Гэхдээ бодлого мөнгөөр бус, ажлын соёл, жендерийн тэгш бус байдал, үйлчилгээний хүртээмж зэрэгтэй хамт өөрчлөгдөхгүй бол үр дүн сул байдгийг тус улсын туршлага харуулж байна.

<sup>10</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=60064&key=38&type=part&utm](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=60064&key=38&type=part&utm)

Өмнөд Солонгосын хувьд эцэг, эхийн чөлөө авах хууль эрх зүйн боломж байгаа ч бодит хэрэгжилт нь ажил олгогчийн соёл, карьерын дарамтаас болж хангалтгүй байна. Энэ нь хууль байгаа ч амьдрал дээр хэрэгжих хоёрын хооронд том орон зай байдгийг, улмаар төрөлтийг дэмжих бодлого институцийн шинэчлэлээс гадна байгууллагын соёл, хөдөлмөрийн зах зээлийн практикт нөлөөлөх ёстойг харуулж байна.

**Шигтгээ 6.7. Өмнөд Солонгос: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

**Сайн туршлага**

**Цогц бодлого хэрэгжүүлсэн:**

- Санхүүгийн дэмжлэг (нярай, хүүхдийн мөнгө, татварын хөнгөлөлт)
- Хүүхэд асаргаа, боловсролын хүртээмж (үнэгүй/хөнгөлөлттэй цэцэрлэг, хүүхэд харагчийн үйлчилгээ)
- Ажил-амьдралын тэнцвэр (эцэг эхийн чөлөө, уян хатан ажлын цаг)
- Орон сууцны бодлого, орон нутгийн нэмэлт урамшуулал

**Төв болон орон нутгийн бодлогын уялдаа:**

- Үндэсний хэмжээний тогтолцоог орон нутгийн захиргаа өөрийн онцлогт тохируулан өргөтгөдөг.
- Жишээ нь хүн ам цөөрч буй хөдөө орон нутаг олон хүүхэдтэй өрхөд илүү өндөр урамшуулал өгдөг.

**Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх:**

- Аавын чөлөө, хамтарсан parental leave зэрэг бодлогоор зөвхөн эмэгтэйчүүд бус, эрэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлсэн.

**Сургамж**

**Зөвхөн мөнгөөр төрөлтийг нэмэгдүүлэх боломжгүй**

- Сар бүрийн ₩100,000 хүүхдийн мөнгө, төрөлтийн өндөр урамшуулал, татварын хөнгөлөлт ч гэсэн залуусын шийдвэрт томоохон өөрчлөлт оруулж чадаагүй.

**Соёл, нийгмийн үнэт зүйлсийн нөлөө**

- Залуучуудын дунд гэрлэх, хүүхэдтэй болох сонирхол эрс буурсан.
- Хэт их боловсролын дарамт, байрны үнэ, карьерын өрсөлдөөн нь хүүхэдтэй болох шийдвэрийг сааруулдаг.

**Хүйсийн тэгш бус байдал**

- Эмэгтэйчүүдийн ажил, гэр бүлийн ачаалал их хэвээр.
- Эцэг эхийн чөлөө авах хууль эрх зүйн боломж байгаа ч бодит хэрэгжилт нь ажил олгогчийн соёл, карьерын дарамтаас болж хангалтгүй.

**Бодлогын “үр нөлөөний хоцрогдол”**

- Хүүхдийн асаргаа, орон сууцны бодлого сайжирсан ч үр дүн богино хугацаанд харагдахгүй, харин хүн амын насжилт түргэн явагдсан.

Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт

Хүүхдийн асаргаа болон орон сууцны бодлого тодорхой хэмжээнд сайжирсан ч бодлогын үр дүн богино хугацаанд шууд мэдрэгдэхгүй байна.

**Япон** улсад 2019 оноос СӨБ-ыг үнэ төлбөргүй болгосон сайн туршлага байна. Японд 2019 оноос 3–5 насны хүүхдэд үнэ төлбөргүй эрт үеийн боловсрол, асаргааны эрх зүйн зохицуулалт (тодорхой санхүүгийн хязгаартайгаар) хэрэгжсэн<sup>11</sup>.

**Шигтгээ 6.8. Япон: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

**Сайн туршлага**

- CFA байгуулснаар бодлогын уялдааг сайжруулсан.
- СӨБ 2019 оноос үнэ төлбөргүй болсон нь гэр бүлийн санхүүгийн дарамтыг бууруулсан.
- Уян хатан чөлөө, мөнгөн дэмжлэг өрхийн шийдвэрт эерэг нөлөө үзүүлсэн.
- Аавын тусгай чөлөө (Ikiten кампанит ажил) нь олон нийтийн хандлагад өөрчлөлт оруулах эхлэл болсон.

**Сургамж**

- Урт ажлын цаг, ажиллах соёл нь төрөлтийг дэмжих бодлогын нөлөөг бууруулдаг.
- Эцгийн чөлөө ашиглалт бага. Тусгайлсан бодлого хэрэгжсэн ч соёлын хүчин зүйл нөлөөлж байна.
- Хүүхэд асаргаа хүртээмж хангалтгүй (урт хүлээлгийн жагсаалт).
- Төрөлтийн түвшин тогтвортой өсөхгүй байна. ТНК 1.3 орчимд хэлбэлзэж байгаа.

Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт

<sup>11</sup><https://www.oecd.org/content/dam/oecd/en/about/programmes/edu/eccec/migrate/starting-strong-vi/StartingStrongVI-CountryNote-Japan.pdf>

Гэхдээ урт хүлээлгийн жагсаалт, хүртээмжийн асуудал хэвээр байгааг судалгаа онцолсон. Үйлчилгээний бодлого зөв байсан ч хүний нөөц, хүчин чадал дагаж өсөхгүй бол үр нөлөө саардаг гэдгийг тус улсын туршлага бас сануулж байна.

Японы жишээнээс харахад, хууль эрх зүйн зохицуулалт байсан ч урт ажлын цаг, ажил олгогчийн соёлын онцлог бодлогын бодит хэрэгжилтийг хязгаарлаж, төрөлтийн бодлогын үр нөлөөг сулруулж байна.

### *Төв Азийн орнуудын туршлага, сургамж*

Төв Азийн орнууд болох Казахстан, Тажикстан, Узбекистан зэрэгт хүүхдийн тоонд суурилсан шаталсан тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, орон сууцны хөнгөлөлттэй зээлийг ашиглаж байгаа нь төрөлтийн шийдвэрт тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлж байгаа ч төсвийн тогтвортой байдал сул, бодлого тасалддаг нь урт хугацааны итгэлцлийг бууруулах эрсдэл дагуулж байна. Тухайлбал, Казахстан олон хүүхэдтэй өрхөд хүүхдийн тооноос хамаарсан тэтгэмжийн систем хэрэгжүүлдэг. Тус улс олон хүүхэдтэй өрхийн тэтгэмжийг 2024 оноос хүүхдийн тооноос хамааран ялгаатай хэмжээгээр олгож эхэлсэн байна<sup>12</sup>. Гэхдээ эмэгтэйчүүдийн ажил-амьдралын тэнцвэр сул учраас санхүүгийн дэмжлэг урт хугацааны эерэг үр дүн үзүүлж чадахгүй байна.

### **Хүснэгт 6.1: Төрөлтийг дэмжих бодлогын багц, сонгосон Төвийн Азийн орнуудаар**

<b>Улс</b>	<b>Бодлого, арга хэмжээ</b>	<b>Сайн туршлага</b>	<b>Сургамж</b>
Казахстан	<ul style="list-style-type: none"> <li>“Многодетная семья” буюу олон хүүхэдтэй өрхөд зориулсан мөнгөн тэтгэмжийн систем (хүүхдийн тооноос хамаарсан шатлалтай)</li> <li>Төрөх үед нэг удаагийн тэтгэмж, хүүхдийн асаргааны сар бүрийн тэтгэмж</li> <li>Орон сууцны хөнгөлөлттэй зээл, ипотекийн хөтөлбөр – олон хүүхэдтэй гэр бүлийг зорилтот бүлэгт оруулдаг.</li> <li>Эцэг эхийн чөлөө, ажлын байрны хамгаалалт сайжирч байгаа ч эмэгтэйчүүдийн ачаалал давамгайл.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн хамгааллын тогтолцоог төрөлттэй уялдуулж шатлалтай тэтгэмж олгодог.</li> <li>Хүүхэд асаргааны дэмжлэгийг орон нутгийн түвшинд хүртээмжтэй болгох оролдлого</li> </ul>	Санхүүгийн дэмжлэг чухал ч эмэгтэйчүүдийн “Ажил-Амьдрал”-ын тэнцвэрийг хангах бодлого сул байгаагаас төрөлтөд урт хугацааны эерэг үр дүн бага.
Туркменистан	<ul style="list-style-type: none"> <li>Нэг удаагийн мөнгөн тэтгэмж төрөх бүрт олгодог (төрөх эмнэлэгт төрсөн тохиолдолд илүү урамшуулдаг)</li> <li>Үнэгүй эсвэл хөнгөлөлттэй үйлчилгээ – хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, спортын сургалт</li> <li>Олон хүүхэдтэй эхчүүдэд “Эхийн баатар” цол, урамшуулал олгодог уламжлал хадгалагдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн боловсрол, спорт, эрүүл мэндийн үйлчилгээ үнэ төлбөргүй эсвэл маш бага өртөгтэй.</li> <li>Улсын төсөвт суурилсан нийт хүн амд чиглэсэн бодлого</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээний чанар ба хүртээмжийг илүү сайжруулахгүй бол зөвхөн урамшуулал нь төрөлтөд тогтвортой нөлөө үзүүлэхгүй.</li> <li>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн бодлого бараг байхгүй.</li> </ul>
Тажикстан	<ul style="list-style-type: none"> <li>“Балалы Үй-Бүлө” хөтөлбөр – хүүхдийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөө орон нутгийн хүн амд чиглэсэн бодлого нь шинэ гэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн хөтөлбөрүүд төсвийн тогтворгүй байдлаас</li> </ul>

<sup>12</sup> <https://www.nur.kz/nurfin/pension/2202197-kakie-posobiya-poluchali-mnogodetnye-semi-v-kazhstane-v-2024-godu/?utm>

Улс	Бодлого, арга хэмжээ	Сайн туршлага	Сургамж
	<p>тооноос хамаарсан сар бүрийн тэтгэмж</p> <ul style="list-style-type: none"> <li>Эхийн тэтгэмж: анхны хүүхдээс эхлэн төрөх бүрт нэг удаагийн мөнгөн тэтгэмж</li> <li>Хөдөө орон нутагт залуу гэр бүлд зориулсан газрын дэмжлэг болон бага хүүтэй зээл</li> </ul>	<p>бүлд орон сууцтай болоход тусалдаг.</p> <ul style="list-style-type: none"> <li>СӨБ, хүүхэд асаргааны байгууллагыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй өргөтгөж байгаа.</li> </ul>	<p>шалтгаалж тасалдалтай хэрэгждэг нь итгэлцэлд сөргөөр нөлөөлдөг.</p> <ul style="list-style-type: none"> <li>Алслагдсан бүсийн эмнэлгийн үйлчилгээ сул, төрөлтийг хязгаарлагч хүчин зүйл хэвээр байгаа</li> </ul>
Узбекистан	<ul style="list-style-type: none"> <li>“Меһрибон Она” (Энэрэнгүй эх) зэрэг хөтөлбөрөөр олон хүүхэдтэй эхчүүдэд онцгой урамшуулал олгодог.</li> <li>Хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж, СӨБ-ын дэмжлэг.</li> <li>Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг өргөжүүлэхэд онцгой анхаарч байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>СӨБ-ын хүртээмжийг богино хугацаанд хурдтай өсгөсөн нь төрөлтийн шийдвэрт эергээр нөлөөлсөн.</li> <li>Нийгмийн халамжийг дижиталжуулж, зорилтот бүлэгт шууд хүргэх тогтолцоог эхлүүлсэн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад шилжилт хөдөлгөөн ихтэйгээс залуу гэр бүлийн тогтвортой байдалд сорилт болж байна.</li> <li>Хөдөлмөр эрхлэлт, орон сууцны хүртээмжийг зэрэг сайжруулах шаардлагатай.</li> </ul>
<p>Эх сурвалж: <a href="https://www.gov.kz/situations/419/1019?lang=en">https://www.gov.kz/situations/419/1019?lang=en</a>; <a href="https://egov.kz/cms/en/articles/family_support/posobiya-i-lgoty?utm;">https://egov.kz/cms/en/articles/family_support/posobiya-i-lgoty?utm;</a> <a href="https://www.ilo.org/media/331811/download?utm;">https://www.ilo.org/media/331811/download?utm;</a> <a href="https://www.unicef.org/turkmenistan/social-and-child-protection?utm;">https://www.unicef.org/turkmenistan/social-and-child-protection?utm;</a> <a href="https://bearr.org/regional-news/turkmenistan-how-family-policies-in-turkmenistan-reinforce-womens-caregiving-burden/?utm;">https://bearr.org/regional-news/turkmenistan-how-family-policies-in-turkmenistan-reinforce-womens-caregiving-burden/?utm;</a> <a href="https://documents1.worldbank.org/curated/en/099082024024536740/pdf/P179024-31e25a0c-2fba-4405-b941-2c6e0eae06.pdf?utm;">https://documents1.worldbank.org/curated/en/099082024024536740/pdf/P179024-31e25a0c-2fba-4405-b941-2c6e0eae06.pdf?utm;</a> <a href="https://www.unicef.org/uzbekistan/en/media/5011/file/Reforming%20child%20benefits%20system.pdf?utm;">https://www.unicef.org/uzbekistan/en/media/5011/file/Reforming%20child%20benefits%20system.pdf?utm;</a> <a href="https://unece.org/sites/default/files/2024-10/2.03.04_%20Ergashev_Uzbekistan.pdf?utm;">https://unece.org/sites/default/files/2024-10/2.03.04_%20Ergashev_Uzbekistan.pdf?utm;</a> <a href="https://business.com.tm/post/7895/turkmenistan-lowers-retirement-age-for-mothers-with-eight-children?utm;">https://business.com.tm/post/7895/turkmenistan-lowers-retirement-age-for-mothers-with-eight-children?utm;</a> <a href="https://turkmenportal.com/en/news/42956-new-laws-in-support-of-large-families-come-into-force-in-turkmenistan?utm">https://turkmenportal.com/en/news/42956-new-laws-in-support-of-large-families-come-into-force-in-turkmenistan?utm</a></p>			

Тажикстан залуу гэр бүлд газар, бага хүүтэй зээл зэрэг хөдөө орон нутагт чиглэсэн орон сууцны дэмжлэг үзүүлж буй нь суурьшлын бодлого нь төрөлттэй уялдуулсныг харуулж буй ч төсвийн тогтворгүй байдал, алслагдсан бүсийн эрүүл мэндийн үйлчилгээ сул зэрэг нь төрөлтийг хязгаарлагч хүчин зүйл хэвээр байсаар байна.

Узбекистан СӨБ-ын хүртээмжийг богино хугацаанд хурдтай өсгөж, төрөлтийн шийдвэрт эергээр нөлөөлсөн сайн туршлага байна. Тажикистанд СӨБ, хүүхэд асаргааны байгууллагыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй өргөтгөх оролдлого хийгдэж байгаа ч төсвийн тогтворгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээний сул талууд бодит үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь үйлчилгээний шинэчлэл урт хугацаанд тогтвортой санхүүжилт, чанарын баталгааг шаарддагийг илэрхийлж байна.

Төв Азийн орнуудын жишээнээс харахад, эцэг, эхийн чөлөө, ажлын байрны хамгаалалт албан ёсоор хэрэгжиж байгаа ч эмэгтэйчүүдийн ачаалал давамгайл хэвээр байгаа нь төрөлтийн түвшинд урт хугацааны эерэг үр дүн гарахгүй л байна.

## 6.2 Монгол Улсын төрөлтийг дэмжих бодлого, арга хэмжээ

Монгол Улсад 1990 оноос хойш хэрэгжүүлсэн төрөлтийг дэмжих бодлогын арга хэмжээг үе шаттайгаар тайлбарлаж, гарсан сайн туршлага болон бодлогын сургамжийг хүн ам зүйн өнцгөөс дэлгэрүүлэн дүгнэсэн болно.

- **1990–2000 он: Шилжилтийн үе – шууд дэмжлэг сул:** 1990-ээд оны эхэн үе нь Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн, нийгэм-эдийн засгийн гүнзгий өөрчлөлт явагдсан онцгой үе байв. Энэ хугацаанд өмнөх социалист системийн өргөн

халамжийн механизм нуран унаж, төрөөс гэр бүл, эх, хүүхдэд чиглэсэн дэмжлэг огцом хумигдсан. Үүний улмаас өрхийн эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж, гэр бүлүүд хүүхэд төрүүлэх шийдвэрээ хойшлуулах, хязгаарлах хандлага давамгайлсан. Тухайн үед төрөлтийг дэмжих тодорхой пронаталист бодлого, зорилтот арга хэмжээ байгаагүй бөгөөд зөвхөн ерөнхий халамжийн үлдэгдэл хэлбэрүүд үйлчилж байсан нь 1990-ээд онд төрөлтийн түвшин огцом буурахад нөлөөлсөн.

- **2000–2010 он: Халамжийн бодлогоор дамжсан дэмжлэг:** Монгол Улс 2000-аад оноос нийгмийн хамгааллын тогтолцоог аажмаар сэргээж, гэр бүл, хүүхдэд чиглэсэн бодлогын анхны бодит дэмжлэгүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэ үеэс хүүхдийн мөнгийг тогтмол олгох, эхийн амаржсаны тэтгэмжийг сайжруулах, жирэмсний хяналт болон эх барих тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогууд эрчимжсэн. Эдгээр арга хэмжээ нь өрхийн санхүүгийн дарамтыг тодорхой хэмжээнд бууруулж, ялангуяа хоёр болон түүнээс дээш хүүхэдтэй болох шийдвэрт эерэг дохио өгсөн. Үүний үр дүнд 2005–2010 оны хооронд төрөлтийн түвшин дахин өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн.
- **2010 оноос хойш: Нийгмийн халамжид тулгуурласан пронаталист арга хэмжээ:** Монгол Улсын төрөлтийг дэмжих бодлого нь 2010 оноос хойш нийгмийн халамжид тулгуурласан илүү тодорхой шинжтэй болсон. Хүүхдийн мөнгийг орлогоос үл хамааран бүх хүүхдэд олгодог универсал хэлбэрт шилжүүлсэн нь бодлогын хамгийн том өөрчлөлт байв. Үүнээс гадна эхийн амаржсаны чөлөө, тэтгэмжийг хадгалж, эрүүл мэндийн даатгалаар жирэмслэлт, төрөлтийн тусламжийг бүрэн санхүүжүүлж ирсэн. Олон хүүхэдтэй эхчүүдийг нийгмийн хувьд үнэлэх зорилгоор “Алдарт эх” одон, тэтгэвэрт гарах хөнгөлөлт зэрэг соёлын болон бэлгэдлийн шинжтэй урамшууллуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн нь Монголын уламжлалт гэр бүлийн үнэт зүйлтэй нийцсэн бодлогын онцлог болсон.

#### **Шигтгээ 6.9. Монгол: Төрөлтийг дэмжих бодлогын туршлага, сургамж**

##### **Сайн туршлага**

###### **Универсал хүүхдийн мөнгө**

- Орлогоос үл хамааран бүх хүүхдэд олгодог
- Хүүхдийн ядуурлыг бууруулж, төрөлтөд эерэг дохио өгсөн
- 2000–2012 онд ТНК өсөхөд нөлөөлсөн

###### **Эхийн эрүүл мэндийн үйлчилгээ**

- Жирэмсний хяналт, амаржих үйлчилгээний хүртээмж өндөр
- Хот–хөдөөгийн ялгаа харьцангуй багассан

###### **Олон хүүхэдтэй эхчүүдийг нийгмийн хувьд үнэлэх**

- “Алдарт эх” одон → соёлын болон бэлгэдлийн урамшуулал
- Монголын онцлог, уламжлалт гэр бүлийн үнэт зүйлтэй нийцдэг

###### **Хот, хөдөөгийн ялгаатай хүн ам зүйн байдал**

- Хөдөөд төрөлт харьцангуй өндөр хэвээр
- Аймаг, сумын түвшинд бодлого турших боломжтой

##### **Сургамж**

###### **Мөнгө дангаараа хангалтгүй**

- Хүүхдийн мөнгө тараасан ч 2015 оноос хойш төрөлт буурч эхэлсэн
- Хотжилт, орон сууц, ажил–амьдралын тэнцвэрт бус байдал гол саад

###### **Ажил–амьдралын тэнцвэр сул**

- Аавын оролцоо бодлогоор дэмжигдээгүй
- Уян хатан ажил, эцэг эхийн хамтарсан чөлөө сул

###### **Хүүхэд асаргааны үйлчилгээ хомс**

- Ясли, цэцэрлэгийн хүртээмж, чанар хангалтгүй
- Хотын залуу гэр бүл 2, 3 дахь хүүхэдтэй болох шийдвэрийг хойшлуулдаг

###### **Бодлого “халамж төвтэй”, “амьдралын мөчлөг төвтэй” биш**

- Төрөлт → асаргаа → боловсрол → орон сууц → хөдөлмөр гэсэн нэгдсэн “Lifecycle” бодлого дутмаг

*Эх сурвалж: Судлаачийн өөрийн дүгнэлт*

Монгол Улсын төрөлтийг дэмжих бодлогын хүрээнд хэд хэдэн онцлог сайн туршлага байна. *Нэгдүгээрт*, универсал хүүхдийн мөнгө нь орлогын түвшнээс үл хамааран бүх хүүхдэд хүрдэг тул хүүхдийн ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж, төрийн зүгээс “хүүхэд үнэ цэнэтэй” гэсэн тодорхой дохиог өгсөн.

*Хоёрдугаарт*, эхийн эрүүл мэндийн үйлчилгээний хамралт харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж, жирэмсний хяналт, амаржих тусламж хот, хөдөөгийн ялгааг харьцангуй багасгаж чадсан.

*Гуравдугаарт*, олон хүүхэдтэй эхчүүдийг нийгмийн болон соёлын хувьд үнэлэх “Алдарт эх” одон нь мөнгөн бус, бэлгэдлийн урамшууллын үр нөлөөг харуулсан Монголын онцлог туршлага юм. *Дөрөвдүгээрт*, хот, хөдөөгийн төрөлтийн ялгаатай байдал нь бүс нутгийн түвшинд бодлого турших, нутагшуулах боломж байсаар байгааг харуулж байна.

Монгол Улсын туршлагаас харахад, мөнгөн тэтгэмж нэмэртэй боловч дангаараа төрөлтийг урт хугацаанд тогтвортой нэмэгдүүлэхэд хангалтгүй болох нь тодорхой болсон. Хүүхдийн мөнгө олгосоор байсан ч 2015 оноос хойш төрөлтийн түвшин дахин буурч эхэлсэн нь хотжилт, орон сууцны хүртээмж, амьдралын өртөг, ажил–амьдралын тэнцвэргүй байдал зэрэг бүтцийн хүчин зүйлсийн нөлөө давамгайл байгааг илтгэнэ. Мөн аавын оролцоог дэмжих бодлого сул, уян хатан ажил, эцэг эхийн хамтарсан чөлөө хангалтгүй байгаа нь эмэгтэйчүүдэд хүүхэд төрүүлэхтэй холбоотой ачааллыг дангаар үүрүүлэх нөхцөл үүсгэж байна. Түүнчлэн ясли, цэцэрлэгийн хүртээмж, чанар хот суурин газарт хангалтгүй хэвээр байгаа нь залуу гэр бүлүүд хоёр дахь, гурав дахь хүүхэдтэй болох шийдвэрээ хойшлуулахад хүргэж байна. Эцэст нь, Монгол Улсын төрөлтийн бодлого нь ихэвчлэн халамж төвтэй хэвээр байгаа бөгөөд төрөлт–асаргаа–боловсрол–орон сууц–хөдөлмөрийг уялдуулсан амьдралын мөчлөгт суурилсан цогц бодлого цаашид зайлшгүй шаардлагатай байна.

Эцэст нь дүгнэхэд, улс орнуудын төрөлтийг дэмжих бодлогын туршлагаас харахад мөнгөн тэтгэмж, татварын хөнгөлөлт дангаараа хангалтгүй бөгөөд хүүхэд асаргааны үйлчилгээ, орон сууц, ажил–гэр бүлийн тэнцвэр, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдрах орчнийг хамарсан цогц бодлогын багц зайлшгүй шаардлагатай байна. Ялангуяа, 0–3 насны хүүхэд асаргааны хүртээмж, уян хатан эцэг, эхийн чөлөө, аавын оролцоог бодитоор дэмжсэн зохицуулалт нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг хадгалж, хоёр дахь болон дараагийн хүүхэдтэй болох шийдвэрт эерэг нөлөө үзүүлдэг нь тодорхой байна. Мөн универсал болон зорилтот дэмжлэгийг хослуулсан санхүүгийн бодлого нь хүүхдийн ядуурлыг бууруулахын зэрэгцээ нийгмийн тэгш байдлыг хангахад илүү үр дүнтэй байгааг улс орнуудын жишээ харуулж байна. Харин бодлогын тогтворгүй байдал, үйлчилгээний хүний нөөцийн хомсдол, ажлын соёлын хатуу байдал нь бодлогын үр нөлөөг сулруулах гол эрсдэл хэвээр байна. Иймээс төрөлтийг дэмжих бодлого нь богино хугацааны урамшуулал бус, амьдралын мөчлөгт суурилсан (Бодлогын бүтцийн талаарх төслийг Хавсралт В дэх Хүснэгт В2-оос харна уу), урт хугацаанд тогтвортой хэрэгжих цогц хандлагад тулгуурлах шаардлагатай юм.

## БҮЛЭГ 7: ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хүн амын төрөлтийн шинжилгээ, бодлогын судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, цаашид баримтлах бодлогын гол чиглэл, зөвлөмжийг хүн ам зүйн онол, эмпирик шинжилгээнд тулгуурлан дэлгэрүүлэн танилцуулж байна.

### 7.1 Дүгнэлт

- Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад, төрөлтийн бууралт нь аливаа улс оронд үзэгдэх хүн ам зүйн зайлшгүй зүй тогтол гэдэг нь харагдаж байна. Мөн маш бага төрөлтийн түвшинд ( $ТНК < 1.5$ ) орсон орнууд төрөлтийг дэмжих төрөл бүрийн арга хэмжээ авч, бодлогын зардал өссөн ч үр дүн хязгаарлагдмал байгааг тэдний туршлага сануулж байна. Ялангуяа, Зүүн Азийн орнуудын жишээ нь төрөлт хэт буурсны дараа бодлогоор “эргүүлэн өсгөх” боломж хязгаарлагддаг гэдгийг нотолж байна. Энэ нь төрөлтийн бууралтыг бүрэн зогсоох бус, харин хэт доод түвшинд хүрэхээс урьдчилан сэргийлэх нь бодлогын бодит зорилт байх ёстойг хэлж байна.
- Монгол Улсад төрөлтийн түвшин түүхийн явцад бодлогын өөрчлөлт, эдийн засгийн тогтворгүй байдал, нийгмийн шилжилттэй нягт уялдан огцом хэлбэлзэж ирсэн. Тухайлбал, 1990-ээд оны огцом уналт, 2006–2015 оны өсөлт, түүнээс хойших тогтвортой бууралт нь төрөлт бодлогын урамшуулалд “мэдрэмжтэй” боловч урт хугацаанд тогтвортой бус байгааг харуулж байна. Монгол Улс одоогийн “дунд-бага шилжилтийн үе шат”-нд бодлогын оролцоогоо зөв чиглүүлж чадвал “маш бага төрөлтийн түвшинд”-д бүрэн шилжин орохоос урьдчилан сэргийлэх боломжтой.
- Төрөлтийн шинжилгээний үр дүнгээс харахад, төрөлтийг бууруулж буй гол хүчин зүйл нь гэрлэлт, амьдралын мөчлөгт үе шатуудад тохиолдож буй эрсдэл, саад бэрхшээлүүд байна. Бонгаарцын загвараар жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ, гэрлэлтийн түвшин, түр үргүйдэл, үр хөндөлт бүгд нөлөөлж байгаа ч гэрлэлт хойшлолт хамгийн тогтвортой, урт хугацааны нөлөө үзүүлж байна (гэрлэхгүй байдал 2003–2023 онд төрөлтийг 29.9-с 37.3%-аар бууруулсан). Энэ нь төрөлтөд нөлөөлөх суурь нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс нь шууд бус байдлаар, голчлон гэрлэлт ба нөхөн үржихүйн зан үйлийг өөрчилж байгааг харуулж байна.
- Төрөлтийн темпо-квантум шинжилгээний үр дүнгээс харахад, Монгол Улсын төрөлтийн бууралт нь “түр зуурын” биш, зан төлөвийн (quantum) өөрчлөлт давамгайлж байна. Темпо (төрөх насыг хойшлуулах) нөлөө 2005–2014 онд төрөлтийг түр өсгөсөн боловч 2019 оноос хойш темпо-зассан  $ТНК^*$  ч буурч эхэлсэн нь эмэгтэйчүүдийн насан туршид төрүүлэх хүүхдийн тоо багассаныг харуулж байна.
- Үелрэл шинжилгээгээр 1960–1980 онд төрсөн эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин буурах чиг хандлагатай байна. Түүнчлэн, оргил төрөх нас 20–24 насны бүлгээс 30–34 насны бүлэг рүү шилжсэн нь бодлогын оролцоо аль насны бүлэгт, аль мөчид чиглэх ёстойг тодорхой харуулж байна.
- Kitagawa загвараар сүүлийн арван жилд  $ТНК$ -ийн бууралтад насны бүтцийн нөлөө бус, хүүхэдтэй болох шийдвэрийн өөрчлөлт зонхилох нөлөө үзүүлснийг харуулж байна. Хотын залуу гэр бүлүүдийн 2, 3 дахь хүүхдээ төрүүлэх шийдвэр гаргалт саатаж байна. Насны тархалт 30–39 нас руу шилжсэн ч дараагийн хүүхэд төрүүлэх магадлал хотод илүү хурдан буурч, орон сууц, хүүхдийн асаргаа, ажил–амьдралын тэнцвэрт бус байдал шийдвэрийг хойшлуулж байна. Ийм учраас, насны бүтэц бус харин төрөх шийдвэр (зан төлөв)  $ТНК$ -ийн өөрчлөлтийг илүү тайлбарлах аж. Иймд бодлогын анхаарлыг “хүүхэд төрүүлэх эсэх” дээр бус, 25–34 насны эмэгтэйчүүд

болоод тэдний амьдралын эрсдэл, зардлыг бууруулахад төвлөрүүлэх хэрэгтэйг сануулж байна.

- Төрөлтийн талаарх ирээдүйн таамаглалаас харахад, бодлогын багц иж бүрэн биш хэвээр үргэлжилбэл 2050 онд ТНК 1.6–1.9 орчимд хүрэх эрсдэл өндөр, харин иж бүрэн, тогтвортой бодлогоор дэмжвэл ТНК 2.0–2.2-т ойртуулах боломжтой байна.
- Судалгааны үр дүнгээр, залуучуудын хүүхэдтэй болох хүсэл алга болоогүй, харин орон сууц, тогтворгүй орлого, асаргааны ачаалал, ажил-амьдралын тэнцвэрийн асуудлаас шалтгаалан төрөлтөө хойшлуулж байна. Өөрөөр хэлбэл, нийгэмд “олон хүүхэд зохимжтой” гэсэн үнэт зүйл бүрэн алдагдаагүй, дунджаар 3–4 хүүхдийг хүсэх хандлага хэвээр хадгалагдсаар байна. Анхны хүүхэд төрөх магадлал нь албан ёсны гэрлэлтийн байдалтай өндөр хамааралтай хэвээр байна. Гэрлэлт хойшлох, эсвэл тогтворгүй байх тусам төрөлт шууд хойшлогдож, зарим тохиолдолд бүр биелэлгүй үлдэх эрсдэл нэмэгдэж байна. Иймд залуучуудын нийгмийн хандлагыг өөрчлөхөөс илүү гэрлэх, анхны болон дараагийн хүүхдээ төрүүлэх шийдвэр гаргах орчныг сайжруулах (орон сууц, асаргаа, ажлын уян хатан нөхцөл) бодлого илүү чухал. Төрөлтийн бодлого нь зайлшгүй гэрлэлтийн бодлоготой уялдах шаардлагатай, гэрлэлтийг дэмжихгүйгээр төрөлтийг дэмжих бодлого үр дүн багатай болно.
- Гэрлэлтийн талаарх хандлага хоёрдмол шинжтэй байна. Нэг талаас, албан ёсны гэрлэлтийг үнэлэх байр суурь өндөр хэвээр боловч нөгөө талаас, салалтыг хүлээн зөвшөөрөх, гэрлээгүй үед хүүхэд төрүүлэхийг тодорхой хэмжээнд зөвшөөрөх уян хатан хандлага нэмэгдэж, уламжлалт амьдралын талаарх үнэт зүйл аажуу суларч байгааг харуулж байна.
- Олон улсын туршлагаас харахад, төрөлтөд хамгийн тогтвортой эерэг нөлөө үзүүлсэн бодлогууд нь хүүхэд асаргааны үйлчилгээ, нөхөн үржихүй дэх жендэрийн тэнцвэр, ажл-амьдралын тэнцвэрийг хангах хөдөлмөрийн зах зээлийн уян хатан зохицуулалт дээр төвлөрсөн байна. Харин нэг удаагийн тэтгэмж, богино хугацааны санхүүгийн дэмжлэг нь төрөлтөд түр нөлөө үзүүлдэг ч урт хугацаанд тогтвортой үр дүнд хүргэх нь хязгаарлагдмал байна.
- Монгол Улсад хэрэгжиж ирсэн бодлогуудын дийлэнх нь салангид, богино хугацааны шинжтэй байсан нь төрөлтийн түвшний хэлбэлзэлтэй уялдаатайгаар харагдаж байна. Иймд төрөлтийг дэмжих бодлого нь нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, хот байгуулалт, боловсролын бодлоготой уялдсан “амьдралын мөчлөгт суурилсан”, салбар хоорондын уялдаа бүхий бодлогын багц хэлбэрт шилжих шаардлагатайг судалгааны үр дүн өгүүлж байна.

## **7.2 Зөвлөмж**

Дээр дурдсан судалгааны ерөнхий дүгнэлтэд үндэслэн дараах бодлогын түвшинд хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг гаргалаа. Үүнд:

### **Зөвлөмж 1. Төрөх нас хойшлолтоос үүдсэн темпо нөлөөг бодлогоор сааруулах:**

Бодлогын зорилго нь хүүхэдтэй болох шийдвэрийг хойшлуулж буй залуу насныхны хувьд төрөх насыг эрт болгоход шахалт үзүүлэх бус, хойшлуулсан нөхцөлд ч хүүхэдтэй болох бодит боломжийг хадгалдаг байх ёстой.

### **Богино хугацаанд (1–2 жил):**

- Анхны хүүхэдтэй өрхөд орлогын шалгуургүй, шууд олгогдох түрээсийн дэмжлэг болон орон сууцны хөнгөлөлттэй зээлийн баталгааг бий болгох.

- Анхны хүүхэдтэй болох үед ажлын байр хадгалах баталгааг хөдөлмөрийн хууль, журамд тодорхой зааж, жирэмсэн болон амаржсан эхийг ажлаас чөлөөлөх, гэрээг сунгахгүй байх эрсдэлийг хориглох.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Залуу гэр бүлд чиглэсэн “Анхны хүүхдийн дэмжлэгийн багц”-ыг хуульчилж, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, орон сууц, асаргааны бодлоготой уялдуулах. “Анхны хүүхдийн дэмжлэгийн багц” гэдэг нь анхны хүүхэдтэй болох үед үүсдэг хөдөлмөр эрхлэлт, орлого, орон сууц, асаргаа, эрүүл мэндийн эрсдэлийг зэрэг бууруулах зорилготой, салбар хоорондын уялдаа бүхий бодлогын хэрэгслүүдийн цогц юм. Тухайлбал, анхны хүүхэдтэй өрхөд нэг удаагийн бус, 12–24 сарын хугацаанд олгогдох тогтмол орлогын дэмжлэг; орлогын албан татварын түр хугацааны хөнгөлөлт; орон сууцны түрээсийн дэмжлэг; орон сууцны зээлтэй өрхөд тодорхой хугацаанд (12–24 сар) зээлийн хүүг бууруулах, үндсэн төлбөрийг хойшлуулах; бага орлоготой анхны хүүхэдтэй өрхөд нэмэгдэл орлогын баталгаат дэмжлэг; асаргааны үйлчилгээний төлбөрт татварын хөнгөлөлт, купон хэлбэрийн дэмжлэг, асаргааны үйлчилгээ авах боломжгүй тохиолдолд гэрийн асаргаанд зориулсан бэлэн мөнгөний дэмжлэг; жирэмсний үеийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг бүрэн санхүүжүүлэх; анхны жирэмслэлтийн дараах эхийн эрүүл мэндийн хяналт, сэтгэлзүйн зөвлөгөөг багцлах, хөдөлмөр, орон сууц, асаргаа, тэтгэмжийн эрх, боломжийг нэг дороос авах дижитал систем гэх мэт орно.
- Хорин таваас гучин есөн (25–39) насанд 3 дахь хүүхдийн үед хэрэгжих шаталсан татварын хөнгөлөлт, хүүхдийн тоотой уялдсан орон сууцны бодлогын хэрэгслийг тогтолцооны хэмжээнд нэвтрүүлэх.
- Төрөх насыг хойшлуулсан эхчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, урьдчилан сэргийлэх үйлчилгээг зорилтот байдлаар санхүүжүүлэх, эрүүл мэндийн даатгалын санхүүжилттэй уялдуулах.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Нас, хүүхдийн дарааллаар ялгавартай дэмжлэг үзүүлэх механизмыг улсын хэмжээнд тогтвортой хэрэгжүүлж, темпо нөлөөнөөс үүдэх төрөлтийн алдагдлыг бодлогоор нөхөх.
- Төрөх нас хойшлолт, ажил–амьдралын зохицуулалт, асаргааны бодлогын уялдааг байнга хянах, засварлах институцийн тогтолцоог бий болгох.

**Зөвлөмж 2. Квантум бүүралтаас урьдчилан сэргийлэх, 2 ба 3 дахь хүүхдийн шийдвэрийг бодлогоор дэмжих:** Бодлогын зорилго нь хоёр, гурав дахь хүүхэд төрөх үед өрхийн амьдралын чанар муудна гэсэн хүлээлтийг бодит бодлогын хэрэгслээр сааруулах.

#### **Богино хугацаанд (1–2 жил):**

- Бүх хүүхдэд суурь тэтгэмж олгохын зэрэгцээ 2, 3 дахь хүүхдэд шаталсан нэмэлт тэтгэмж олгох механизмыг шууд хэрэгжүүлэх.
- Хоёроос дээш хүүхэдтэй өрхөд орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн бодит хөнгөлөлт үзүүлэх.

- Олон хүүхэдтэй өрхөд эрүүл мэнд, боловсролын гэнэтийн зардлыг даах даатгалын тусгай схем нэвтрүүлэх.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Хоёр, гурав дахь хүүхдийн үед орон сууцны зээл, түрээсийн дэмжлэгийг хүүхдийн тоо, асаргааны ачаалалтай уялдуулах тогтолцоог бүрдүүлэх.
- Олон хүүхэдтэй өрхийг хөдөлмөрийн зах зээлд тогтвортой байлгах зорилгоор уян хатан цаг, хагас цагийн ажлыг татвар, нийгмийн даатгалын бодлогоор дэмжих, хуулийн хэрэгжилтийг хангахад ажил олгоч нартай хамтрах.
- Олон хүүхэдтэй өрхөд чиглэсэн нийгмийн үйлчилгээний багцыг аймаг, дүүргийн түвшинд ялгавартай санхүүжүүлэх.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Хүүхдийн тоотой уялдсан татвар, нийгмийн хамгааллын бодлогыг тогтвортой хэрэгжүүлэх замаар квантум түвшинг хадгалах.
- Хоёр ба гурав дахь хүүхэдтэй өрхийн амьдралын чанарыг бусад өрхөөс дордуулахгүй байх бодлогын зарчмыг хуульчлах. Энэ хүрээнд хоёр болон гурав дахь хүүхэдтэй өрхөд татвар, нийгмийн даатгал, орон сууц, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд асаргааны үйлчилгээний хүртээмжийг бодитоор дэмжих, хүүхдийн тооноос шалтгаалсан нэмэлт зардлыг бодлогын хэрэгслээр нөхөх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай. Ийм зарчим хуульчлагдсанаар олон хүүхэдтэй байх нь өрхийн амьдралын чанарыг бууруулах эрсдэлтэй сонголт биш, харин төрөөс дэмжигдсэн, тогтвортой амьдралын нөхцөлтэй шийдвэр болох эрх зүйн орчин бүрдэнэ.

**Зөвлөмж 3. Гэрлэлтийн хойшлолттой үялдсан бодлогын хэрэгслүүдийг нэвтрүүлэх:** Бодлогын зорилго нь гэрлэлт, хамтын амьдралын шийдвэрийг эдийн засаг, орон сууц, хөдөлмөрийн эрсдэлгүйгээр гаргах нөхцөлийг бүрдүүлэх.

#### **Богино хугацаанд (1–2 жил):**

- Шинээр гэрлэсэн болон хамтран амьдарч буй залуу өрхөд чиглэсэн түрээсийн дэмжлэг, орон сууцны баталгаат зээлийн схем хэрэгжүүлэх.
- Гэрлэлт ба анхны хүүхдийн хоорондох хугацаанд төрийн дэмжлэг тасрахгүй байх зохицуулалт бий болгох. Ингэх нь залуу өрхийг хүүхэд төрөх хүртэлх завсрын үед бодлогын хувьд орхигдуулахгүй байхад чиглэнэ. Шинээр гэрлэсэн өрхөд олгосон орон сууц, түрээс, санхүүгийн дэмжлэгийг анхны хүүхэд төрөх хүртэл үргэлжлүүлж, тухайн хугацаанд дэмжлэгийн агуулгыг үе шаттайгаар өөрчилнө. Тухайлбал, гэрлэлтийн дараах үед орон сууц, орлогын тогтвортой байдалд чиглэсэн дэмжлэг хэрэгжиж, жирэмслэлт баталгаажсанаар эрүүл мэнд, нийгмийн хамгааллын дэмжлэг нэмэгдэн, хүүхэд төрсний дараа асаргаа болон ажил–амьдралын зохицуулалтад чиглэсэн бодлого руу шилжих нь зүйтэй
- Гэрлээгүй боловч хүүхэдтэй өрхийг нийгмийн хамгаалал, асаргааны системд бүрэн хамруулах. Энэ зохицуулалт нь хүүхэдтэй болох шийдвэрийг гэрлэлтийн байдалтай уялдуулан ялгаварлахгүй байх бодлогын чухал хэрэгсэл юм. Энэ хүрээнд хүүхдийн тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж, орон сууц, асаргааны үйлчилгээг гэрлэлтийн байдлаас үл хамааран тэгш хүртээмжтэй олгож, 0–3 насны хүүхдийн

асаргаанаас үүдэх хөдөлмөр эрхлэлтийн тасалдлын эрсдэлийг бууруулах нь зүйтэй. Ингэснээр хүүхдийн эрх ашиг хамгаалагдаж, хүүхэдтэй болох шийдвэр нийгмийн хамгааллын хувьд эрсдэлтэй сонголт болохоос сэргийлнэ.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Гэрлэлтийн шийдвэрт нөлөөлдөг орон сууц, орлого, ажлын тогтвортой байдлыг нэг багц бодлогоор шийдэх. Энэ бол залуу эрх гэр бүл болох үед тулгардаг гол гурван эрсдэлийг (байр, орлого, ажил) тус тусад нь бус, уялдаа холбоотойгоор нэг дор бууруулах бодлогын хэрэгслүүд юм. Тухайлбал, орон сууцны хувьд шинээр гэрлэсэн залуу өрхийг түрээсийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээл, нийгмийн орон сууцанд хамруулах замаар амьдрах орчны тодорхойгүй байдлыг бууруулахад чиглэх. Анхны хүүхэд төрсөн тохиолдолд эдгээр дэмжлэгийг сунгах, өмчлөх боломжтойгоор шилжүүлэх зохицуулалт хэрэгждэг байх. Орлогын тогтвортой байдлыг дэмжих чиглэлд залуу өрхийн орлогын огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор түр хугацааны орлогын дэмжлэг, татварын хөнгөлөлт, орлого тогтворгүй хөдөлмөр эрхлэгчдэд чиглэсэн хамгаалалтын механизмыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Ажлын байрны тогтвортой байдлыг хангах тухайд хөдөлмөрийн гэрээний баталгааг сайжруулж, уян хатан ажлын хэлбэрийг бодитоор хэрэгжүүлэх, залуу өрхийг тогтвортой ажлын байраар хангаж буй ажил олгогчдыг урамшуулах зэрэг орно.
- Залуу өрхийн санхүүгийн эрсдэлийг бууруулах хуримтлал, зээлийн хосолсон хэрэгслийг төрийн дэмжлэгтэйгээр нэвтрүүлэх.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Гэрлэлт, хүүхэд төрүүлэх шийдвэрийг дэмжих бодлогыг хот байгуулалт, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах.
- Залуу гэр бүлийн амьдрах орчныг дэмжих тогтвортой санхүүжилтийн механизм бүрдүүлэх.

**Зөвлөмж 4. Хүүхэд асаргааг төрөлтийг дэмжих бодлогын үндсэн хэрэгсэл болгох:** Бодлогын зорилго нь хүүхэд асаргаанаас үүдэх карьерын тасалдал, орлогын алдагдлыг бодлогоор нөхөх.

#### **Богино хугацаанд (1–2 жил):**

- 0–3 насны хүүхэд асаргааг хуульчилсан эрх болгон баталгаажуулах. Энэ хүрээнд төрөөс 0–3 насны хүүхэд бүр асаргааны үйлчилгээ авах эрхтэй байхыг хуульд тодорхой зааж, ясли, хүүхэд асаргааны төв, гэрийн асаргаа зэрэг хэлбэрийн үйлчилгээг бүс нутаг, амьдрах орчноос үл хамааран баталгаатай олгох зохицуулалт хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн төр–хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар асаргааны үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлж, үйлчилгээ авах боломжгүй тохиолдолд орлогын дэмжлэг эсвэл асаргааны тэтгэмжээр нөхөх механизмыг бий болгох нь зүйтэй.
- Хотод төр–хувийн хэвшлийн түншлэлээр асаргааны үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Энэ төрлийн төр–хувийн хэвшлийн хамтарсан асаргааны үйлчилгээ өмнө нь хэрэгжиж байсан ч бодит үр нөлөө сул байсан. Үүний гол шалтгаан нь санхүүжилт тогтворгүй, хамрах хүрээ хязгаарлагдмал, үйлчилгээ худалдан авах тодорхой механизм, хяналт-үнэлгээ дутмаг байсантай холбоотой. Иймд цаашид

төрөөс асаргааны үйлчилгээг нэг удаагийн дэмжлэгээр бус, тогтмол санхүүжилттэй, гэрээт үйлчилгээ, купон/нэг хүүхдэд ногдох татаасын зарчимд шилжүүлж, хувийн хэвшлийн оролцоог урт хугацаанд тогтвортой болгох шаардлагатай

- Хөдөөд гэрийн асаргааг дэмжих тэтгэмж, уян үйлчилгээ нэвтрүүлэх. Ясли, асаргааны байгууллага хүрэлцээгүй нөхцөлд бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд асрах боломжийг бодлогоор дэмжихэд чиглэнэ. Энэ хүрээнд гэртээ хүүхдээ асарч буй эх, эцэгт зорилтот тэтгэмж олгох, мөн явуулын болон ээлжлэн ажиллах асаргааны үйлчилгээ, зөвлөгөө, дэмжлэгийг орон нутгийн түвшинд уян хатан хэлбэрээр хэрэгжүүлэх нь зүйтэй.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Асаргааны үйлчилгээний чанар, хүртээмжийг бүс нутгаар ялгавартай санхүүжүүлэх.
- Асаргааны улмаас ажлаас түр чөлөөлөгдсөн эх, эцгийн нийгмийн даатгалын тасалдлыг төрөөс нөхөх.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Асаргааны бодлогыг боловсрол, хөдөлмөр эрхлэлттэй уялдуулсан үндэсний тогтолцоо болгон төлөвшүүлэх.

#### **Зөвлөмж 5. Ажил–амьдралын тэнцвэрийг бодит бодлогын хэрэгслээр хангах:**

Бодлогын зорилго нь хүүхэдтэй болсноор хөдөлмөр эрхлэлтийн эрсдэлд орохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.

#### **Богино хугацаанд (1–2 жил):**

- Эцгийн заавал авах квоттой эцгийн чөлөө (Parental Leave)-г хуульчлах. Ингэх нь хүүхэд асаргааны хариуцлагыг эхэд төвлөрүүлэхгүй, эцэг эхийн дунд бодитоор хуваалцах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Энэ зохицуулалтын хүрээнд эцэгт заавал эдлэх тодорхой хугацааны чөлөөг (жишээ нь 1–3 сар) хуульд тусгаж, тухайн хугацааг эхэд шилжүүлэх боломжгүй байхаар тогтоох нь зүйтэй. Мөн эцэг чөлөөгөө ашигласан тохиолдолд орлогын алдагдлыг нөхөх тэтгэмж олгож, ажлын байраа хадгалах эрхийг баталгаажуулснаар энэхүү чөлөө бодит амьдрал дээр хэрэгжих нөхцөл бүрдэнэ.
- Хүүхэдтэй эцэг эхэд уян хатан цаг, алсаас ажиллах эрхийг хуульчилсан байгаа ч хэрэгжилтийг хангах талд ажил олгогч нартай хамтран ажиллах. Энэ хүрээнд уян хатан болон алсын зайн ажлыг бодитоор хэрэгжүүлж буй байгууллагад татвар, нийгмийн даатгалын урамшуулал олгох, сайн туршлагыг нийтэд сурталчлан “гэр бүлд ээлтэй ажлын байр” гэсэн шалгуур, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй. Мөн ажил олгогчдод зориулсан арга зүйн зөвлөмж, загвар дотоод журам боловсруулж түгээх, хэрэгжилтийг хянах, дэмжих хамтарсан механизм бүрдүүлснээр уян хатан болон алсаас ажиллах зохицуулалт байгууллагын бодит практик болох нөхцөл бүрдэнэ.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг сааруулж буй далд зохицуулалтууд (буюу хууль, журамд ил тод тусгагдаагүй боловч ажилд авах, гэрээ сунгах, албан тушаал ахиулах, уян хатан ажлын зохицуулалтыг хэрэгжүүлэх явцад жирэмсэн болон бага

насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг системтэйгээр хязгаарлаж буй албан бус институцийн практик, хандлага, зах зээлийн зан үйлийг)-ыг арилгах.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Ажил–амьдралын тэнцвэрийг дэмжих бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн стандарт болгон тогтворжуулах. Ингэхийн тулд тулд хүүхэдтэй эцэг эх уян хатан ажлын цаг, алсаас ажиллах боломжийг бодитоор эдлэх эрхтэй байх, эцэг эхийн чөлөө авсан нь ажил эрхлэлт, цалин, албан тушаалд сөргөөр нөлөөлөхгүй байх, жирэмслэлт болон асаргааны улмаас ажлын байрыг алдах эрсдэл үүсэхгүй байх зохицуулалтыг нийтлэг мөрдөгдөх шаардлага болгох нь зүйтэй. Мөн уян хатан ажлын хэлбэр болон эцэг эхийн чөлөөг ашигласан ажилтныг сургалт, карьерын боломж, үнэлгээнээс хасахгүй байх, эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэх үүргийг ажил олгогчдод тодорхой хариуцлагатайгаар ногдуулах замаар ажил–амьдралын тэнцвэрийг бодит стандарт болгон тогтворжуулах шаардлагатай.

**Зөвлөмж 6. Амьдралын мөчлөгт суурилсан, салбар хоорондын нэгдсэн бодлогын тогтолцоог бүрдүүлэх:** Бодлогын зорилго төрөлтийг дэмжих бодлогыг салангид бус, амьдралын мөчлөгийн туршид хэрэгжүүлэх.

#### **Богино хугацаанд (1–2 жил):**

- Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, орон сууцны бодлогыг уялдуулах зохицуулах нэгж байгуулах. Монгол Улсад гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлыг хариуцсан институцүүд оршин байгаа боловч тэдгээр нь салбарын доторх бодлого, үйлчилгээний хэрэгжилтэд төвлөрч, эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг бусад салбарын бодлогыг уялдуулах Засгийн газрын түвшний эрх, мандат дутмаг байна. Иймд шинээр байгууллага байгуулах бус, одоо байгаа институцийн байр суурь, эрх хэмжээг өргөтгөн, салбар хоорондын бодлогын уялдааг хангах зохицуулалтыг бэхжүүлэх шаардлагатай.

#### **Дунд хугацаанд (3–5 жил):**

- Амьдралын мөчлөгт суурилсан бодлогын багцыг хуульчлах. Амьдралын мөчлөгт суурилсан бодлогын багц нь хүний амьдралын гол үе шат бүрд (гэрлэлт, хүүхэд төрөх, асрах, боловсрох, хөдөлмөр эрхлэх, орон сууцтай болох) төрийн дэмжлэгийг уялдаа холбоотойгоор олгох цогц бодлого юм. Энэ багцыг хуульчласнаар салбар хоорондын уялдаа, төрийн байгууллагуудын хариуцлага тодорхой болж, бодлогын хэрэгжилт тасралтгүй, тогтвортой хэрэгжих эрх зүйн орчин бүрдэнэ.
- Бодлогын хэрэгжилтийг 5–10 жилийн хугацаанд тогтвортой санхүүжүүлэх.

#### **Урт хугацаанд (6–10 жил):**

- Хүн амын бодлогыг улс орны урт хугацааны хөгжлийн бодлогын салшгүй хэсэг болгох.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Монгол хэл дээр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Үндэсний статистикийн хороо, & Эрүүл мэндийн яам. (1999). *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа 1998*, 67-76.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Үндэсний статистикийн хороо, & Эрүүл мэндийн яам. (2004). *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа 2003*, 71-82. Үндэсний статистикийн хорооны хэвлэл.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Үндэсний статистикийн хороо, & Эрүүл мэндийн яам. (2009). *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа 2008*, 73-85. Үндэсний статистикийн хорооны хэвлэл.

Үндэсний статистикийн хороо. (1990–2024). *Жил тутмын төрөлтийн статистик* [Өгөгдлийн сан]. 1212.mn. <https://1212.mn>

Үндэсний статистикийн хороо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, & Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан. (2014). *Нийгмийн үзүүлэлтүүдийн түүвэр судалгаа 2013*, 201-216. Үндэсний статистикийн хороо.

Энхцэцэг, Б., Пагмадулам, Г. (2017). Монгол улсын хүн амын төрөлтийн цаг хугацааны "темпо" өөрчлөлтийн шинжилгээ. *Монголын хүн амын сэтгүүл*, 27, 7–12. МУИС хэвлэл.

Энхцэцэг, Б. (2024). Монгол Улсын хүн амын төрөлтийн өөрчлөлтийн шинжилгээ. *Монголын хүн амын сэтгүүл*, 34, 5–16. МУИС хэвлэл.

### Англи хэл дээр

Allendorf, K., Thornton, A., Mitchell, C., Young-DeMarco, L., & Ghimire, D. J. (2017). Early women, late men: Timing attitudes and gender differences in marriage. *Journal of Marriage and Family*, 79(5), 1478–1496. <https://doi.org/10.1111/jomf.12426>

Billari, F. C., & Philipov, D. (2004). *Education and the transition to motherhood: A comparative analysis of Western Europe*. European Demographic Research Papers Series. Vienna Institute of Demography.

Bongaarts, J. and Potter, R. (2013). *Fertility, biology, and behavior: An analysis of the proximate determinants*. Academic Press.

Bongaarts, J. (2015). Modeling the fertility impact of the proximate determinants: Time for a tune-up. *Demographic Research* 33: 535-560.

Bongaarts, J. (1999). *The fertility impact of changes in the timing of childbearing in the developing world*, Population Council, New York

Bongaarts, J. and Sobotka, T. (2012). Demographic explanation for the recent rise in European fertility, *Population and Development Review*, Pages 83-120

Bongaarts, J., & Feeney, G. (1998). On the Quantum and Tempo of Fertility. *Population and Development Review*, 24(2), 271–291.

Buckley, C. (1998). Rural/urban differentials in demographic processes: The Central Asian states. *Population Research and Policy Review* 17: 71-89.

Chu, J., Liu, H., & Png, I. P. L. (2018). Nonlabor income and age at marriage: Evidence from China's heating policy. *Demography*, 55(6), 2345–2370. <https://doi.org/10.1007/s13524-018-0732-1>

Gereltuya, Altankhuyag. (2008). "Dramatic fertility decline in Mongolia and its determinants: The demise of the pronatalist State," *Asia-Pacific Population Journal* 23(2): 81-99.

Gereltuya, Altankhuyag, Jane Falkingham and James Brown. (2007). "Determinants of current contraceptive use and method choice in Mongolia," *Journal of Biosocial Science* 39(6): 801-817

Kalmijn, M. (2011). The influence of men's income and employment on marriage and cohabitation: Testing Oppenheimer's theory in Europe. *European Journal of Population*, 27(3), 269–293. <https://doi.org/10.1007/s10680-011-9238-x>

Kitagawa, E. M. (1955). Components of a Difference Between Two Rates. *Journal of the American Statistical Association*, 50(272), 1168–1194.

Lesthaeghe, R. (2020). The second demographic transition, 1986–2020: sub-replacement fertility and rising cohabitation—a global update. *Journal of Population Sciences*. Genus 76.

Neupert, Ricardo F. (1994). "Fertility decline in Mongolia: Trends, policies and explanations," *International Family Planning Perspectives* 20(1): 18–22.

Neupert, Ricardo F. (1996). *Population Policies, Socioeconomic Development and Population Dynamics in Mongolia*. Canberra: Australian National University, Research School of Social Sciences.

Preston, S., Heuveline, P., & Guillot, M. (2001). *Demography: Measuring and Modeling Population Processes*. Wiley

Singh, S. and Casterline, JB. Cleland, JG. (1985). The proximate determinants of fertility: Sub-national variations. *Population studies* 39: 113-135.

Spoorenberg, Thomas. (2009). "The impact of the political and economic transition on fertility and family formation in Mongolia: A synthetic parity progression ratios analysis," *Asian Population Studies* 5(2): 127-151.

Spoorenberg, Thomas, and Byambaa Enkhtsetseg. (2009). "Future low fertility prospects in Mongolia? An evaluation of the factors that support having a child," *Journal of Population Research* 26(2): 227-247.

United Nations. (2024). *World Population Prospects*. New York: United Nations Department for Economic and Social Information and Policy Analysis, Population Division. <https://population.un.org/wpp>

UNFPA. (2022). *Mongolia Annual Report*. UNFPA Mongolia, UN House.

United Nations, Department of Economic and Social Affairs, Population Division. (2024). *World Population Prospects: The 2024 Revision*. <https://population.un.org/wpp/>

Zeman, K., Beaujouan, É., Brzozowska, Z., & Sobotka, T. (2018). Cohort fertility decline in low fertility countries: Decomposition using parity progression ratios. *Demographic Research*, 38, 651–690. <https://doi.org/10.4054/DemRes.2018.38.25>

### **Цахим хуудас**

<http://www.1212.mn>

<https://www.gov.kz/situations/419/1019?lang=en>

[https://egov.kz/cms/en/articles/family\\_support/posobiya-i-lgoty?utm](https://egov.kz/cms/en/articles/family_support/posobiya-i-lgoty?utm)

<https://www.ilo.org/media/331811/download?utm>

<https://www.unicef.org/turkmenistan/social-and-child-protection?utm>

<https://bearth.org/regional-news/turkmenistan-how-family-policies-in-turkmenistan-reinforce-womens-caregiving-burden/?utm>

<https://documents1.worldbank.org/curated/en/099082024024536740/pdf/P179024-31e25a0c-2fba-4405-b941-2c6ebe0eae06.pdf?utm>

<https://www.unicef.org/uzbekistan/en/media/5011/file/Reforming%20child%20benefits%20system.pdf?utm>

[https://unece.org/sites/default/files/2024-10/2.03.04\\_%20Ergashev\\_Uzbekistan.pdf?utm](https://unece.org/sites/default/files/2024-10/2.03.04_%20Ergashev_Uzbekistan.pdf?utm)

<https://business.com.tm/post/7895/turkmenistan-lowers-retirement-age-for-mothers-with-eight-children?utm>

<https://turkmenportal.com/en/news/42956-new-laws-in-support-of-large-families-come-into-force-in-turkmenistan?utm>

<https://www.service-public.gouv.fr/particuliers/vosdroits/F3156?lang=en&ut>

<https://www.nur.kz/nurfin/pension/2202197-kakie-posobiya-poluchali-mnogodetnye-semi-v-kazahstane-v-2024-godu/?utm>

<https://www.oecd.org/content/dam/oecd/en/about/programmes/edu/ecec/migrate/starting-strong-vi/StartingStrongVI-CountryNote-Japan.pdf>

[https://elaw.klri.re.kr/eng\\_mobile/viewer.do?hseq=60064&key=38&type=part&utm](https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=60064&key=38&type=part&utm)

<https://www.canada.ca/en/employment-social-development/news/2025/03/toward-10-a-day-an-early-learning-and-child-care-background0.html?utm>

<https://www.madeforfamilies.gov.sg/support-measures/raising-your-child/financial-support/baby-bonus-scheme?utm>

<https://familienportal.de/familienportal/meta/languages/family-benefits/parental-allowance-141952?utm>

## ХАВСРАЛТ А

Хүснэгт А1. ТНК ба quantum (темпо-зассан ТНК)-ийн харьцуулалт, темпо нөлөөний хэмжээ

Year	ТНК	ТНК*(t)	TempoEffectShare	Year	ТНК	ТНК*(t)	TempoEffectShare
1990	4.42			2008	2.61	3.18	17.70
1991	4.01	3.62	-10.83	2009	2.73	3.06	10.79
1992	3.57	2.82	-6.67	2010	2.42	2.48	2.50
1993	2.62	2.30	-13.72	2011	2.56	2.28	-12.26
1994	2.80	2.45	-14.40	2012	2.63	2.83	7.22
1995	2.78	3.11	10.54	2013	2.86	3.98	28.21
1996	2.58	2.71	4.75	2014	3.01	4.71	36.05
1997	2.42	2.72	10.72	2015	3.01	3.39	11.17
1998	2.36	2.37	0.39	2016	2.95	2.96	0.37
1999	2.32	2.51	7.67	2017	2.79	3.11	10.43
2000	2.24	2.27	1.28	2018	2.92	3.74	21.95
2001	2.22	2.53	12.37	2019	2.99	3.74	20.29
2002	2.08	2.41	13.86	2020	2.94	3.57	17.81
2003	2.01	2.34	13.94	2021	2.78	3.34	16.74
2004	1.98	2.40	17.30	2022	2.57	3.22	20.07
2005	1.97	2.06	4.31	2023	2.55	3.25	21.33
2006	2.08	2.42	13.95	2024	2.32	2.70	13.88
2007	2.37	2.70	12.02				

Эх сурвалж: Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Хүснэгт А2. Бодит темпо-зассан ТНК\* ба квантум индекс, 5 жилээр, 1991-2024 (суурь он 1991)

1991 оны түвшнийг суурь болгосон		ТНК* <sub>суурь</sub> =3.6
Хугацаа	Бодит ТНК* <sub>хугацааны</sub>	Квантум индекс
1991–1995	2.9	79.0
1996–2000	2.5	69.4
2001–2005	2.3	64.8
2006–2010	2.8	76.4
2011–2015	3.4	94.9
2016–2020	3.4	94.6
2021–2024	3.1	86.3

Эх сурвалж: Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Хүснэгт А3. ТНК-ийн өөрчлөлтийн Kitagawa задаргаа, 5 жилийн интервалаар, 1990-2024

Интервал	Эхний ТНК	Сүүлчийн ТНК	Δ ТНК	Зан төлөвийн өөрчлөлт	Насны бүтцийн өөрчлөлт
1990–1994	4.42	2.80	-1.61	-0.35	+0.02
1995–1999	2.78	2.32	-0.46	-0.11	0.00
2000–2004	2.24	1.98	-0.26	-0.07	-0.01
2005–2009	1.97	2.73	+0.76	+0.18	-0.00
2010–2014	2.42	3.01	+0.60	+0.11	-0.02
2015–2019	3.01	2.99	-0.03	-0.01	-0.00
2020–2024	2.94	2.32	-0.61	-0.13	+0.00

Эх сурвалж: Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол. Үндэсний статистикийн хороо, 1212.mn

Хүснэгт А4. Амьд төрсөн хүүхдийн тоо, насны бүлгийн тархалтын хувиар, 15-49 насны эсэгтэйчүүдийн 5 насны бүлгээр, 1990-2024

Жил	Амьд төрсөн хүүхдийн тоо	Нийт төрөлт (%)	Нийт төрөлт дэх тухайн насны эмэгтэйчүүдийн төрөлтийн хувь нэмэр						
			15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49
1990	73209	100.00	6.0	33.8	33.0	17.8	6.9	2.0	0.5
1991	70083	100.00	6.8	34.6	33.3	16.5	6.5	1.8	0.5
1992	63258	100.00	8.6	35.7	30.5	16.2	6.5	1.9	0.6
1993	47871	100.00	9.3	37.8	30.0	14.8	6.2	1.6	0.4
1994	52962	100.00	8.5	38.9	29.0	15.3	6.2	1.8	0.4
1995	54293	100.00	7.3	39.2	29.0	15.5	6.7	1.9	0.4
1996	51806	100.00	7.2	37.5	30.5	15.8	6.8	1.7	0.4
1997	49488	100.00	9.9	35.4	28.9	15.6	7.3	2.3	0.5
1998	49256	100.00	7.5	36.3	30.3	16.0	7.5	2.0	0.4
1999	49461	100.00	8.1	36.4	30.7	15.5	7.1	1.8	0.4
2000	48721	100.00	7.5	35.8	30.4	16.9	7.2	1.9	0.4
2001	49685	100.00	8.1	35.1	30.1	16.6	8.0	1.8	0.3
2002	46922	100.00	6.5	35.1	30.9	18.0	7.0	2.1	0.4
2003	45723	100.00	5.9	35.5	30.4	17.6	7.7	2.4	0.5
2004	45501	100.00	6.1	34.9	30.4	17.2	8.9	2.2	0.5
2005	45326	100.00	5.0	32.7	32.2	18.8	8.8	2.0	0.5
2006	49092	100.00	6.2	34.3	31.0	18.0	8.1	2.1	0.3
2007	56636	100.00	5.2	32.3	31.0	19.5	9.3	2.4	0.4
2008	63768	100.00	4.7	31.4	30.7	20.2	10.3	2.4	0.3
2009	69167	100.00	4.1	32.4	30.4	19.6	10.8	2.4	0.3
2010	63270	100.00	4.2	31.4	30.5	19.8	10.9	2.9	0.4
2011	69853	100.00	3.9	31.7	31.4	19.0	10.9	2.7	0.4
2012	73839	100.00	5.7	32.6	29.6	19.3	10.6	2.1	0.1
2013	79780	100.00	4.5	29.4	31.3	19.5	11.9	2.9	0.4
2014	82839	100.00	3.9	25.9	31.1	21.8	12.9	3.9	0.5
2015	82130	100.00	4.4	25.8	32.0	22.0	12.6	3.1	0.1

<b>2016</b>	79920	100.00	4.8	25.4	<b>32.2</b>	22.1	12.4	3.0	0.1
<b>2017</b>	75321	100.00	4.7	23.9	<b>31.8</b>	23.4	13.0	3.1	0.2
<b>2018</b>	78444	100.00	4.5	23.1	<b>31.2</b>	24.3	13.4	3.4	0.2
<b>2019</b>	79580	100.00	4.3	22.2	<b>29.8</b>	25.5	14.5	3.5	0.1
<b>2020</b>	77716	100.00	3.8	21.4	<b>28.6</b>	26.8	15.4	3.8	0.2
<b>2021</b>	73253	100.00	3.5	20.2	<b>27.8</b>	27.6	16.6	4.1	0.2
<b>2022</b>	66910	100.00	3.6	21.2	27.3	<b>27.3</b>	16.4	4.1	0.2
<b>2023</b>	66234	100.00	3.1	19.0	26.5	<b>28.2</b>	18.5	4.4	0.2
<b>2024</b>	59644	100.00	3.3	18.5	<b>27.0</b>	26.7	19.4	4.8	0.3

Эх сурвалж: Жил тутмын төрөлтийн статистикт үндэслэсэн судлаачийн тооцоолол.  
 Үндэсний статистикийн хороо, 1212.тп

## ХАВСРАЛТ Б

### Хүснэгт Б1. Эмэгтэй, эрэгтэй хүний анхны гэрлэлтийн насны талаарх хүлээлт

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн тархалт, эмэгтэй/эрэгтэй хүний анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой насны талаарх хүлээлтээр, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат																						
	Эмэгтэй хүний анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой насны талаарх хүлээлт										Эрэгтэй хүний анхны гэрлэлтийн хамгийн тохиромжтой насны талаарх хүлээлт										15-34 насны эмэгтэйчүүдийн тоо	
	34 ба					34 ба					34 ба											
	18-20	21-23	24-26	27-29	30-32	түүнээс	Бусад	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт	18-20	21-23	24-26	27-29	30-32	түүнээс	Бусад	Мэдэхгүй	Хариулаагүй	Нийт		
<b>Бүгд</b>	5.2	11.1	57.9	10.8	9.7	0.2	0.9	3.6	0.6	100.0	4.0	6.6	51.7	15.4	13.9	1.7	0.8	5.2	0.6	100.0	817	
<b>Хот, хөдөө</b>																						
Хот	5.1	9.0	58.7	11.9	10.2	0.3	1.1	3.6	0.3	100.0	3.7	5.7	50.3	18.0	14.3	1.9	1.0	4.8	0.3	100.0	621	
Хөдөө	5.4	17.7	55.6	7.5	8.2	0.1	0.0	3.9	1.6	100.0	4.8	9.7	56.1	7.3	12.9	1.2	0.0	6.5	1.6	100.0	196	
<b>Бүс</b>																						
Баруун	4.6	13.6	63.6	8.7	5.9	0.0	0.0	1.7	1.9	100.0	4.7	6.0	70.1	5.0	10.6	0.0	0.0	1.7	1.9	100.0	106	
Хангай	6.2	17.4	53.2	9.6	10.0	0.1	0.0	2.8	0.8	100.0	2.3	13.6	50.1	8.4	16.9	0.1	0.9	6.8	0.8	100.0	160	
Төв	4.7	15.5	58.0	10.2	5.3	0.0	2.0	3.1	1.1	100.0	4.3	3.8	53.1	14.3	14.7	1.6	2.0	5.2	1.1	100.0	135	
Зүүн	13.9	12.1	48.5	6.5	14.4	0.0	0.0	4.6	0.0	100.0	14.8	9.0	42.3	16.4	8.6	0.1	0.0	8.8	0.0	100.0	59	
Улаанбаатар	3.6	5.6	59.9	13.0	11.7	0.4	1.2	4.6	0.0	100.0	2.6	4.3	48.1	22.0	14.2	3.3	0.5	5.0	0.0	100.0	357	
<b>Хотжилтын түвшин</b>																						
Хот	3.3	6.2	58.4	14.3	12.0	0.1	1.2	4.5	0.0	100.0	2.8	3.5	46.7	22.5	16.1	2.8	0.9	4.7	0.0	100.0	364	
Суурин газар, хагас нягтралтай	6.5	14.7	53.1	10.5	10.8	0.0	1.2	2.8	0.4	100.0	3.3	8.7	56.0	12.4	14.2	0.3	1.2	3.6	0.4	100.0	222	
Хөдөө	6.8	15.2	61.9	5.7	5.1	0.5	0.0	3.0	1.7	100.0	6.5	9.5	55.6	7.2	10.3	1.5	0.0	7.7	1.7	100.0	231	
<b>Насны бүлэг</b>																						
15-17	4.8	10.3	63.7	7.6	10.7	0.0	1.0	1.8	0.1	100.0	4.6	9.4	63.0	6.8	12.0	0.0	1.0	3.1	0.1	100.0	189	
18-20	4.4	3.9	64.9	14.3	8.5	0.0	0.0	2.1	2.0	100.0	2.9	2.8	57.9	21.1	5.1	3.1	0.0	5.1	2.0	100.0	84	
21-24	0.2	16.4	53.9	17.4	9.7	0.7	0.0	1.6	0.0	100.0	0.3	4.5	54.9	26.5	9.6	1.7	0.0	2.4	0.0	100.0	148	
25-29	4.8	8.0	57.1	11.7	7.0	0.4	1.4	8.1	1.5	100.0	2.9	5.9	45.1	18.1	15.8	0.8	0.9	8.9	1.5	100.0	162	
30-34	9.2	13.0	53.9	7.5	11.3	0.0	1.2	3.8	0.2	100.0	6.9	7.6	42.9	11.5	20.1	3.4	1.2	6.3	0.2	100.0	233	
<b>Төрөлтийн тоо</b>																						
0	3.2	9.4	58.2	15.1	9.3	0.1	0.5	3.6	0.5	100.0	2.9	5.3	57.5	17.4	11.2	1.3	0.5	3.4	0.5	100.0	402	
1	4.8	9.4	64.4	8.9	5.8	0.9	1.8	3.9	0.0	100.0	1.9	5.4	40.8	24.0	13.8	2.9	1.2	10.0	0.0	100.0	127	
2+	8.1	14.2	55.1	5.7	12.1	0.0	1.0	3.3	0.4	100.0	6.4	9.1	48.8	8.9	17.9	1.9	1.0	5.6	0.4	100.0	286	
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	2
<b>Боловсролын түвшин</b>																						
Боловсролгүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Бага	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Суурь	(11.1)	(6.5)	(51.0)	(5.9)	(6.8)	(0.0)	(0.0)	(18.8)	(0.0)	100.0	(3.6)	(1.4)	(65.4)	(4.9)	(8.2)	(0.0)	(0.0)	(16.5)	(0.0)	100.0	39	
Бүрэн дунд	3.8	14.1	60.7	7.6	9.2	0.0	1.4	2.6	0.5	100.0	4.1	10.9	57.9	8.5	12.1	0.2	1.4	4.3	0.5	100.0	267	
Техникийн	15.9	30.0	45.4	1.4	7.2	0.0	0.0	0.0	0.0	100.0	3.9	20.9	58.5	2.3	14.5	0.0	0.0	0.0	0.0	100.0	42	
Их, дээд сургууль, коллеж	4.0	8.4	58.5	14.8	9.6	0.4	0.7	2.9	0.8	100.0	3.4	3.6	47.3	22.6	14.5	3.1	0.5	4.2	0.8	100.0	442	
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	7
<b>Гэрлэлтийн байдал</b>																						
Гэрлэж байсан/Хамтран	7.4	13.3	57.4	7.3	8.9	0.3	1.1	4.3	0.0	100.0	5.3	7.7	49.1	13.6	15.6	1.7	0.6	6.3	0.0	100.0	446	
Огт гэрлээгүй	2.5	8.5	60.1	15.5	11.0	0.1	0.5	1.7	0.0	100.0	2.4	5.4	56.3	18.0	12.2	1.8	0.9	2.8	0.0	100.0	361	
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	9
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>																						
Халх	5.7	10.2	58.3	11.4	8.7	0.3	1.1	3.6	0.7	100.0	4.1	6.3	51.1	17.6	12.8	1.7	0.9	4.8	0.7	100.0	647	
Казах, дөрвөд, буриад	1.8	17.7	58.3	9.2	8.8	0.0	0.0	3.9	0.4	100.0	4.6	8.0	58.9	10.3	13.2	0.8	0.0	3.9	0.4	100.0	83	
Бусад	3.1	12.9	62.2	8.7	9.2	0.0	0.0	4.0	0.0	100.0	1.8	9.3	55.6	4.9	14.8	3.5	0.0	10.1	0.0	100.0	74	
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	12
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>																						
Доогуур	8.4	15.6	50.4	6.3	12.6	0.0	1.1	4.0	1.5	100.0	4.8	7.8	55.1	3.9	16.8	0.0	1.1	9.0	1.5	100.0	169	
Дунджаас доогуур	6.4	16.2	54.4	5.0	8.4	0.6	0.0	8.5	0.5	100.0	5.9	13.1	56.5	5.2	9.3	1.8	0.8	7.0	0.5	100.0	187	
Дундаж	6.8	11.2	65.5	6.3	5.1	0.0	1.5	2.7	0.9	100.0	5.9	4.4	59.1	12.1	8.8	1.3	0.0	7.4	0.9	100.0	155	
Дунджаас дээгүүр	3.0	6.9	57.7	12.8	16.5	0.0	1.4	1.5	0.0	100.0	2.0	2.5	34.0	32.2	24.6	1.0	1.4	2.3	0.0	100.0	136	
Дээгүүр	0.8	4.0	62.7	24.3	7.1	0.3	0.5	0.4	0.0	100.0	0.8	3.7	50.6	27.8	12.3	4.4	0.5	0.0	0.0	100.0	170	

( ) 25-49 жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

(\*) 25-аас цөөн жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

Хүснэгт Б2. Гэрлэлтэд хандах хандлага

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн тархалт, амьдралын төлөвлөгөөнд албан ёсны гэрлэлтийн ач холбогдлын түвшин, ерөнхийдөө чухалд тооцдог гэрлэлт/хамтын амьдралын хэлбэр, мөн салалтыг хүлээн зөвшөөрөх түвшнээр, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат																				
	Амьдралын төлөвлөгөөнд албан ёсны гэрлэлтийг хэр чухалд тооцож буй түвшин (%)							Ерөнхий ойлголтоор чухалд тооцогддог гэрлэлт, хамтын амьдралын хэлбэрүүд (%)					Салалтыг хүлээн зөвшөөрөх байдлын түвшний тархалт (%)					15-34 насны эмэгтэйчүүдийн тоо		
	Маш чухал	Чухал	Дунд зэрэг	Бага зэрэг чухал	Огт чухал биш	Мэдэхгүй/Хариулаагүй	Нийт	Албан ёсны гэрлэлт	Хамтран амьдрагч	Аль алийг нь (албан ба албан бус)	Чухалчил даггүй	Мэдэхгүй/Хариулаагүй	Нийт	Хүлээн зөвшөөрдөг	Зарим тохиолдолд хүлээн зөвшөөрдөг	Огт хүлээн зөвшөөрдөггүй	Мэдэхгүй/Хариулаагүй		Нийт	
<b>Бүгд</b>	57.9	29.3	8.3	1.9	1.3	1.4	100.0	73.2	3.7	15.1	4.1	4.0	100.0	30.9	49.2	15.9	4.0	100.0	817	
<b>Хот, хөдөө</b>																				
Хот	57.8	30.0	8.8	1.7	1.3	0.4	100.0	72.5	2.2	16.7	4.8	3.8	100.0	34.3	51.8	11.2	2.8	100.0	621	
Хөдөө	58.1	26.8	6.6	2.7	1.1	4.7	100.0	75.2	8.2	10.0	1.8	4.7	100.0	20.1	41.1	31.0	7.8	100.0	196	
<b>Бүс</b>																				
Баруун	63.3	13.5	11.8	4.1	3.9	3.5	100.0	75.5	8.0	10.7	0.0	5.9	100.0	11.9	36.2	43.1	8.8	100.0	106	
Хангай	65.4	29.0	2.3	0.0	0.9	2.4	100.0	70.1	4.8	16.8	3.9	4.3	100.0	33.4	49.7	12.9	4.1	100.0	160	
Төв	54.5	31.8	6.0	5.5	0.1	2.1	100.0	73.5	6.7	17.0	0.7	2.1	100.0	28.3	49.8	19.7	2.2	100.0	135	
Зүүн	44.1	43.3	7.4	2.5	0.7	2.1	100.0	72.1	2.1	20.2	1.8	3.8	100.0	28.3	50.1	16.7	5.0	100.0	59	
Улаанбаатар	56.4	30.8	10.9	0.7	1.2	0.0	100.0	73.9	1.0	14.1	7.0	4.1	100.0	36.8	52.5	7.7	3.0	100.0	357	
<b>Хотжилтын түвшин</b>																				
Хот	59.1	28.5	10.6	0.2	1.6	0.0	100.0	76.3	0.9	13.5	7.4	2.0	100.0	38.8	50.7	7.5	2.9	100.0	364	
Суурин газар, хагас нягтралтай	57.0	31.3	6.8	3.4	0.5	1.1	100.0	65.4	5.1	24.6	1.7	3.2	100.0	31.7	50.4	14.4	3.5	100.0	222	
Хөдөө	56.7	28.4	6.0	3.2	1.6	4.0	100.0	75.7	6.7	8.6	1.1	7.9	100.0	17.5	45.7	30.7	6.1	100.0	231	
<b>Насны бүлэг</b>																				
15-17	49.0	33.3	15.6	0.3	0.0	1.8	100.0	61.1	7.5	16.7	4.8	9.9	100.0	30.8	52.1	13.6	3.5	100.0	189	
18-20	71.8	22.6	2.7	0.9	0.0	2.0	100.0	73.9	0.5	23.6	0.0	2.0	100.0	27.1	61.4	9.6	2.0	100.0	84	
21-24	67.0	22.6	8.8	1.6	0.0	0.0	100.0	70.8	1.4	25.9	1.9	0.0	100.0	40.6	48.1	11.2	0.0	100.0	148	
25-29	55.3	30.1	9.8	1.7	0.9	2.1	100.0	76.8	2.9	10.4	7.2	2.6	100.0	33.4	41.4	15.7	9.5	100.0	162	
30-34	56.0	32.0	2.8	4.0	3.8	1.3	100.0	81.6	3.6	7.2	4.2	3.4	100.0	24.4	48.6	23.3	3.8	100.0	233	
<b>Төрөлтийн тоо</b>																				
0	59.9	28.5	9.0	1.1	0.0	1.5	100.0	70.5	4.6	17.1	2.3	5.5	100.0	32.4	51.4	11.9	4.3	100.0	402	
1	42.3	49.0	4.8	1.9	1.3	0.8	100.0	75.0	0.2	18.6	4.2	2.1	100.0	23.5	64.7	8.9	2.9	100.0	127	
2+	62.3	21.9	8.7	3.1	3.1	0.9	100.0	76.6	3.9	10.8	6.6	2.1	100.0	32.2	39.7	24.8	3.2	100.0	286	
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	2
<b>Боловсролын түвшин</b>																				
Боловсролгүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Бага	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Суурь	(35.3)	(51.3)	(12.0)	(1.1)	(0.2)	(0.0)	100.0	(76.5)	(8.8)	(11.4)	(1.3)	(2.0)	100.0	(15.9)	(19.8)	(42.2)	(22.1)	100.0	39	
Бүрэн дунд	57.7	28.1	10.5	2.0	0.2	1.6	100.0	67.5	5.4	14.9	4.8	7.4	100.0	31.5	51.3	14.8	2.4	100.0	267	
Техникийн	55.1	42.2	0.5	1.7	0.6	0.0	100.0	66.6	3.9	29.0	0.5	0.0	100.0	32.2	45.0	20.7	2.1	100.0	42	
Их, дээд сургууль, коллеж	61.8	26.7	6.2	1.9	2.2	1.3	100.0	78.2	2.2	13.0	4.4	2.2	100.0	31.9	52.3	12.7	3.1	100.0	442	
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	7
<b>Гэрлэлтийн байдал</b>																				
Гэрлэж байсан/Хамтран	57.5	30.2	7.0	2.7	2.4	0.2	100.0	77.2	2.4	14.0	4.9	1.5	100.0	31.2	46.4	18.7	3.7	100.0	446	
Огт гэрлээгүй	59.8	28.9	10.0	1.0	0.0	0.4	100.0	70.0	5.3	16.9	3.1	4.7	100.0	31.2	54.0	12.9	1.9	100.0	361	
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	9
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>																				
Халх	55.5	32.2	7.9	1.9	1.0	1.5	100.0	73.2	3.2	14.3	5.1	4.2	100.0	33.9	50.3	11.9	3.9	100.0	647	
Казах, дөрвөд, буриад	73.4	8.5	9.0	2.9	5.0	1.2	100.0	73.1	5.2	17.3	0.0	4.4	100.0	14.2	35.5	43.9	6.4	100.0	83	
Бусад	68.2	28.3	1.3	0.9	0.0	1.3	100.0	81.8	4.5	12.5	0.0	1.3	100.0	15.1	62.2	20.6	2.1	100.0	74	
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	12
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>																				
Доогуур	55.0	28.7	6.6	3.2	1.9	4.5	100.0	70.7	5.7	17.0	0.0	6.6	100.0	20.1	40.3	31.2	8.3	100.0	169	
Дунджаас доогуур	64.8	29.7	4.4	0.0	0.2	0.9	100.0	71.5	4.5	14.6	3.5	5.8	100.0	28.5	49.4	18.1	4.1	100.0	187	
Дундаж	58.9	29.7	7.3	2.1	0.6	1.4	100.0	83.2	2.2	11.3	1.9	1.4	100.0	24.2	53.1	17.7	4.9	100.0	155	
Дунджаас дээгүүр	48.7	38.5	12.1	0.5	0.1	0.0	100.0	74.2	2.5	16.5	6.8	0.1	100.0	33.4	53.3	10.8	2.4	100.0	136	
Дээгүүр	59.4	21.5	11.8	3.8	3.4	0.0	100.0	67.4	3.0	16.2	8.4	4.9	100.0	48.1	51.0	0.8	0.0	100.0	170	

( ) 25-49 жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

(\*) 25-аас цөөн жинлээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

### Хүснэгт Б3. Гэрлэлтэд тавигдах шаардлагатай зайлшгүй нөхцөлүүд

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн тархалт, гэрлэлтэд тавигдах шаардлагатай зайлшгүй нөхцөлүүдээр, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат											
	Гэрлэлтэд тавигдах шаардлагатай гэж хүлээн зөвшөөрөгдөж буй нөхцөлүүд (%)										15-34 насны эмэгтэйчүүдийн тоо
	Санхүүгийн тогтвортой байдал	Боловсрол	Тогтвортой ажлын байр	Амьдрах сууцтай байх	Эцэг, эхийн зөвшөөрөл	Хань болох хүний санал	Жирэмслэлт	Бусад	Хариулаагүй	Нийт	
<b>Бүгд</b>	37.0	12.2	26.4	25.1	14.8	19.8	2.3	12.1	13.5	<b>100.0</b>	817
<b>Хот, хөдөө</b>											
Хот	40.6	13.0	28.3	25.0	14.8	19.9	3.0	11.7	12.4	100.0	621
Хөдөө	25.7	9.9	20.4	25.3	14.9	19.3	0.3	13.4	17.3	100.0	196
<b>Бүс</b>											
Баруун	30.1	13.9	31.6	29.0	14.1	14.3	0.1	8.1	8.4	100.0	106
Хангай	25.2	6.5	20.9	30.5	9.5	29.5	2.3	14.6	15.3	100.0	160
Төв	36.0	15.2	25.7	27.7	21.5	27.7	0.3	13.6	11.9	100.0	135
Зүүн	32.1	8.9	12.8	21.4	9.5	13.0	0.0	13.5	31.6	100.0	59
Улаанбаатар	45.6	13.7	29.8	21.1	15.8	15.1	4.2	11.3	11.9	100.0	357
<b>Хотжилтын түвшин</b>											
Хот	46.8	11.3	30.2	23.1	12.9	16.9	5.1	11.3	11.2	100.0	364
Суурин газар, хагас нягтралтай	29.5	11.0	24.8	29.2	14.4	25.0	0.0	14.2	14.5	100.0	222
Хөдөө	28.9	14.9	22.0	24.2	18.1	19.3	0.3	11.3	16.3	100.0	231
<b>Насны бүлэг</b>											
15-17	35.1	11.9	18.1	20.7	16.9	16.0	0.0	9.8	20.8	100.0	189
18-20	44.7	12.4	42.3	25.1	17.5	12.9	0.0	6.8	7.3	100.0	84
21-24	42.6	16.1	24.4	21.4	17.4	15.6	0.0	17.1	11.6	100.0	148
25-29	46.0	11.4	22.2	24.7	11.3	14.8	2.4	10.0	12.8	100.0	162
30-34	26.0	10.6	31.5	31.2	12.9	31.4	6.6	14.0	11.7	100.0	233
<b>Төрөлтийн тоо</b>											
0	42.5	14.1	25.7	21.8	17.6	15.2	0.0	10.7	14.6	100.0	402
1	30.5	6.9	29.9	32.9	10.4	19.9	14.7	9.3	17.4	100.0	127
2+	32.5	12.0	25.9	26.4	13.0	26.3	0.2	15.3	9.7	100.0	286
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	2
<b>Боловсролын түвшин</b>											
Боловсролгүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Бага	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	10
Суурь	(34.1)	(0.0)	(36.6)	(30.5)	(23.5)	(29.1)	(0.0)	(8.6)	(13.0)	100.0	39
Бүрэн дунд	34.4	11.3	21.2	23.5	15.6	19.1	1.3	10.7	16.9	100.0	267
Техникийн	22.8	12.7	34.1	50.2	16.5	14.2	0.8	17.7	10.1	100.0	42
Их, дээд сургууль, коллеж	41.5	13.1	28.1	23.6	13.4	20.4	3.5	11.8	11.4	100.0	442
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	7
<b>Гэрлэлтийн байдал</b>											
Гэрлэж байсан/Хамтран	34.6	10.6	27.6	29.8	13.8	22.1	4.3	14.6	9.7	100.0	446
Огт гэрлээгүй	41.0	14.5	25.5	19.9	16.4	17.4	0.0	9.0	16.3	100.0	361
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	9
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>											
Халх	36.9	11.9	25.0	25.0	14.0	18.5	2.9	12.1	14.6	100.0	647
Казах, дөрвөд, буриад	23.2	16.9	35.6	36.9	21.1	19.2	0.0	8.1	6.4	100.0	83
Бусад	60.1	11.4	32.2	15.7	16.8	30.8	0.5	9.0	12.2	100.0	74
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	100.0	12
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>											
Доогуур	28.5	10.0	22.5	21.7	18.4	22.6	0.2	15.7	14.7	100.0	169
Дунджаас доогуур	37.4	13.8	19.4	32.0	17.9	23.2	2.0	16.0	14.3	100.0	187
Дундаж	33.0	4.8	24.0	25.8	13.9	21.1	0.0	7.3	18.4	100.0	155
Дунджаас дээгүүр	32.9	9.4	35.0	34.7	8.2	16.8	11.1	12.2	7.9	100.0	136
Дээгүүр	52.2	21.8	33.1	12.4	13.9	14.3	0.0	8.4	11.8	100.0	170

( ) 25-49 жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

(\*) 25-аас цөөн жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

**Хүснэгт Б4. Гэрлэлтийн талаарх хувь хүний шийдвэрт нөлөөлөх нийгмийн дарамт ба нөлөөлөл**

15-34 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн тархалт, гэрлэлтийн талаар гэр бүл, үе тэнгийнхэн, нийгэм болон бусдаас ямар нэгэн дарамт, нөлөөлөл мэдэрч байсан хувь, уг дарамт нөлөөлөл нь тэдний гэрлэлтийн талаарх хувийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, мөн дарамт нөлөөлөл хувийн шийдвэрт хэрхэн нөлөөлсөн байдлаар, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат					
	Гэрлэлтийн талаар гэр бүл, үе тэнгийнхэн, нийгэм болон бусдаас ямар нэгэн дарамт, нөлөөлөл мэдэрч байсан хүмүүсийн хувь	15-34 насны эмэгтэйчүүдийн тоо	Дарамт, нөлөөлөл нь гэрлэлтийн талаарх хувийн шийдвэрт нь нөлөөлсөн хүмүүсийн хувь	Гэрлэлтийн талаар гэр бүл, үе тэнгийнхэн, нийгэм болон бусдаас ямар нэгэн дарамт, нөлөөлөл мэдэрч байсан 15-34 насны эмэгтэйчүүдийн тоо	Дарамт, нөлөөлөл нь гэрлэлтийн талаарх хувийн шийдвэрт нь нөлөөлсөн 15-34 насны эмэгтэйчүүдийн тоо
<b>Бүгд</b>	4.5	817	(55.5)	37	21
<b>Хот, хөдөө</b>					
Хот	4.7	621	(*)	29	17
Хөдөө	4.1	196	(*)	8	3
<b>Бүс</b>					
Баруун	1.9	106	(*)	2	0
Хангай	4.2	160	(*)	7	4
Төв	4.7	135	(*)	6	5
Зүүн	0.1	59	(*)	0	0
Улаанбаатар	6.1	357	(*)	22	12
<b>Хотжилтын түвшин</b>					
Хот	5.9	364	(*)	21	13
Суурин газар, хагас хотжилттай	3.3	222	(*)	7	4
Хөдөө	3.6	231	(*)	8	3
<b>Насны бүлэг</b>					
15-17	0.8	189	(*)	1	0
18-20	3.6	84	(*)	3	0
21-24	6.8	148	(*)	10	8
25-29	5.8	162	(*)	9	4
30-34	5.6	233	(*)	13	8
<b>Төрөлтийн тоо</b>					
0	5.4	402	(*)	22	12
1	9.6	127	(*)	12	8
2+	1.1	286	(*)	3	0
Хариулаагүй	(*)	2	-	0	0
<b>Боловсролын түвшин</b>					
Боловсролгүй	(*)	10	-	0	0
Бага	(*)	10	-	0	0
Суурь	(8.9)	39	(*)	4	2
Бүрэн дунд	1.0	267	(*)	3	0
Техникийн	1.2	42	(*)	1	1
Их, дээд сургууль, коллеж	6.8	442	(*)	30	18
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	7	-	0	0
<b>Гэрлэлтийн байдал</b>					
Гэрлэж байсан/Хамтран	4.0	446	(*)	18	8
Огт гэрлээгүй	5.3	361	(*)	19	12
Хариулаагүй	(*)	9	-	0	0
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>					
Халх	3.7	647	(*)	24	12
Казах, дөрвөд, буриад	3.4	83	(*)	3	0
Бусад	13.7	74	(*)	10	8
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	12	-	0	0
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>					
Доогуур	3.4	169	(*)	6	4
Дунджаас доогуур	1.9	187	(*)	4	0
Дундаж	6.1	155	(*)	10	5
Дунджаас дээгүүр	2.4	136	(*)	3	2
Дээгүүр	8.8	170	(*)	15	10

( ) 25-49 жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.  
 (\*) 25-аас цөөн жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.  
 - 0 жиллээгүй ажиглалтад суурилсан буюу хувь тооцох боломжгүй.

**Хүснэгт Б5. Гэрлэлт, хамтын амьдралын талаарх шийдвэрт нөлөөлөх хувь хүний болон нийгэм-соёлын хүчин зүйлс**

15-34 насны эмэгтэйчүүдийн хувийн жин, гэрлэлтийн талаарх шийдвэрт нь нөлөөлсөн эсвэл нөлөөлөх магадлалтай хувь хүний болон нийгмийн хүчин зүйлсээр, Монгол Улс MICS Plus 2025-26, 1-р шат

	Гэрлэлтийн талаарх шийдвэрт нь нөлөөлсөн эсвэл нөлөөлөх магадлалтай хувь хүний болон нийгмийн хүчин зүйлс							15-34 насны эмэгтэйчүүдийн тоо
	Гэр бүлийнхний санал	Найзууд болон үе тэнгийгнхний санал	Нийгмийн сүлжээ, цахим орчны нөлөөлөл	Нийгмийн нийтлэг хандлага, уламжлалт үнэлэмж	Өөрийн хүсэл сонирхол, хувийн үнэт зүйлс	Хос/хамтран амьдрагчийн санал	Бусад	
<b>Бүгд</b>	59.4	25.7	7.5	15.4	89.5	87.4	1.6	817
<b>Хот, хөдөө</b>								
Хот	60.0	26.9	6.4	13.8	91.9	90.3	1.7	621
Хөдөө	57.7	21.8	10.9	20.6	82.0	78.1	1.3	196
<b>Бүс</b>								
Баруун	65.4	35.8	16.2	26.0	75.1	71.4	1.9	106
Хангай	58.0	19.5	7.6	13.8	89.7	93.2	0.5	160
Төв	57.1	25.7	5.4	16.1	87.9	84.1	2.2	135
Зүүн	51.1	19.1	8.8	9.6	85.8	83.0	0.0	59
Улаанбаатар	60.6	26.5	5.4	13.7	94.9	91.6	2.0	357
<b>Хотжилтын түвшин</b>								
Хот	61.2	24.7	5.9	12.7	95.2	92.0	2.0	364
Суурин газар, хагас нягтралтай	52.8	23.6	10.2	16.0	86.9	87.5	1.5	222
Хөдөө	63.1	29.1	7.5	19.2	83.1	80.2	1.1	231
<b>Насны бүлэг</b>								
15-17	66.7	39.0	13.0	27.0	91.3	86.8	4.6	189
18-20	53.2	25.7	3.0	14.9	86.4	86.1	0.0	84
21-24	69.6	27.2	4.0	10.4	92.9	87.3	0.0	148
25-29	51.8	12.5	4.1	8.4	91.6	93.1	0.5	162
30-34	54.7	23.0	9.2	14.3	85.7	84.5	1.5	233
<b>Төрөлтийн тоо</b>								
0	62.9	31.1	7.7	19.2	91.1	86.6	2.2	402
1	54.7	23.2	5.2	4.7	90.5	92.1	0.7	127
2+	57.1	19.3	8.3	15.0	87.6	87.1	1.2	286
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	2
<b>Боловсролын түвшин</b>								
Боловсролгүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	10
Бага	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	10
Суурь	(45.4)	(29.9)	(20.6)	(29.4)	(76.9)	(81.8)	(3.7)	39
Бүрэн дунд	62.0	31.6	10.2	20.0	92.6	85.9	3.5	267
Техникийн	36.6	8.4	7.3	12.0	86.8	86.5	0.0	42
Их, дээд сургууль, коллеж	62.1	23.3	5.1	11.4	90.6	90.3	0.5	442
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	7
<b>Гэрлэлтийн байдал</b>								
Гэрлэж байсан/Хамтран	56.6	17.9	6.5	11.7	89.5	89.1	1.0	446
Огт гэрлээгүй	64.5	35.9	8.8	20.5	91.9	87.6	2.4	361
Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	9
<b>Өрхийн тэргүүний яс үндэс</b>								
Халх	58.7	23.9	6.3	14.4	92.1	88.6	1.7	647
Казах, дөрвөд, буриад	58.7	39.7	17.6	23.9	73.0	71.2	2.4	83
Бусад	65.9	28.9	4.7	17.1	87.8	95.0	0.0	74
Мэдэхгүй/Хариулаагүй	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	(*)	12
<b>Өрхийн аж байдлын түвшин</b>								
Доогуур	58.1	28.1	10.9	18.9	79.5	83.2	1.5	169
Дунджаас доогуур	56.4	29.2	7.4	19.0	83.0	83.7	0.4	187
Дундаж	63.0	21.1	7.7	15.5	92.6	92.8	0.3	155
Дунджаас дээгүүр	53.8	17.3	4.8	9.0	96.1	91.5	1.4	136
Дээгүүр	65.5	30.1	6.2	13.2	98.6	87.5	4.3	170

( ) 25-49 жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

(\*) 25-аас цөөн жиллээгүй ажиглалтад суурилсан тооцоолол.

## ХАВСРАЛТ В

Хүснэгт В1. Төрөлтийг дэмжих бодлогын багц, сонгосон улс орнуудаар

Улс	Бодлого, арга хэмжээ	Сайн туршлага	Сургамж
Франц	<ul style="list-style-type: none"> <li>Өндөр түвшний төрийн татаас буюу хүүхдийн мөнгө, татварын хөнгөлөлт</li> <li>Урт хугацааны улсын СӨБ (цэцэрлэг 0–3 наснаас эхэлдэг)-ийн үйлчилгээ</li> <li>Эцэг, эхийн цалинтай чөлөө: Эхэд 16 долоо хоног, эцэгт 4 долоо хоног (хуульчилсан)</li> <li>Уян хатан ажлын цагийн бодлого</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Өрхөд санхүүгийн болон үйлчилгээний дэмжлэгийг нэг дороос авах боломж</li> <li>Хүүхэд асрах үйлчилгээний хүртээмж өндөр</li> </ul>	Санхүүгийн дэмжлэг дангаараа биш, үйлчилгээний хүртээмж ба ажлын нөхцөл сайтай байх зэрэгтэй хосолж байж төрөлтийн түвшинг тогтвортой хадгална гэдгийг харуулсан.
Швед	<ul style="list-style-type: none"> <li>Цалинтай эцэг, эхийн чөлөө - 480 хоног (эхнэр, нөхөр тэнцүү хувааж авдаг)</li> <li>Хүүхэд асрах төрийн үйлчилгээ өргөн хүртээмжтэй, чанартай</li> <li>Гэр бүлд ээлтэй ажлын цагийн бодлого</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Аавуудын оролцоог нэмэгдүүлснээр хүүхэд асрах ажлыг тэгш хуваарилдаг.</li> <li>Хөдөлмөр эрхлэлт өндөр хэвээр хадгалах боломж</li> </ul>	Эцэг, эхийн чөлөөг зөвхөн ээжид бус, аавд ч оногдуулах нь чухал гэдгийг харуулсан.
Герман	<ul style="list-style-type: none"> <li>Elterngeld – Хүүхэд төрүүлсний дараах цалинтай чөлөө (12–14 сар)</li> <li>Kindergeld – Хүүхдийн мөнгө сар бүр</li> <li>Улсын цэцэрлэг, сургуулийн өмнөх боловсрол</li> </ul>	Эцэг, эхийн орлогын түвшинд нийцсэн дэмжлэг үзүүлдэг.	Уян хатан ажлын цагийн бодлого, жендерийн тэгш оролцоо чухал гэдгийг сануулсан.
Чех	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд асрах тэтгэмж – 3 хүртэл жил</li> <li>Цэцэрлэгийн хүртээмж өндөр</li> <li>Татварын хөнгөлөлт</li> </ul>	Урт хугацааны асрамжийн тэтгэмж нь эхчүүдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.	Ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бууруулахгүй байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй.
Канад	<ul style="list-style-type: none"> <li>Child Benefit – Хүүхэд бүрт тогтмол мөнгөн дэмжлэг</li> <li>Эцэг, эхийн цалинтай чөлөө 12–18 сар</li> <li>Орон нутгийн уян хатан үйлчилгээ</li> </ul>	Төр-хувийн хэвшлийн үйлчилгээний холимог загвар сайн ажилладаг.	Орлогын түвшин багатай өрхөд илүү чиглэсэн бодлого үр дүнтэй.
Япон	<ul style="list-style-type: none"> <li>“Angel Plan” – Хүүхэд асрах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</li> <li>Ажлын цагийн хуулийн өөрчлөлт – Эцэг, эх уян хатан цагаар ажиллах</li> <li>Сургуулийн өмнөх боловсролын татаас</li> </ul>	Хот суурин газарт хүүхэд асрах төвүүдийг нэмэгдүүлсэн.	Ажил олгогчийн соёл өөрчлөгдөхгүй бол төрийн бодлого хангалтгүй.
Сингапур	<ul style="list-style-type: none"> <li>“Baby Bonus” хөтөлбөр – Хүүхэд бүрт төрөөс мөнгөн татаас</li> <li>Tax rebate – Хүүхэдтэй өрхөд татварын хөнгөлөлт/бууралт</li> </ul>	Санхүүгийн дэмжлэгийн зэрэгцээ орон сууцны боломжийг зэрэг шийдсэн.	Зөвхөн мөнгөн татаас хангалтгүй, “Ажил-Амьдрал”-ын тэнцвэрийг хангах орчны бодлого шаардлагатай.

Улс	Бодлого, арга хэмжээ	Сайн туршлага	Сургамж
	<ul style="list-style-type: none"> <li>Төрийн орон сууцанд хөнгөлөлт – Залуу гэр бүлд хамаатай</li> </ul>		
Өмнөд Солонгос	<ul style="list-style-type: none"> <li>Төрөлт бүрт мөнгөн урамшуулал (5 сая воноос дээш)</li> <li>Цэцэрлэгийн татаас – Хүүхэд бүрт үнэ төлбөргүй цэцэрлэг</li> <li>Эцэг, эхийн чөлөөний дэмжлэг</li> </ul>	Хүүхэд асрах зардлыг төр бүрэн даах оролдлого	Нийгэм, соёлын хүчин зүйл (ажлын цаг уртаас гэр бүлдээ зарцуулах цаг богино, эмэгтэйчүүдийн карьер тасалдах эрсдэл) бодлогоос илүү нөлөөлдөг гэдгийг харуулсан.
Казахстан	<ul style="list-style-type: none"> <li>“Многодетная семья” буюу олон хүүхэдтэй өрхөд зориулсан мөнгөн тэтгэмжийн систем (хүүхдийн тооноос хамаарсан шатлалтай)</li> <li>Төрөх үед нэг удаагийн тэтгэмж, хүүхдийн асаргааны сар бүрийн тэтгэмж</li> <li>Орон сууцны хөнгөлөлттэй зээл, ипотекийн хөтөлбөр – олон хүүхэдтэй гэр бүлийг зорилтот бүлэгт оруулдаг.</li> <li>Эцэг эхийн чөлөө, ажлын байрны хамгаалалт сайжирч байгаа ч эмэгтэйчүүдийн ачаалал давамгайл.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн хамгааллын тогтолцоог төрөлттэй уялдуулж шатлалтай тэтгэмж олгодог.</li> <li>Хүүхэд асаргааны дэмжлэгийг орон нутгийн түвшинд хүртээмжтэй болгох оролдлого</li> </ul>	Санхүүгийн дэмжлэг чухал ч эмэгтэйчүүдийн “Ажил-Амьдрал”-ын тэнцвэрийг хангах бодлого сул байгаагаас төрөлтөд урт хугацааны эерэг үр дүн бага.
Туркменистан	<ul style="list-style-type: none"> <li>Нэг удаагийн мөнгөн тэтгэмж төрөх бүрт олгодог (төрөх эмнэлэгт төрсөн тохиолдолд илүү урамшуулдаг)</li> <li>Үнэгүй эсвэл хөнгөлөлттэй үйлчилгээ – хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, спортын сургалт</li> <li>Олон хүүхэдтэй эхчүүдэд “Эхийн баатар” цол, урамшуулал олгодог уламжлал хадгалагдсан.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн боловсрол, спорт, эрүүл мэндийн үйлчилгээ үнэ төлбөргүй эсвэл маш бага өртөгтэй.</li> <li>Улсын төсөвт суурилсан нийт хүн амд чиглэсэн бодлого</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үйлчилгээний чанар ба хүртээмжийг илүү сайжруулахгүй бол зөвхөн урамшуулал нь төрөлтөд тогтвортой нөлөө үзүүлэхгүй.</li> <li>Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн бодлого бараг байхгүй.</li> </ul>
Тажикстан	<ul style="list-style-type: none"> <li>“Балалы Үй-Бүлө” хөтөлбөр – хүүхдийн тооноос хамаарсан сар бүрийн тэтгэмж</li> <li>Эхийн тэтгэмж: анхны хүүхдээс эхлэн төрөх бүрт нэг удаагийн мөнгөн тэтгэмж</li> <li>Хөдөө орон нутагт залуу гэр бүлд зориулсан газрын дэмжлэг болон бага хүүтэй зээл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөө орон нутгийн хүн амд чиглэсэн бодлого нь шинэ гэр бүлд орон сууцтай болоход тусалдаг.</li> <li>СӨБ, хүүхэд асаргааны байгууллагыг олон улсын байгууллагын дэмжлэгтэй өргөтгөж байгаа.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн хөтөлбөрүүд төсвийн тогтворгүй байдлаас шалтгаалж тасалдалтай хэрэгждэг нь итгэлцэлд сөргөөр нөлөөлдөг.</li> <li>Алслагдсан бүсийн эмнэлгийн үйлчилгээ сул, төрөлтийг хязгаарлагч хүчин зүйл хэвээр байгаа</li> </ul>
Узбекстан	<ul style="list-style-type: none"> <li>“Mehrbon Ona” (Энэрэнгүй эх) зэрэг хөтөлбөрөөр олон хүүхэдтэй эхчүүдэд онцгой урамшуулал олгодог.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>СӨБ-ын хүртээмжийг богино хугацаанд хурдтай өсгөсөн нь төрөлтийн шийдвэрт эергээр нөлөөлсөн.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад шилжилт хөдөлгөөн ихтэйгээс залуу гэр бүлийн тогтвортой байдалд сорилт болж байна.</li> <li>Хөдөлмөр эрхлэлт, орон сууцны</li> </ul>

Улс	Бодлого, арга хэмжээ	Сайн туршлага	Сургамж
	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн асаргааны мөнгөн тэтгэмж, СӨБ-ын дэмжлэг.</li> <li>Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг өргөжүүлэхэд онцгой анхаарч байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн халамжийг дижиталжуулж, зорилтот бүлэгт шууд хүргэх тогтолцоог эхлүүлсэн.</li> </ul>	хүртээмжийг зэрэг сайжруулах шаардлагатай.
Вьетнам	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхэд төрөхөд нэг удаагийн мөнгөн урамшуулал (зарим муж, хот)</li> <li>Эхийн жирэмсний болон төрсний дараах 6 сарын чөлөө олгодог</li> <li>Үргүйдлийн эмчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлсэн.</li> <li>Хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төр–хувийн хэвшлийн түншлэлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн.</li> <li>“Хоёр хүүхэд хангалттай” хуучин уриаг халж, төрөлтөд эерэг хандлагыг дэмжсэн сурталчилгааны кампанит ажил өрнүүлж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үргүйдлийн эсрэг болон нөхөн үржихүйн тусламжийг бодлогын түвшинд тусгасан нь бусад хөгжиж буй орнуудаас ялгарна.</li> <li>Хот, хөдөөгийн төрөлтийн ялгааг харгалзсан зохицуулалт хийж буй.</li> <li>Нийгмийн уриалга, сурталчилгаа – хуучин сөрөг уриаг өөрчилж, эерэг ойлголт бий болгохыг зорьсон нь зөв чиглэл болсон.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн мөнгөн урамшуулал хангалтгүй, орон сууцны хүртээмж, амьжиргааны өртөг зэрэг бодит хүчин зүйлд хандсан бодлого шаардлагатай.</li> <li>Залуусын дунд тогтсон “хоёр хүүхэд хангалттай” хандлага богино хугацаанд өөрчлөгдөхгүй тул нийгмийн соёл, хэвшлийг өөрчлөх урт хугацааны бодлого хэрэгтэй.</li> <li>Хот, хөдөөгийн ялгааг зөв зохицуулахгүй бол хүн амын тэгш бус өсөлт, нийгмийн ачаалал үүсгэх эрсдэлтэй.</li> </ul>
Монгол	<ul style="list-style-type: none"> <li>Хүүхдийн мөнгө (сар бүр)</li> <li>Эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж</li> <li>Орон сууцны хөнгөлөлттэй зээл</li> </ul>	Мөнгөн дэмжлэг хүүхэд бүрт өгдөг.	Хүүхэд асрах үйлчилгээний хүртээмж муу, ажлын уян хатан нөхцөл сул байгаа нь төрөлтөд сөргөөр нөлөөлдөг.

Хүснэгт В2: Амьдралын мөчлөгт суурилсан бодлогын багцын бүтэц (загвар жишээ)

Амьдралын үе шат	Гол шийдвэр	Төрийн бодлогын зорилт	Санал болгож болох бодлогын хэрэгсэл
Залуу нас (18–29)	Гэрлэлт, карьерын эхлэл	Тодорхой бус байдлыг багасгах (Гэрлэлт, хүүхэдтэй болохоос айх шалтгааныг багасгах)	<ul style="list-style-type: none"> <li>Залуу ерхийн орон сууцны хуримтлалын данс (хүүхэд төрөхөд төр нэмэлт хувь нэмж өгдөг)</li> <li>Оюутан, залуучуудад: Тогтвортой хөдөлмөрийн анхны гэрээ, нийгмийн даатгалын тасралтгүй байдал</li> <li>Амьдрал, гэр бүл төлөвлөлтийн боловсрол: Гэр бүл, хүүхдийн талаарх эерэг, бодит мэдээлэл түгээх</li> </ul>
Гэр бүл болох (25–32)	Анхны хүүхэд	Эрсдэлийг төр хуваалцах, анхны хүүхэд эрсдэлгүйгээр төрөх нөхцөл бүрдүүлэх (“Хүүхэдтэй боллоо карьераа алдлаа” гэх айдсыг арилгах)	<ul style="list-style-type: none"> <li>Эхийн тэтгэмж, орлогын орлуулалт, татварын хамгаалалт</li> <li>Эцэг эхийн хамтарсан уян хатан чөлөө буюу parental leave</li> <li>Эцгийн заавал авах cap (non-transferable), эцгйн оролцоог quota, урамшууллаар дэмжих</li> </ul>
Нярай–бага нас (0–3)	Асаргаа	Эцэг эх ажиллах боломж (Эцэг эх: “Ажил ба Хүүхэд” зэрэг явах боломж)	<ul style="list-style-type: none"> <li>Ясли, асаргааг хуульчилсан эрх болгох</li> <li>Хотод: төр–хувийн хэвшлийн асаргааны үйлчилгээ</li> <li>Хөдөөд: гэрийн асаргааг дэмжих тэтгэмж</li> <li>Асаргааны зардлын татвар, тэтгэмж</li> </ul>
СӨБ–бага боловсрол (3–8)	2–3 дахь хүүхэд	Өрхийн дарамт бууруулах (Олон хүүхэдтэй болсон ч амьдрал дордохгүй гэсэн итгэл үнэмшилтэй байх)	<ul style="list-style-type: none"> <li>Шаталсан хүүхдийн нэмэлт мөнгө (2, 3 дахь хүүхэд)</li> <li>Хүүхдийн тоотой уялдуулсан татварын бодит хөнгөлөлт (орлоготой өрхөд мэдрэгдэх)</li> <li>Орон сууцны: зээлийн хүү бууруулах, түрээсийн дэмжлэг нэмэгдэх, ялангуяа хотын залуу өрхөд зорилтот багц</li> </ul>
Сургуулийн нас (6–16)	Урт хугацааны тогтвортой байдал	Итгэл, урьдчилсан таамаг (“Олон хүүхэдтэй ч ирээдүй тодорхой” гэх итгэл)	<ul style="list-style-type: none"> <li>Боловсролын хүртээмж, чанарын баталгаа</li> <li>Олон хүүхэдтэй өрхийн нийгмийн баталгаа: Эрүүл мэнд, боловсролын гэнэтийн зардлын даатгал</li> <li>Ажил-амьдралын тэнцвэрийн зохицуулалт</li> <li>Хотын ачааллыг бууруулах орон нутгийн бодлого</li> </ul>